

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр, Лхагва гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-3

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 4-55

---

*1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/* 5-55

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы  
Төсвийн байнгын хорооны  
08 дугаар сарын 28-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 31 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Ганбаатар, Б.Чойжилсүрэн;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Батжаргал;  
Тасалсан: Н.Алтанхуяг, Б.Батцэцэг, Ж.Ганбаатар, П.Мөнхтулга, Г.Тэмүүлэн.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн өнөөдрийн хэлэлцэх асуудалд орсон “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлгийг хэлэлцэх асуудлын дарааллаас хасах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

**Ц.Даваасүрэн:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 8  
Бүгд: 15  
46.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Ганзоригийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ц.Даваасүрэн:** Улсын Их Хурлын гишүүн П.Ганзоригийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 5  
Бүгд: 15  
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 5  
Бүгд: 15  
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр**

*өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хургүүлнэ/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер П.Чанцалдулам, Б.Лхагвацэнд, Б.Долгорсүрэн, ахлах аудитор П.Амарсанаа, Э.Энхбаатар, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, аудитын менежер Ю.Энхтуяа, ахлах аудитор У.Оюунхүү, аудитор Б.Идэрбалжинням, Д.Нямжаргал, Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин, мөн банкны ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн А.Энхбат, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Н.Мандуул, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Идэрцогт, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Төлбөр, тооцооны хэлтсийн дарга В.Рэнцэнханд, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Алтанхорол, Б.Баяр-Эрдэнэ, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Т.Хонгор, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл, Гаалийн ерөнхий газрын Татвар, орлогын газрын дарга С.Баярмаа, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Б.Мөнгөн-Аргамж, мөн хэлтсийн референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Г.Дамдинням, Б.Мөнхсоёл, Д.Батбаяр, Д.Энхтүвшин нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, мөн яамны Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төлбөр, тооцооны хэлтсийн дарга В.Рэнцэнханд, Гаалийн ерөнхий газрын Татвар, орлогын газрын дарга С.Баярмаа, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар хариулж, тайлбар хийв.

*Асуултад хариулах албан тушаалтнуудыг хуралдаанд хүрэлцэн ирэх хүртэл хуралдаан 12 цаг 05 минутаас 14 цаг 05 минут хүртэл завсарлав.*

Илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан, П.Ганзориг, Б.Түвшин, Р.Батболд, Дав.Цогтбаатар, Д.Батлут, Т.Аубакир, Ц.Даваасүрэн нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин, мөн банкны ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн А.Энхбат, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Н.Мандуул, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Идэрцогт, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Б.Мөнхсоёл, Б.Түвшин, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 3 цаг 42 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 13 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим  
10 цаг 31 минут.

### ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ц.Даваасүрэн:** Төсвийн байнгын хорооныхоо хурлыг эхэлье. 1 хүн дутуу байгаад байгаа юм уу? 1 гишүүн ороод ирэнгүүт эхэлье. Баясгалан гишүүн нэг яачих юм уу? Баясгалан гишүүн орчихоор тэгээд болчхож байгаа юм байна. Тэгээд хэдүүлээ хурлаа эхэлье. Хоёрхон асуудал юм байна. Гишүүд бүртгүүлчихье, сая орж ирсэн гишүүд, тэгээд хурлаа эхэлье.

Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд ирвэл зохих ёстой 25 гишүүнээс 13 гишүүн ирж, 52 хувийн ирцтэй байна. Би ирсэн гишүүдийг танилцуулъя. Миний бие оролцож байна. Алтанхуяг гишүүн одоогоор алга байна. Аубакир гишүүн ирсэн байна бүртгүүлчих, би нөгөө зарлаж байгаа учраас. Саяын ирсэн гишүүдийг тэмдэглэчих. Батболдыг бичсэн юм уу. Норовын Алтанхуяг гишүүн алга байна. Тилеуханы Аубакир гишүүн ирсэн байна, Далайн Батбаяр гишүүн ирсэн байна, Ринчиндоржийн Батболд гишүүн ирсэн байна, Жигжидийн Батжаргал гишүүн өвчтэй байгаа гэсэн үү? Дамбын Батлут гишүүн ирсэн байна. Батмөнхийн Батцэцэг гишүүн одоогоор алга байна. Жадамбаагийн Баясгалан гишүүн ирж яваа гэж байна. Хөххүүгийн Болормаа ирсэн байна. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн ирсэн байна. Жамбалын Ганбаатар гишүүн одоогоор бүртгүүлээгүй байна. Гомбын Ганбаатар гишүүн юу гэж байгаа юм бэ энэ, ОНТ, орон нутагт томилолттой яваа юм байна. Пүрэвжавын Ганзориг гишүүн ирсэн байна. Хассуурийн Ганхуяг гишүүн

ирсэн байна. Гонгорын Дамдинням гишүүн ирсэн байна. Батжаргалын Заяабал гишүүн одоогоор бүртгүүлээгүй байна. Баатаржавын Мөнхсоёл гишүүн ирсэн байна. Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн одоогоор алга байна. Загджавын Мэндсайхан гишүүн бүртгүүлсэн байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн бүртгүүлсэн байна. Банзрагчийн Түвшин гишүүн бүртгүүлсэн байна. Тэмүүлэнгийн Ганзориг, Ганзоригийн Тэмүүлэн гишүүн одоогоор алга байна. Даваагийн Цогтбаатар гишүүн алга байна. Чойжилсүрэн гишүүн гадаад томилолттой. Ингээд ирц 56 хувьтай байгаа учраас өнөөдрийн хуралдаанаа эхлүүлъя.

Байнгын хорооны 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Байнгын хороогоор 2 асуудал хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Монгол Улс нэгдүгээрт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл хоёр дахь хэлэлцүүлэг. 2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэд хороо, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай Төсвийн байнгын хорооны тогтоол гэсэн ийм 2 асуудал байгаа юм.

Хэлэлцэх асуудалтай холбогдоод санал хэлэх гишүүн байна уу? Санал хэлэх гишүүн алга байна уу? Цогтбаатар гишүүн ирцэд орж ирж бүртгүүлж байна. Энэ 2 дахь асуудал дээр би санал гаргая. Гишүүд бас дэмжвэл би энэ асуудлыг хасуулчихъя гэж бодоод байгаа юм. 5 дахь өдөр чуулган хаагдана. Ажлын хэсэг байгуулахаар ерөөсөө ганцхан

маргааш шүү дээ, ямар ч хэрэг байхгүй болчихоод байгаа гүйцэтгэл дээр. Тийм учраас би горимын санал гаргаад хоёр дахь асуудлыг хэлэлцэх шаардлагагүй гэдэг ийм горимын саналаар санал хураалгачихъя, дэмжээд энэ 2 дахь ажлын хэсэг байгуулах тухай асуудлыг хасаад явчихъя. Тэгэхдээ ер нь болбол төсвийн гүйцэтгэлийг голлож хэлэлцдэг дэд хороо Зарлагын хяналтын дэд хороо юм байгаа юм. Тэгэхээр хэдүүлээ бол энд ажлын хэсэг байгуулахгүй явчихъя.

Би нэг горимын санал гаргаад энэ 2 дахь асуудлыг хэлэлцэхгүй гэсэн ийм горимын санал гаргаж байна. Дэмжиж байгаа гишүүд. Санал хураалт. Төхөөрөмж гацсан байна. Хэн Ганзориг гишүүн хэлэх юм уу? Ганзориг гишүүний микрофоныг өгчихье.

**П.Ганзориг:** Энэ төхөөрөмж гацчихлаа. Тэгээд саяын явуулсан саналыг хүчингүй болгож өгнө үү гэдэг горимын санал гаргаж байна.

**Ц.Даваасүрэн:** Тэгвэл Ганзориг гишүүний гаргасан горимын саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалтыг хүчингүйд тооцъё. Техникийн алдаа гарч байна шүү. Дахин санал хураалт явуулъя. Ганзориг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Энийг бас хүчингүйд тооцъё. Техникийн бэлэн байдал хангая. Техникийн бэлэн байдал хангагдсан болов уу манай ажил манай Тамгын газрынхан? Зүгээр үү, манайхан бэлэн үү? Горимын саналаар санал хураалт явуулъя. Горимын санал 66,7 хувиар дэмжигдсэн байна.

Эхний санал хураалтыг хэлэлцэх асуудлын 2 дахь асуудлыг хасъя гэдэг санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. Зөвшөөрсөн нь дээр. Санал хураалтад 15 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 66,7 хувийн саналаар уг санал дэмжигдсэн байна. Ингээд 2 дахь асуудал хэлэлцэхээс хасагдлаа. Хэлэлцэх асуудалдаа орно.

**Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг эхэлъе. Хаагдчихаад байна. Ажлын хэсгийн, яагаад байх юм. Ажлын хэсгийг танилцуулъя. Энэ Жавхлан гишүүнийг оруулж ирэхгүй бол Жавхлан гишүүн нөгөө танилцуулга хийх байх шүү.

Жавхлан гишүүн, Болдын Жавхлан, Сангидоржийн Баярмаа Гаалийн ерөнхий газрын Татварын орлогын газрын дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын Ерөнхий газрын Татварын хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, энэ гааль, татварын дарга нар нь ирчхэж болдоггүй юм уу? Гүйцэтгэл хэлэлцэж байхад. Энэ дарга нарыг нь дууд. Ер нь дэгээрээ бол байна шүү дээ энд чинь төсвийн ерөнхийлөн захирагч, дэд сайд байхгүй болчихсон ийм улсууд оролцох ёстой. Одоо бүүр сүүлдээ хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, зөвлөх арай дэндүү хариуцлагагүй болж эхэлж байна. Тийм учраас энэ Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газрын дарга нарыг дууд. Энэ төсвийн гүйцэтгэл хэлэлцэхэд оролц, яаралтай дуудна шүү.

Үндэсний аудитын газрын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав, Ядамьн Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн



Энхболд Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Юрагийн Энхтуяа Аудитын газрын аудитын менежер Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрынх юм байна. У.Оюунхүү Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Б.Идэрбалжинням Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитор, Д.Нямжаргал Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитор, П.Чанцалдулам Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Б.Долгорсүрэн Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер, П.Амарсанаа Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Э.Энхбаатар Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор,

Бэлтрэгийн Цогбадрах Төрийн сангийн газрын дарга, Лувсандоржийн Сонор Санхүү бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Жамъяншиаравын Дэлгэржаргал Санхүү хөгжлийн хөрөнгө оруулалтын газрын дарга, энэ улсууд байгаа юу Сангийн яамны? Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Энхтөрийн Батмөнх Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Лувсанвандангийн Ичинноров Төсвийн орлогын хэлтсийн дарга, ажлын хэсгийн бүрэлдэхүүнээ бүгдийг нь оруулна шүү. Солонгын Тулга Санхүү хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Нарангийн Мөнхсүх Төрийн сангийн газрын санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Өрийн удирдлагын хэлтсийн Гантогтох дарга, Булганхүүгийн Ганзориг Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Ванчингийн Рэнцэнханд Төрийн сангийн газрын Төлбөр тооцооны хэлтсийн дарга, Мэндээгийн Алтанхорол Төрийн сангийн газрын Санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Баясгалангийн Баяр-Эрдэнэ Төрийн сангийн газрын санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Түмэнбаярын Хонгор Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө

оруулалтын газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн гэсэн ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүн байгаа юм байна. Цаашидаа ажлын хэсгийг яахдаа гол, гол албан тушаалтнуудаар яагаад энэ бусад ахлах мэргэжилтэн энэ тэр гэсэн юмнуудыг ажлын хэсэгт оруулахгүй шүү. Туслалцаа л үзүүлнэ биз, энэ чинь хариулах эрхгүй шүү дээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх илтгэлийг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайд, Жавхлан сайд яачхав? Тэгээд яах юм бэ хойшлуулах юм уу хурлыг? Тийм, орлуулах сайд нэг сайд нь орлодог шүү дээ. Тэгээд нэг бол тэрийгээ дууд. Тийм Жавхлан сайдыг харин орлодог сайд нь хэн юм бэ? Тэгээд тэр сайдыгаа дуудаад. 10 минут хүлээе, 10 минут хүлээгээд байхгүй бол хурлыг хойшлуулъя. Тэгвэл түр хүлээж байх хооронд Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Монгол Улсын Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. Загджав гишүүний микрофон, 5 номерын микрофоныг өгье. Загджав даргын микрофоныг.

**Д.Загджав:** Та бүхэнд энэ өглөөний мэнд хүргэе. Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрх, Төсвийн тухай хуулийн дагуу Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын

үр дүнд хийсэн аудитын талаар товч танилцуулъя.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланд 227 тайлан нэгтгэснээс 104 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, нэг байгууллагад байгууллага аудитад хамрагдаагүй. 122 байгууллагыг аудитын түүвэрт хамрууллаа. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй харьяа 96 байгууллагад өөрчлөлтгүй, 8 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 25,8 тэрбум төгрөгийн 161 зөрчил илэрснээс 25,8 сая төгрөгийн зөрчилд 20 төлбөрийн акт тогтоож, 11,8 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 62 албан шаардлага хүргүүлж, 4,2 тэрбум төгрөгийн зөрчилд 94 зөвлөмж өгч, 14,4 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 5 албан шаардлагыг хүргүүлсэн байна.

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 297,6 тэрбум төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 296,9 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 0,7 тэрбум төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх талаар 8 зөвлөмж өгч ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийгмийн, нийцлийн асуудлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 194,5 тэрбум төгрөгийн 62 зөрчил бусад хууль тогтоомжтой холбоотой 34,4 тэрбум төгрөгийн 37 зөрчилд нийт 228,9 тэрбум төгрөгийн 99 зөрчил илэрсэн байна. Үүнээс 154,5 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 39 албан шаардлага, 57,5 тэрбум төгрөгийн зөрчилд 53 зөвлөмж өгч, 16,9 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 7 албан шаардлагыг хүргүүлсэн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 451 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 201,9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 6 төсөл

арга хэмжээ, хэмжээг төлөвлөсөн. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл 62 хувьтай хэрэгжсэн байна.

Тус Байнгын хороо аудитын дүн дүгнэлтээс үндэслэн дараах асуудлуудыг анхаарал хандуулахыг зөвлөж байна. Зээл, буцалтгүй тусламжийн гэрээний хугацаа дууссан, дамжуулан зээлийн болон шүүхийн маргаантай төсөв, төсөл, хөтөлбөрийн нэгжийн данс бүртгэлд тусгасан хөрөнгийг эзэмшигч, ашиглагч байгууллагад шилжүүлж, дуусгалтын тайланг бэлтгэж, төслийн хаалтыг хийж, үр дүнг үнэлж байх.

2, дараагийн дугаарт төслийн хэрэгжилт хангалтгүй, үр дүн дүнг үнэлээгүй, төслийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг эзэмшигч байгууллага данс бүртгэлдээ тусгаагүй, гадаад зээлийн эх үүсвэртэй төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлэхгүй хугацаа сунгадаг, төслийг хэрэгжүүлэгч, захиалагч байгууллагаас тавих хяналтыг сайжруулах зэрэг зөрчлийг арилгах, төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын дүгнэлтийг тоймлон товчлон танилцуулж дууслаа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Загджав даргад баярлалаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 23 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 23 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх илтгэлийг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, ЗГХЭГ-ын дарга Учрал танилцуулна. Учрал сайдын микрофоныг өгье.

**Н.Учрал:** Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв



байгууллагаар аудит хийлгэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан билээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2023 онд 23,3 их наяд төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 22,5 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2,2 их наяд төгрөгийн алдагдалтай төлөвлөгдсөнөөс 785,9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан ба сүүлийн жилүүдэд дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар буурууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд тус Байнгын хороонд харьяалагдах Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Үндэсний аудитын газар, Сангийн сайдын багцын нийт 218 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан нэгтгэн гаргасан болно. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 3,7 их наяд төгрөгийн гүйцэтгэл гарч, үүнээс урсгал зардалд 2,3 их наяд төгрөг, хөрөнгийн зардалд 1,2 их наяд төгрөгийг зарцуулсан байна. Нийт зарлага болон цэвэр зээлийн дүнгийн 97,4 хувь буюу 3,6 их наяд төгрөгийг Сангийн сайд, 1,8 хувь буюу 66,4 тэрбум төгрөгийг Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, 0,8 хувь буюу 28,6 тэрбум төгрөгийг Үндэсний аудитын газрын зарлага эзэлж байна. Улсын төсвөөс 2,3 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгосон бол төсөвт байгууллагын өөрийн орлогоор 1,2 их наяд төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлт болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй

танилцаж, Төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Учрал сайдад баярлалаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан, аудитын дүгнэлттэй холбогдуулаад асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя. Цогтбаатар гишүүн, Батболд, нэрээ өгнө, Мөнхсоёл орчихсон. Соронзонболд. Ингээд Соронзонболд, Ганзориг, болж байна уу гишүүдээ, болчихсон уу? Ганзориг гишүүнээр тасаллаа. Ганхуяг гишүүн асуултаа асууя.

**Х.Ганхуяг:** Хэд хэдэн асуулт байна. 1 дүгээрт төсвийн гүйцэтгэлийг цаашидаа бид нар ийм яаралтай горимоор биш арай нэг жоохон хугацаа эд нар тавьж байгаад хэлэлцдэг, хардаг, ярилцдаг баймаар байна. 1 дүгээр асуулт болохоор ЭМД-ын сантай холбоотой асуулт байна. ЭМД-аас яг хэдэн хувь нь эрүүл мэндэд зарцуулагдсан, хэдэн хувь нь амралт, сувилалд зарцуулагдсан энийг тоогоор хэлээд өгөх боломж байна уу Аудитын газраас асуух гэсэн юм. Янз янзын төсөл хөтөлбөрт бас хэрэгжүүлсэн сангийн зарцуулалт нь хэд байсан юм бэ энийг нэг асуучихмаар байна. Энэ яагаад асуугаад байна вэ гэхээр бид нар ЭМД-ын ерөнхий газраас энэ санхүүжилт гарахаа больчихсон байна. Тэгээд бид нар энэ хүмүүсээ эрүүл мэндэд нь биш, дандаа амралт, сувилалд нь голцуу мөнгө гараад байдаг. Өмнөх сангуудын зарцуулалттай холбоотойгоор энийг асуугаад байгаа юм шүү?

2 дугаар асуудал болохоор энэ ЭМД-ын сан, нийгмийн даатгалын сан гээд нийтдээ бараг 100 гаруй тэрбум төгрөг энэ Чингис Хаан банк дээр байршуулсан байгаа юм. Энийг хэзээ, яаж олж авах вэ? Хэн энийг хариуцлагыг нь

хүлээх вэ? Найдваргүй зээл болгоод бүртгэгчхсэн, хойноос нь явдаг хүн амьтан байна уу, үгүй юү?

3-д болохоор энэ Боловсролын зээлийн сан гээд ноднин жил бас нэлээн бид нар бас асуудал болсон. Яг энэний зарцуулалт ер нь яг тэр хуулийн дагуу явж байна уу, үгүй юү? Хэчнээн хүн энэ боловсролын зээлийн сангаас одоогийн байдлаар мөнгө авсан байна, найдваргүй авлага хэд байна вэ? Энийг нэг хэлээд өгмөөр байна.

Өмнөх энэ 23 оны төсөвтэй холбоотойгоор тендергүй зарцуулалт гэдэг мэдээлэл энэ олон нийтийн сүлжээнд нэлээн яваад байна л даа. Тэгэхээр яг аль аль яам дээр, хэдэн төгрөгийн төсөв тендергүй зарцуулагдсан байна гэдгийг нэг мэдээлэл өгмөөр байна.

Мөн илрүүлсэн зөрчлүүд гээд энэ аудитын тайлангаар дүүрэн зөрчлүүд. Тэгээд энэ илрүүлсэн зөрчлүүдтэй холбоотойгоор яг ямар, ямар арга хэмжээ авч байгаа юм бэ, төсвийн ерөнхийлөн захирагчид ямар арга хэмжээ авсан, цаашидаа ер нь анхааруулах тал дээр юу юу байх вэ гэдгийг би бас Аудитын газрын даргаас асууж баймаар байна.

Тэгээд гайхируулж байгаа нэг асуудал байна л даа. Энэ гадаадын зээл тусламжийг дамжуулаад хувийн хэвшилд олгочихсон, ТӨК-д олгочихсон асуудал бас энэ дээр нэлээн өндөр дүнтэй юм явж байх юм. Бэрэн группэд нийтдээ 239 тэрбум төгрөг олгочихсон байх юм. Энэний эргэн төлөгдөх асуудал ер нь ямар шатанд яваа юм бэ энэ тал дээр мэдээлэл авчихмаар байна. Тэгээд энэ олон жилийн насжилттай энэ зээлүүд их байна төрийн өмчийн компаниудад олгочихсон. Тэгээд энэ дээр яг төр нь ингээд хувийн хэвшилтэйгээ өрсөлддөг. Тэгээд ингээд нөгөө төсвөөс мөнгө авчихдаг, зээл болгож авдаг, тэгээд тэрийгээ эргэж төлдөггүй. Энэ чинь бол нэлээн газар авчихсан байна шүү дээ. Энэ дээр ер нь яг

ямар арга хэмжээ авах вэ гэдгийг надад нэг. Энэ асуултууддаа хариулт авчхаад, дахиад тодруулж асууя даргаа.

**Ц.Даваасүрэн:** ЭМД-ын сантай холбогдолтой асуултыг аудитаас асуусан уу? Аудитыг аудитаас, ЗГ-ын гүйцэтгэлийн тайланг ЗГ-аас гэсэн юм байна дэгээрэй. Загджав даргаа.

**Д.Загджав:** Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Ер нь ЭМД-тай холбоотой энэ аудит хийгдсэн асуудлыг энэ харьяалах Байнгын хороон дээр тодорхой бас хариулах юм дэлгэрэнгүй. Энэ дээр бас тодотгож асууя гэвэл манай энэ гүйцэтгэлийн аудитаас хариулна. Зүгээр бид бүхэн энэ аудитаар илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээ хуулийн хүрээнд аваад л явж байгаа л даа. Энэ дээр бол зөвлөмж, албан шаардлага, акт тогтоохоос эхлүүлээд л бүх л ажлаа хийгээд л явж байгаа.

**Ц.Даваасүрэн:** Нэм, нэм, арай тодорхой хариулъя. 6, арай ерөнхийдчихлөө. 6, 6 номерын микрофоныг өгье.

**Ц.Наранчимэг:** Ганхуяг гишүүний асуултад хариулъя. ЭМД-ын сан болон Боловсролын зээлийн сангийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар хязгаарлалттай гэсэн санал, дүгнэлтийг өгсөн байгаа. ЭМД-ын сан тайлант онд гүйцэтгэлээр эрүүл мэндийн байгууллагуудад олгох тусламж, үйлчилгээний санхүүжилтэд 1,4 их наяд төгрөг, эмийн хөнгөлөлтөд 80 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардалд 10,3 тэрбум төгрөг, шимтгэлийн илүү төлөлтийн хүүд 0,3 төгрөг зарцуулсан. Эрсдэлийн санд бол Улсын Их Хурлаас 40 тэрбум төгрөгийг ЭМД-ын эрсдэлийн санд баталж өгсөн байгаа. Нийтдээ 1,6 их наяд төгрөгийн төсөвт зарцуулсан. Нийт төсвийн 85-аас 87 хувь нь болбол яг ЭМД-ын үйлчилгээний чиглэлд зарцуулж байгаа. Боловсролын зээлийн сангаас олгож байгаа энэ зээлийн асуудал дээр бол.../үг тасрав/

**Ц.Даваасүрэн:** Тэр эрүүл мэндийн нөгөө сангаас даатгалын сангаас ингээж асуугаад байгаа шүү дээ ЭМД-ын эмчилгээ чиглэлдээ хэдийг нь явсан юм бэ, амралт сувилалд хэдийг нь явчихсан юм бэ гээд яг тодорхой асуугаад байгаа байхгүй юу.

**Ц.Наранчимэг:** ЭМД-ын сангийн нийт хөрөнгийн 85 хувийг нь яг эмчилгээ чиглэлдээ зарцуулж байгаа. Яг амралт, сувилалд гэдгийг нь салгаж танд хүргүүлье. Бид нар нөгөө яг энэ удаагийн Байнгын хороонд болбол харьяалагдах Байнгын хорооных нь төсвийн ерөнхийлөн захирагчдын мэдээлэлтэй ирсэн учраас энийг танд яг салгаад тодорхой мэдээллийг хүргүүлье гэж ингэж бод ж байна.

ТӨК-удын авч байгаа энэ урт хугацаатай яг гадаад эргэн төлөгдөх зээл төлөгдөхгүй байгаа өглөг авлагуудаар төрийн аудитын байгууллага аудит хийгээд, санхүүгийн тайлангийн аудитыг баталгаажуулахдаа 3 дүгнэлтийг өгч байгаа. Эрсдэлтэй буюу барагдахгүй байгаа авлага, өглөгөөр бол аудитыг санхүүгийн тайланг баталгаажуулахдаа энэ тоо бол эрсдэлтэй.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Тэр ЭМД-ын юугаар эрүүл мэндийн даатгал ЭМЯ холбогдох яамнаас нь хариулах хүн байна уу? Холбогдох яамнаас нь тодруулаад өгчих, яг тодорхой амралт, сувилал энэ чиглэлд хэдэн төгрөг зарцуулсан бэ гэж байна. Хариулах хүн байна уу? 3 номерын микрофон, Цогбадрах хариулах уу? Танай дээр ямар тоо ирсэн байна вэ?

**Б.Цогбадрах:** Та бүхэндээ өглөөний мэнд хүргэе. Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Цогбадрах. 2023 онд бол ЭМД-ын сангаас бол 111 улсын эмнэлэгт 860,7 тэрбум төгрөг, 231 хувийн эмнэлэгт 217,2 тэрбум төгрөг, 328 сумын эрүүл мэндийн төвд 175,8 тэрбум төгрөг, 216 өрхийн эмнэлэгт

171,8 тэрбум төгрөг, 1565 эмийн санд 89,9 тэрбум төгрөг, 50 лабораторид 36 аравны эрт илрүүлгийн 36,8 тэр тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

**Ц.Даваасүрэн:** Амралт, сувилалд гээд байна шүү дээ. Мөнхсүх хариулах юм уу? Нийгмийн хамгааллын яамнаас хүн байна уу, энэ гэр бүл төлөвлөлтийн яам гээд байгаа билүү, байна уу? Энэ яамнаас холбогдох хүнийг нь дуудъя. Бусад асуултад нь хариулъя. Сангийн яам. 4 номерын микрофон дээр очоод хариулъя.

**С.Тулга:** Сайн байна уу. Сангийн яамны хэлтсийн дарга Тулга. Ганхуяг гишүүний Бэрэн групптэй холбоотой асуултад хариулъя. Энэ төслийг 1000 биш юу 2012 онд БНХАУ-ын 239,2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Сангийн яам болон тухайн үед Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулсан. Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам цаашаа Бэрэн групптэй 173,6 тэрбум төгрөг, Цагаан хуаран Консалтинг ХХК-тэй 65,6 тэрбум төгрөгийн дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулаад, өр авлагын аливаа маргаан үүссэн тохиолдолд арбитрын шүүхээр шийдвэрлэнэ гээд тухайн хувийн хэвилийн ААН-үүдтэй гэрээ байгуулчихсан байгаа. Тэгээд Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын тухайн үеийн нэрээр одоо хүртэл энэ 2 байгууллагатай арбитрын маргаан үүсгээгүй ингээд яваад ингээд хугацаа хэтэрсэн авлагад бүртгэгдээд явж байгаа ийм зээл байгаа.

**Ц.Даваасүрэн:** Дутуу байна. Алив тэр гүйцэд хариулъя даа. Тэр, тэрэн дээр нь нэмэлт хариулт 4 номер. Сангийн яам шийдвэр гаргаж өгсөн юм уу гэж байна.

**С.Тулга:** Энэ 2012 онд Сангийн яам Барилга, хот байгуулалтын яаманд Хятадаас авсан зээлээ дамжуулж зээлдүүлсэн ийм зээлийн гэрээ байгуулсан. Зам, тээврийн яам нь цаашаа Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам нь цаашаа 2 хувийн хэвилийн ААН-тэй

байгуулсан байгаа. Ерөнхийдөө бол зээлийн ерөнхий хэлэлцээр гадна талаас авч байгаа зээлийг бол Улсын Их Хурлаар батлуулсан байгаа. Энэ нь өөрөө арилжааны шинж чанартай эдийн засгийн үр ашигтай зээл учраас энийг бол дамжуулах үүрэгтэй байдаг Өрийн удирдлагын хуулиар. Нийгмийн шинж чанартай биш. Түүнийг бол ингээд цаашаа харьяалах яам руу нь төслийнх нь ач холбогдолтой уялдуулаад дамжуулсан байгаа.

**Ц.Даваасүрэн:** Тодруулах юм уу? Ганхуяг гишүүн тодруулъя.

**Х.Ганхуяг:** Тэр амралт, сувилалтай холбоотой асуулт дээр яг тодорхой хариу өгчихмөөр байх юм. Тэгээд сувилалтай бол, сувилалд бол энэ ЭМД-аас гээд мөнгө авдаг шүү дээ. Тэгээд асар олон хүн, олон улс төрч нар эрүүл, сувилалд явуулдаг. Тэгсэн мөртөө эрүүл мэнд дээр болохоор эмчилгээ дээр болохоор мөнгө байхгүй, мөнгө дутаад байна гээд байдаг. Энэ дээр би нэг тодорхой хариулт авчихмаар байна.

2 дугаар асуулт энэ тендергүй зарцуулалт гээд би маш тодорхой асуулаа шүү дээ. Ямар төсөл, хөтөлбөр тендергүйгээр зарцуулсан тийм юм байгаа юм уу? Энэ чинь сошиалаар бол аягүй олон асуудал яригдаад л яваад байх юм. Тухайлбал хагас коксжих нүүрсний үйлдвэр гээд гээд явж л байна, соёлын, спортын арга хэмжээнүүд гээд явж л байна. Тэгээд энэ дээр аудитаас илрүүлсэн юм байдаггүй юм уу?

3 дугаар асуудал байна. Та нар энэ Бэрэн дээр ЗГ-ын баталгаа гаргаад л өгчихсөн байна шүү дээ. Та нар Их Хурлаар оруулсан л гээд байх юм. Яг хувийн хэвшилд гаргаж өгнө гэдэг асуудал дээр ЗГ хэлэлцсэн юм байдаг юм уу? Тэгээд ийм зөрчлүүд дээр яг ямар арга хэмжээ авдаг юм бэ? Яг тухайн үед энэ асуудалд оролцсон хүмүүс дээр ямар нэг арга хэмжээ авсан юм байгаа юу гэдэг асуултыг асуугаад байгаа юм.

Тэгээд энэ олон жилийн насжилттай төрийн өмчийн компаниудаас авах энэ авлагууд дээр яг ямар арга хэмжээ авч байгаа вэ? Сангийн яам бол энэ улсын төсвийн зарцуулалт дээр хяналт тавиад явж байх ёстой газар шүү дээ. Аудит шалгаад, энэ зөрчлүүдийг илрүүлээд явж байна. Хэн нь хариуцах юм бэ, хэн нь хариулах юм бэ? Холбогдох Байнгын хороонд өгчихсөн л гээд байх юм. Бид нарт яагаад өгөхгүй байгаа юм бэ мэдээллийг? 25 оны төсөв барихад чинь энэ саяын ярьсан асуудлуудыг бид нар болохгүй бол засах эрх нь бид нарт байгаа шүү дээ. Хасах эрх нь. Та нар хариулдаггүй юм бол хасагдаад л явна гэсэн үг шүү дээ энэ чинь. Төрийн мөнгө чинь үнэгүй мөнгө болчихсон юм уу? Яагаад ийм.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Сангийн яам хариулъя. Тэр өр зээлтэй холбогдолтой асуудлууд. Тэгээд тэр Зам, тээвэр, барилгын яам гэж байсан үед юм уу, тийм үү? Тэр яамнаас нь хүн байна уу? Байхгүй юу. Барилгын яамнаас хүн байна уу? Сангийн яам хариулъя. 4 номерын микрофоныг өгье. Чи нэг жосохон тодорхойдуу хариул л даа. Тэр нь төлөлттэй байгаа юм уу, төлөлтгүй байгаа юм уу, юу болоод байгаа юм бэ, дамжуулан зээлдэх гэрээ нь хэн нь хэнтэйгээ байгуулсан юм бэ тэрийг нь тодорхой хэлээч?

**С.Тулга:** Ойлголоо. Ганхуяг гишүүний асуултад тодруулж хариулъя. Дамжуулан зээлдэх гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдэх гэрээ байгуулна гэдэг нь Улсын Их Хурлаар гаднаас зээл авахаар шийдвэрлэсэн энэ зээл нь хэрвээ тэр зээлийн шинж чанар нь арилжааны шинж чанартай байх юм бол, ашиг олох чанартай байх юм бол энийг бол зайлиггүй дамжуулдаг байгаа. Төслийн шинж чанартай нь уялдуулаад. Тэгээд энэ нь бол байшин барих ийм зээл байсан учраас дэд зээлдэгчээр нь Барилга, хот байгуулалтын яам.../үг тасрав/



**Ц.Даваасүрэн:** Санхүүгийн зээл биш төслийн зээл байжээ гэж ойлгоё тийм үү?

**С.Тулга:** Дамжуулан зээл.

**Ц.Даваасүрэн:** Биш ээ биш.

**С.Тулга:** Анх авахдаа төслийн зээл.

**Ц.Даваасүрэн:** Төслийн зээл. Төслийн алдагдал нөхөх санхүүгийн зээл биш байсан байна шүү дээ, тийм үү?

**С.Тулга:** Тийм яг зөв.

**Ц.Даваасүрэн:** Тэгж тодорхой ярь л даа чи.

**С.Тулга:** Тэгээд тухайн төсөл нь өөрөө байшин бариад, ашиг олох боломжтой ийм шинж чанартай төсөл байсан учраас Засгийн газар энийг бол дамжуулан зээлдэг. ЗГ дамжуулан зээлэхдээ БХБЯ-тай дэд зээлдэгчээр дамжуулж зээлж байгаа. Эцсийн зээлдэгч нь болохлоор Бэрэн болон Цагаан хуаран байгаа. Дэд зээлдэгчийн үүрэг нь юу вэ гэхээр яг эцсийн зээлдэгчтэй адилхан дэд зээлдэгчийн эргэн төлөлтийг хариуцах ийм үүрэгтэй байдаг. Сангийн яам, төрийн өмчийн компани, орон нутаг, яамнуудтай бүгдтэй нь ингээд төслийн шинж чанартай нь холбогдуулаад дамжуулан зээлийн гэрээ байгуулдаг. Дэд зээлдэгч нь эргэн төлөлт дээр бүрэн хариуцлага хүлээдэг.

**Ц.Даваасүрэн:** Тендергүй төслийн хэмжээ хэд вэ, хэдэн ширхэг вэ, ямар үнэ дүнтэй вэ гэдэг дээр Сангийн яам хариулъя. Загджав дарга, 5 номерын микрофоныг өгье.

**Д.Загджав:** 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 7 их наяд 376,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 1139 төсөл, арга хэмжээг төсөвлөсөн байгаа. Энэ бүгд дээр бас гүйцэтгэлийн аудит хийж үзсэн. Энэ дээр бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ,

төрийн болон орон нутгийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны журам хууль зөрчиж ингэж тендергүй зарласан юм бол байхгүй байгаа. Харин зүгээр энэ дээр бол улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгцээ шаардлага, тэргүүлэх асуудал, эдийн засгийн үр өгөөжөөр нь эрэмбэлээгүй, санхүүжилтийг хэрэгжих хугацаатай нь уялдуулж төлөвлөөгүй, хэрэгжилтэд нь тулгарсан асуудлыг шийдвэрлэх хугацаа, цаг дараалал нь тодорхойгүй, гэрээний хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаа ийм зөрчлүүд гарсан.

Энэ дагуу бид төсвийн ерөнхийлөн захирагчид 11 зөвлөмж өгч, илэрсэн зөрчил нь 8 тэрбум гурван зуун 249,9 сая төгрөгийн 11 төлбөрийн акт тогтоож, 28 тэрбум 615,4 сая төгрөгийн 15 албан шаардлагыг хүргүүлж ажилласан. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог үнэлэх, барилга байгууламжийн зураг төсөл, гүйцэтгэлд илэрч байгаа нийтлэг зөрчил, тулгарч буй асуудалд судалгаа шинжилгээ хийж, эрх зүйн орчныг сайжруулах замаар хөрөнгө оруулалтыг.../үг тасрав/

**Ц.Даваасүрэн:** Энэ асуух асуулттай гишүүдийн нэрсийг ирцээр нь урагшлуулаарай. Ирцээр нь болгоорой.

**З.Загджав:** Үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

**Ц.Даваасүрэн:** Дутуу бол нэг удаа бас болно шүү, дутуу хариулж байна гэж үзэж байгаа учраас дахиад Ганхуяг гишүүний микрофоныг өгье.

**Х.Ганхуяг:** Түрүүн би нэг асуулт асуусан, тэрийг нь бас хариулахгүй орхигдуулчихаад байна л даа. Энэ ЭМД-ын сан, нийгмийн даатгалын сангаас Чингис Хаан банк дээр нийтдээ 120 гаруй тэрбум төгрөг байршуулаад авч чадахгүй байгаа гэсэн ийм юу байна. Тэгээд энэ сангуудын мөнгийг нь банкнууд дээр байршуулаад



яваад байдаг. Тэгээд миний санаж байгаа нь Чингис Хаан банк, Капитал банк гээд олон банкнууд холбогдсон байдаг. Тэгээд эд нараас мөнгө төгрөгөө ер нь олж авч чадсан эсэхийг нь бас нэг тодруулаад асуучих юм уу?

2 дугаарт одоо байгаа чөлөөт үлдэгдлээ аль банкнууд дээр байршуулж байгаа, энэ дээр Сангийн яамнаас ямар нэгэн зөвлөмж гаргадаг эсэх. Энэ Чингис хаан банкин дээр ингээд 120, 30 тэрбумыг нь аваачаад тавьчихдаг, байршуулчихдаг нь хэний ер нь зөвлөмжөөр, хэний юугаар байршуулсан бэ гэдгийг нь асуучихмаар байх юм.

**Ц.Даваасүрэн:** Цогбадрах 3, 3 номер. Та нар тэр нөгөө нэг халамжийн чиглэлээр гэх юм уу, тэр ахмадын сувилал гээд сувиллуудад хэдэн төгрөг өгсөн юм бэ гэдэг нь уг нь Төсвийн төрийн сан дээр гарсан л байгаа шүү дээ. Тэрийг нь л хэлчхээч дээ. Тэгээд саяын асуултад нэмээд тэгээд хариулчих, 3 номер.

**Б.Цогбадрах:** Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Цогбадрах. ЭМД-ын ерөнхий газар Чингис хаан банкин дээр 30,8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй. Капитал банкин дээр 78,5, 76 аравны, 78,5 тэрбум, ингээд нийтдээ Капитал болон Чингис хаан банкин дээр 109,3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа юм байна 2023 оны жилийн эцсийн байдлаар.

**Ц.Даваасүрэн:** Сувилал дээр та хэд мөнгөн дүнгээр нь хэлж чадахгүй байгаа юм уу? Нөгөө хариуцаж байгаа газрын дарга нь ирж байгаа юм байна. Тэгэхээр ирэхээр нь нэмээд тодруулчихъя. Энэ нэг Чингис банк гэж ер нь нэг дампуурчихсан мөртөө дампуурлын зарладаггүй нэг банк байна. Ийм их мөнгө шатаагаад хаячихсан эрүүл мэнд, нийгмийн даатгалынх хэд байгаа юм мэдэхгүй. Дээр нь Хөгжлийн банкны 50 тэрбум, тэгээд энэ дампуурлыг нь зарлахгүй ингээд нуугаад ингээд байгаад

байдаг энэ асуудлыг ер нь Их Хурал анхааралдаа авах нь зүйтэй байх. Дамдинням гишүүний, энэ ирцээр нь болгочхоорой. Дамдинням гишүүний. Болохгүй байгаа бол Мөнхсоёл, болчихсон юм уу.

**Г.Дамдинням:** Тэр энэ төсвийн гүйцэтгэл дээр бид нар Сангийн яамтай холбоотой, бас энэ аудиттай холбоотой асуудлууд л ярьж байгаа. Сая энэ Ганхуяг гишүүн бас асуугаад байгаа энэ асуулт энэ Чингис Хаан банк руу хамаг юу яг хэд хэдэн онуудад, ямар ямар сайдуудын үед энэ сангуудаас мөнгө орсон байдаг юм бэ? Энийг нэг онтой сартай нь, тоо хэмжээтэй нь тухайн үеийн сайд нарын шийдвэрийг нь хэлээдхээч Сангийн яамныхан. Капитал банк 2 дээр. Эзэнтэй байх ёстой шүү дээ юм. Энэ бол дампуурах нь тодорхой болчихсон банкнуудыг л тэгээд нэг ямар аргаар нь мэдэхгүй энэ улсын сангийн мөнгөнүүдийг л хийгээд ингээд дампуурлыг нь зарлахгүй таг гацааж хаячхаад байгаа байхгүй юу. Энийг асууя. Эзэнтэй нь, онтой, сартай нь хэр хэмжээгээр шилжүүлж байсныг нь, ямар шийдвэрээр.

2 дугаар асуулт энэ би өчигдөр бас чуулган дээр асууж байсан. Энэ одоо бид нар зунжингаа сайхан найрлаж, наадамлаад, шинэ Засгаа бүрдүүлээд, хоол хүнсээ хувааж аваад сайхан харру болж байгаа байх бүгдээрээ баяр баясгалантай байгаа байх. Ингээд нөгөө өвлийн утаа эхэллээ, өвлийн утаа эхэллээ. Өвлийн утаа эхлэх дөхчихсөн байдаг, шахмал түлшний үйлдвэр утаагүй түлшний үйлдвэр лүү нь хийсэн хөрөнгө оруулалтууд ямар ч эхэндээ болбол үнэхээр үр дүнтэй байсан шүү дээ. Улаанбаатарчууд энэ Монголчууд бүгдээрээ мэдэж байгаа. Одоо бол байхгүй болсон. Тэгээд энэ Эрдэнэс Тавантолгойгоос бараг 1,1 их наяд төгрөгийн зээлийг энэ Тавантолгой түли рүү хийгээд, тэгээд өчигдөр Их Хурал дээр Улаанбаатар хотын өмчлөл рүү энэ нүүрсний үйлдвэрийг нүүрс угаах энэ шахмал түлшний үйлдвэрийг шилжүүлнэ

гэхэд бас энэ хотын гишүүд блоклож байгаад өртэй нь авахгүй байхаар л шийдэж байх шиг байна лээ. Тэгэхээр энэ байгууллага дээр Үндэсний аудитын газар ер нь ажилласан юм уу? Загджав даргаа ажилласан уу? Ямар шийдвэр гаргасан бэ? Энэ ер нь ямар шатдаа яваа юм бэ? Сангийн яам тэр зээлтэй холбоотой асуудал дээр нь ер нь та нар оролцож байсан юм уу? Танай зөвшөөрөлгүйгээр тийм их мөнгийг тийшээ шийдэхгүй дээ.

Тэгээд энэ 1,6 сая хүн амтай улсын маань Нийслэлийн энэ утаатай холбоотой асуудал ард иргэдийн цэвэр, аюулгүй орчинд амьдрах энэ асуудлыг бүүр нэг их аравны 1 их наяд хэмжээнд оруулаад ингээд утгагүй болчихсон юмыг асуумаар л байна л даа би.

**Ц.Даваасүрэн:** Дамдинням гишүүний асуултад хариулъя. Эхнийх нь болохоор тэр нөгөө Чингис банк руу өгсөн зээлүүдийг хэдэн онд, ямар хүний шийдвэр өгсөн бэ гэж байна. Сангийн яам 1 номерын микрофон.

**В.Рэнцэнханд:** Төрийн сангийн газрын Төлбөр тооцооны хэлтсийн дарга Рэнцэнханд байна. Дамдинням гишүүний асуултад хариулъя. НДЕГ-ын мөнгө бол 94,9 тэрбум төгрөг Чингис хаан банканд үлдэгдэлтэй байгаа. Тэдгээрийн яг аль сайдын шийдвэрээр гэдгийг болбол хэлж чадахгүй байна. Гэхдээ энэний бол хамгийн их буюу хоёр мянга 88,9, 89 орчим тэрбум төгрөг нь бол 2011 оны 4 сарын 6-нд нээсэн данс дээр байршиж байна. 4 тэрбум төгрөг нь бол 2016 онд нээсэн данс дээр, 1,4 тэрбум төгрөг нь бол 2013 онд нээсэн данснууд дээр бол байршиж байна.

ЭМД-ын сангийн мөнгө бол 2018 оны 1 сарын 19-нд нээсэн данс дээр 30,9 тэрбум төгрөг байршиж байна. Тэгэхээр бид нар нөгөө нэг яг энэний хөдөлгөөн нь болбол харагдахгүйгээр, яг дансанд нээсэн данснууд нь бол харагдаж байна.

**Ц.Даваасүрэн:** 2 дахь нь аудит хариулъя. Загджав дарга. Тэр юу тэр бол Сангийн яамтай бол нэг их хамааралгүй. Компани хоорондын зээл учраас Сангийн яам бол тэрийг мэдэхгүй байгаа. Аудит шалгасан үгүй, үгүй, тэр би яг сайн санаад байгаа юм. Нөгөө өөрөө би яг тэр шахмал түлшний үйлдвэрийг хийгээд энэ асуудлыг шийдэхэд оролцсон учраас. Нийгмийн хариуцлагын хүрээнд нь Эрдэс Монгол компаниас татаас өгөөд явчихсан байхгүй юу. Тэгэхээр тэр компани хоорондын юм болчхоод байгаа юм. Зүгээр энэ дээр шалгалт хийсэн юм уу, энэ өр зээлийн асуудал ямар байгаа юм бэ гэж асуугаад байна. Шалгалт хийсэн, хийгээгүйгээ хэлээд л, хийсэн болбол ямаршуу нөхцөл байдалтай байна вэ? Хариулъя.

**Д.Загджав:** Дамдинням гишүүний асуултад хариулъя. Шахмал түлшний үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалттай холбоотой зүйл байна. Энэ бол Эрдэнэс Монгол биш Эрдэнэс Тавантолгойгоос оруулсан хөрөнгө оруулалт байгаа. Үүнтэй холбоотой 1,1 их наяд төгрөгийн зөрчил илрүүлээд, тэр зөрчил өөрөө гэмт хэргийн шинэ чанартай үйлдэл байгаа учраас Монгол Улсын Ерөнхий прокурорт Монгол Улсын ерөнхий аудиторын зүгээс шилжүүлсэн байгаа.

**Ц.Даваасүрэн:** Аль тэр татаас нь уу? Үгүй ээ тэгвэл наадах чинь Ерөнхий сайд тэр үед Ерөнхийлөгч байсан шүү дээ. Чи ямар хариуцлагагүй юм яриад байна. Юун гэмт хэргийн шинж чанартай байдаг юм тэр. ЗГ-ын шийдвэр гараад, Эрдэнэс Тавантолгойг нийгмийн хариуцлагынхаа хүрээнд татаас өг гэдэг шийдвэр гарсан шүү дээ. 5 номерыг. Энэ чинь Ерөнхийлөгчийгөө буруу юм хийсэн гээд сууж байх юм.

**Д.Загджав:** Тэр бол татаас биш, гүйцэтгэлийн аудитын тайланд ийм зүйл туссан байгаа. Тэгээд энэ гэмт хэргийн шинж чанартай байна гэж үзээд тэгээд хуулийн дагуу Монгол Улсын ерөнхий прокурорт шилжүүлсэн байгаа зөрчлийг.

Гэмт хэргийн шинж чанартай зөрчил байсан.

**Ц.Даваасүрэн:** Үгүй ээ чи зөв хариулаад байна уу? Үгүй ээ үгүй, энэ татаас олгох асуудлыг чинь тухайн үед ЗГ, биш ээ татаасын тухай яриад байна шүү дээ. Тийм татаас олгохыг ЗГ шийдээд л, тэгээд л татаас олгоод л явсан шүү дээ. Тэрэнд гэмт хэргийн шинж чанартай юм юу байдаг юм. Их л сонин л хариулчихлаа даа. Би бол тэгж бодохгүй байна. Яагаад гэвэл энэ тухайн үед, шахмал түлшний үнэ чинь өөрөө 2 татаастай байгаа юм. 1 дүгээрт болбол энэ төрөөс Эрдэс тавантолгой болбол үнийн зөрөөгийн татаасыг нь өгсөн. Яагаад гэвэл энэ өөрөө шахмал түлш чинь болбол гурван зуун наян, 1 тонн нь 380 мянга болчихоод байсан учраас нийгмийн хариуцлагынхаа хүрээнд тухайн үед ЗГ-аас шийдвэр гаргаад ЭТГ компани хариуцахаар ингэж шийдсэн. Мөн Энержи ресурс компани нийгмийн хариуцлагынхаа хүрээнд мидлингээ үнэгүй нийлүүлэхээр ийм л юмнууд болсон. Тэгээд энд бол би гэмт хэргийн шинж чанартай юм байна гэж бол огт харахгүй байна. Тэгээд буруу мэдээлэл яваад байх юм. Тийм, өөр юмтай эндүүрээд л, тэр ковидын юмтай л эндүүрчих шиг болох юм даа саяынхыг. Тодруулах уу? Дамдинням гишүүн.

**Г.Дамдинням:** Сангийн яам 2011 онд 80 гаруй тэрбум төгрөгийг өгч, алдаад тэгээд дараачийн жилүүдэд нь нэмж мөнгө өгөөд байдаг нь ямар учиртай юм бэ? Тэр банкнууд руу сангаасаа. Яагаад энэ мөнгөнүүдийг алдчихаад нэмээд тэр 2 банк байгаад байгаа шүү дээ энэ чинь. Чингис Хаан банк, нөгөөдөх нь нөгөө Капитал билүү, энэ 2 банк руу ингээд шилжүүлээд байдаг юм бэ? Энэ дээр нэг тайлбар өгөөч.

2 дугаарт хурлын дараа албан ёсоор яг ямар ямар шийдвэрүүдээр энэ 2 банк руу энэ төрийн санд байсан төрөл бүрийн сангаас орсон мөнгөнүүдийн дүнтэй нь, онтой сартай нь, тухайн

үеийн Сангийн сайдын шийдвэрүүдтэй нь цуг албан бичгээр хүргүүлээдхээрэй над руу албан ёсоор. Яагаад өгөөд байсан юм бэ гэдгийг нь нэг хариулаадхаач.

**Ц.Даваасүрэн:** Сангийн яам энэ 2 банк руу яагаад нийгмийн даатгалын сан, ЭМД-аас хамт байгаа юу, сангийн мөнгийг байршуулсан юм бэ гэдэг асуудал дээр. Тэгээд мэдээллийг нь гаргаж өгөөрэй.

**В.Рэнцэнханд:** Хариулъя. Нийгмийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлд болбол нөгөө нийгмийн даатгалын сангийн хуримтлалын сангийн хөрөнгийг ЗГ-ын бонд болон Монголбанкнаас гаргасан үнэт цаас худалдан авах арилжааны банканд байршуулах замаар нэмэгдүүлж болно гэсэн заалттай. Тэгээд энэ заалтын дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн шийдвэрээр арилжааны банканд ингээд байршуулаад явдаг байгаа. Тэгээд яг нөгөө хугацаатай, шийдвэрүүдтэйг болбол албан ёсоор мэдээллийг нэгтгээд гишүүнд хүргүүлъя.

**Ц.Даваасүрэн:** Уг нь энэ нийгмийн даатгалын мөнгө бол анх төрийн сан байгуулагдахдаа эрүүл мэндийн даатгалын мөнгө нөгөө төрийн сандаа байршиж явдаг байсан байхгүй юу. Тийм. Тэгсэн сүүлдээ хуулийг нь өөрчлөөд, одоо ингээд өөрсдөө аваад, тэгээд өөрсдөө аваачаад арилжааны банкин дээр тавьдаг, хүүгийн зөрөөг нь хулгайлдаг өөрсдөө шалгагдаад ингээд баларсан улс шүү дээ. Тэгж байгаад л эд нар баларсан байхгүй юу. Яг бодит байдал бол тийм. Мөнхсоёл гишүүн асуултаа асууя.

**Б.Мөнхсоёл:** 1 асуулт нь яг тэр талаар байсан. Чингис хаан, Үндэсний хөрөнгө оруулалтын банкнууд яагаад одоо хүртэл 256,6 тэрбум төгрөгийн эрсдэлтэй гэдгийг нь мэдсээр байж одоо хүртэл байршуулсаар байгаа вэ? Энэ давхацчихлаа. Тэгээд хариулт сайн тодорхой бас ирэхгүй байх шиг байна.

Тэгээд хэд хэдэн асуулт байгаа товчхон бас давхиулахгүй явахыг бодъё. Ирээдүй өв сан 2023 оны эхэнд хэдэн төгрөгийн үлдэгдэлтэй яг байсан бэ, хүүгийн орлого хэд байсан бэ гэж л асуух гээд байгаа юм л даа. Тэгээд сангийн хуримтлалыг хаана байриуулж, менежментийг нь яг хэн хийж хариуцаж байгааг мэдмээр байна.

2 дугаарт нь болохоор Монголбанк 23 онд урсгал шилжүүлэх 51 хувь нэмэгдсэн гэж байгаа шүү дээ тийм ээ? Үүн дээр голлон нөлөөлсөн шилжүүлгүүдийг бас мэдээж шалтгааныг нь хамт сонсмоор байна.

Тэгээд бас олон жилийн насжилттай төлөгдөөгүй авлага, өр төлбөр байгууллагууд дээр нэлээн байгаа нь ингээд санхүүгийн тайлангаас харагдаж байна. Эдгээр төлж, эдгээрийг төлж барагдуулах талаар ямар бодлого арга хэмжээ авч байгаа бол? Тэгээд олон улсын байгууллагуудаас Монгол Улсын төсвийн удирдлагад өгдөг зөвлөмжид зээл, тусламжаар бий болсон барилга байгууламжийг эзэнгүйдүүлдэг, хөрөнгө эзэмшигч ашиглагч, байгууллагуудад нь хүлээлгэн өгч, тэдэнд хөрөнгийн урсгал болон капитал засварыг цаг тухайд нь хийдэггүйгээс насжилт богиносож, хэрэгцээнээс хурдан гарах эрсдэлтэй байна гэж хамгийн сүүлийн бас НҮБ-ын тайланд дурдагдсан байсан.

Тэгэхээр түрүүний яг асуулттай холбогдуулаад жишээлбэл саяын гаргасан та нарын хүргэлт, хүргэж өгсөн тайлан дээр 10 гаруй төслийн энэ 534 тэрбум төгрөгийн хөрөнгийг эзэмшигч, ашиглагч байгууллагад шилжүүлээгүй байна гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэтэй холбогдуулаад бас тодруулж асуумаар байгаа юм. Ер нь бол бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Зөвхөн НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн төсөл гэлтгүй, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн хэрэгжүүлсэн нөгөө Эрчим хүчний үр ашиг төсөл байна. Ногоон юуг, нөгөө төслийнх нь нэрийг нь мартчихаж,

байшин тэр тэдгээр төслүүд юу бас зөвлөдөг вэ гэхээр аливаа бүтээн байгуулалт буюу байшин байгууламж барьж болно, сургууль, цэцэрлэг. Тэгэхдээ уурын зуух хүртэл яригдаж байгаа шүү дээ. Maintenance cost гэж ярьдаг. Нөгөө тухайн засвар үйлчилгээг нь даах зардлыг нь жил болгон тусгаагүйгээс болоод насжилт богиносдог, ашиглалт муутай, эзэнгүйддэг ийм асуудлууд байдаг. Энэ дээр бас ямар асуудлууд, аль яамнууд дээр илүү тулгарч байна вэ? Зөвлөмж байна вэ? Товчхондоо энэ хэдийг эхлээд асуучихъя гэж бодож байна. Тэгээд дараа нь тодруулаад явчихъя. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Саяын асуултад хариулъя. 4 номерын микрофон Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя.

**С.Тулга:** Сангийн яамны хэлтсийн дарга Тулга. Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Энэ нөгөө Ирээдүйн өв сантай холбоотой асуултад нь хариулъя. 2023 оны жилийн эцсийн үлдэгдлээр Ирээдүйн өв санд нийт 3,5 их наяд төгрөгийн үлдэгдэл байсан. Ирээдүйн өв санг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасны дагуу 2025 он хүртэл Сангийн яам Ирээдүйн өв сангийн үлдэгдлийг Төрийн сангийн нэгдсэн дансны удирдлагаар хэрэгжүүлж хангана гэсэн ерөнхийдөө Сангийн яам удирдана гэсэн ийм агуулгатай байгаа. Үүнээс 2025 он хүртэл Сангийн яам Ирээдүйн өв сангийн хөрөнгийг тусгаарлах үүрэгтэй. Үүнийх нь дагуу 2023 оны 12 сарын 28-ны өдөр 1,3 их наяд төгрөгийг Ирээдүйн өв сангийн Монголбанкна дахь дансанд тусгаарласан байгаа. 1,8 их наяд төгрөгийг 24 онд багтаан тусгаарлаад ингээд хуулийн хэрэгжилтийг бүрэн хангана.

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 12.1.7-д заасны дагуу тус сангийн хөрөнгийг зөвхөн гадаадад санхүүгийн хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах, тэгээд дотоодын санхүүгийн аливаа хэрэгсэлд байршуулахыг хориглодог учраас Ирээдүйн өв сан дээр бол ингээд аливаа хүү тооцох энэ асуудал



гадагшаа гаргахаас нааш хүү тооцох ийм асуудал бол байхгүй байгаа.

**Ц.Даваасүрэн:** Бусад асуусан зүйлд нь хариулт байна уу? Олон асуулт асуулаа шүү дээ. Нөхөд өө олон төрлийн л асуулт асуусан даа. Мөнхсоёл гишүүнээ болчихсон уу, тодруулах уу? Тодруулъя. Харин тийм. Үгүй ээ энэ Мөнхсоёл гишүүн чинь олон төрлийн л асуулт асуулаа даа. Тэгээд нэгхэн хариулт өгчих юм. Хөөш ингэж хариуцлагагүй хандаж болохгүй нөхөд өө. Мөнхсоёл гишүүн байна шүү дээ бүүр нэг бүрчлээд асуу, тэгээд би нэг бүрчлэн дуудна, тэгээд тэд нар хариулна шүү.

**Б.Мөнхсоёл:** Түрүүний Сангийн сайдын юу Сангийн яамны хүний хариулсан дээр тодруулахад би зүгээр зориуд асууж байгаа юм л даа. Бид нар мэдэж байгаа шүү дээ. Ирээдүйн өв сан яах гэж байгуулагдсан бэ. 2 сан байна. Төсвийн тогтвортой байдлын сан, Ирээдүйн өв сан. Ирээдүйн өв сангийн гол зорилго нь байгалийн баялаг хязгаарлагдмал учраас ирээдүй хойч үр хүүхдүүддээ мөнгө хуримтлуулъя, баялаг бүтээж үлдээе гэсэн утгатай байсан. Гэтэл үрэгдээд байгаа. Одоо яг өөрөө хариулчихлаа л даа, нөгөө гадаад руу байршуулаагүй, арвижуулах боломжгүй хүүгийн орлого гэж алга гээд. Тэгээд бид нар мэдэж байгаа хүүхдийн мөнгөнд л гол нь явчихсан. Тэр учраас нөгөө байн байнга жил болгон энэ Төсвийн тухай хуульдаа сүрхий сүрхий зорилго тавьдаг, биелдэггүй, энэ дээр бид нар хариуцлагатай хандах ёстой шүү гэдгийг тодотгох үүднээс л асуусан юм.

Дараагийнх нь уг нь 2 гол асуудал хөндөх гээд зориуд асуугаад байгаа нь 1 дүгээрт мэдээж нөгөө maintenance cost засвар, үйлчилгээний зардал сайн тусгагддаггүй учраас тухайн том том бүтээн байгуулалт хийгдлээ гээд үр дүн өгөөж байхгүй, оновчгүй зарцуулалт болчихоод байна. Тийм учраас удахгүй бид нар тодотгол ярьж байна. Цаашиаад ирэх оны Төсвийн хууль ярих юм чинь энэ

дээрээ бас энэ ялангуяа Сангийн сайд энийгээ сайн асуудлаа гаргаад ирээд гишүүддээ ойлгуулаач гэдэг боломж олгоод байхад боломжоо бас нөгөө талдаа ашиглаж чадахгүй байна шүү. Миний гол зорилго бол шүүмжлэхийн төлөө шүүмжлэх биш, дарж яах зорилго алга. Гол нь энэ нөгөө бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдаа гол асуудлуудаа бас гүйцэтгэх засаглал нь ойлгуулж чаддаг байгаасай, эргээд өөрсдөө хариуцлагатай ажилладаг байгаасай гэж хүсээд байгаа юм.

Дараагийн тойрог дээр төрийн өмч болон ТӨК-удын оролцоотой компаниудын хувьцаа эзэмшигчийн эрхийн асуудлаар асуулт асууя. Тэгээд хүн нь ирчихсэн байх байх гэж найдаж байна. Түрүүний асуултууд бол хариулагдаагүй. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Тэр нөгөө Ирээдүйн өв сангийн чинь нөгөө компани нь байгуулагдаагүй байх тийм ээ. Тэгэхдээ Ирээдүйн өв сангийн хуулиар чинь 30 он хүртэл ашиглахгүй гэсэн мөртөө ашигласан тохиолдол гарсан. Тэрний талаар мөн зам жишээлбэл барьчхаад бид нар нөгөө засвар үйлчилгээний мөнгийг нь тавьж өгөхгүй болохоор зам эвдрээд л ингээд л явчхаж байгаа шүү дээ. Уг нь засвар үйлчилгээ арчилгаа нь байж зам насжилт удаан байна, энэ асуудлаа та нар сайн ярьж, танилцуулж, хөрөнгөө шийдвэрлэхэд яадаг юм бэ гэж асууж байна.

3 дахь нь юу байлаа сүүлийнх нь? Төрийн өмчийн энэ оролцоотой компаниуд өчигдөр бас Их Хурал дээр манайхан яриад байсан шүү дээ. Яагаад энэ нөгөө иргэдийн хувьцаатай компани Эрдэнэс Монгол төр нь дураараа ингээд ноогдол ашигийг нь ч төмөр зам руу оруулаад л ингээд яваад байдаг юм бэ? Тэр ноогдол ашигийг нь өгөхгүй гээд яагаад дураараа шийдээд байдаг юм бэ? Өчигдөр хүртэл тэр нөгөө шийдвэр гаргахдаа яагаад энэ олон нийтийн эрх ашиг хөндөгдөхгүй явчхаад байгаа юм гээд. Энэ



зүйлүүд дээр 3 дахь нь хариулт авъя гэж байна шүү. Хариулъя. Эхлээд 4 номер.

**С.Тулга:** Гишүүний асуултад тодруулга өгье. Байнгын хорооны даргын хэлсэнтэй яг зөв, 2030 он хүртэл Ирээдүйн өв сангаас аливаа зарцуулалт хийхийг хориглосон байгаа. Тэгээд зарцуулах 2 заалт байгаа. Нэг нь тэр корпорацын өөрийн үйл ажиллагааны зардал буюу менежментийн зардлаас бусдаар, нөгөөдөх нь зөвхөн 2022 онд хүүхдийн мөнгөн хуримтлалыг Ирээдүйн өв сангийн 2022 оны орлогоос санхүүжүүлнэ гээд хууль дээр өөрчлөлт ороод ингээд хуулийн дагуу нэг л удаа зарцуулалт гарсан Ирээдүйн өв сан 2019 оноос байгуулагдсанаас хойш.

Ирээдүйн өв сан нь 19 онд байгуулагдаад, өмнө Хүний хөгжил сангийн 1 их наяд 67 тэрбум төгрөгийн өр авлагыг төлж барагдуулаад ингээд 23 оны жилийн эцсийн байдлаар 3,5 их наяд төгрөгийн хуримтлал ингээд үүсгээд байгаа.

Хуульд заасны дагуу бид нар хөрөнгө оруулалтыг зөвхөн гадаадад хийнэ гэсэн ийм заалттай. Корпорац бол байгуулагдаагүй. Корпорац байгуулахаар хуульд заасан, корпорац байгуулах ЗГ-ын тогтоол гарсан. Тэгээд 2021 онд нөгөө нэг цар тахлын улмаас ерөнхийдөө энэ нөгөө нэг Ирээдүйн өв сангийн дагаж мөрдөх журмын тухай хуульд нь Төрийн сангийн нэгдсэн дансны журмаар удирдана гэж. Тэгээд гадаад валютын эргэн төлөлт, өр төлбөрийн эргэн төлөлт, валютын нөөцийн хэмжээтэй уялдуулаад ерөнхийдөө Сангийн яам энийгээ удирдаад явах нь зүйтэй гэсэн шийдвэр Их Хурлаас гаргасан байгаа.

**Ц.Даваасүрэн:** 2 дахь нь Хөрөнгө оруулалтын газрын дарга байна уу? Засвар, үйлчилгээний зардлыг нь яагаад тусгадаггүй юм бэ гээд байна. Сангийн яам, засвар, үйлчилгээний зардлуудыг яасан бэ? Та дэд сайдаа өгчихсөн шүү. Яах вэ хариулах гэж байх шиг байна тийм

үү? 4 номер дээр хариулах гээд байна уу, 3 номер хариулах гээд байна уу? 3 хариулъя, Цогбадрах. Засвар, үйлчилгээний зардлыг тусгахгүй байна, насжилт удаан биш болчихоод байна гэдэг асуултад хариулъя. Энэ төрийн өмчлөлийн асуудал дээр нь дараа нь бэлдэж байгаарай. Сангийн яамны Санхүүгийн бодлогынхон хариулна шүү. Төрийн өмчийн хорооноос хүн бий юу? Цэнгэл даргыг дуудах юм уу? 3 номер.

**Б.Цогбадрах:** Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Төрийн сангийн газрын дарга Цогбадрах. 2023 онд Зам, тээврийн хөгжлийн сайд дээр 38,6 тэрбум төгрөгийн зам, тээврийн засвар дээр 38,6 6 тэрбум төгрөгийн төсөвтэй байснаас гүйцэтгэл нь 37,1 хувь буюу 96,1 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

**Ц.Даваасүрэн:** Хүсэлт нь хэд ирээд, хэдээр хянагдсан юм бол? Зам, тээврийн яамнаас хүн байна уу? Энэ Зам, тээврийн яам, Төрийн өмчийн хороо бусад улсуудыг оролцуулъя. Сангийн яам өөрөө хариулж чадахгүй байгаад байна шүү дээ та нар. Тэгсэн мөртөө өөрсдөө нэр өгөхдөө тэд нарынхаа нэрийг өгөөгүй. Тэгээд хариулж чадахгүй болчихоод байна шүү дээ. Төрийн өмчийн хороо ер нь төрийн өмчийн асуудал бол өчигдрөөс хойш нэлээн хөндөгдөөд байгаа учраас Цэнгэл даргыг дуудъя. Нийгэм, хамгаалал, нийгмийн даатгалынхныг оролцуулъя, асуултад бүрэн хариулъя. ЗТЯ-ны төлөөллийг оролцуулъя, ЭМЯ-ны төлөөллийг оролцуулъя. Эдгээр улсуудыг яаралтай дуудъя. Энэ чинь нийтдээ 10 гишүүн асуух гээд байна шүү дээ. Тэр өмчлөлийнх дээр нь та нар дараа нь тодруулаад Мөнхсоёл гишүүнд өгөөрэй.

Хэчнээн хэмжээний хүсэлт ЗТЯ-наас ирсэн, хэдээр хянагдсан юм бэ? Гүйцэтгэлийг нь ойлголоо. Тэр өмчлөлтэй холбогдолтой асуудал дээр хариулт өгье. Сангийн яамны Санхүү, бодлогын газрынхан байна уу? Төрийн өмчийн асуудал чинь танайд тэр газраа байгаа биз дээ? Хаанаа байдаг юм бэ? Энэ төрийн өмчийн хувьцаа тэр санхүүдээ

байдаггүй юм уу? Ингэе, одоо ЗГ хуралдаж байгаа учраас яах вэ сайд нар оролцоход хүндрэлтэй байгаа байх, ТНБД нарыг бүгдийг нь дуудъя бүх яамдын. Тэгж байж хариулъя. Тэгээд Төрийн өмчийн хорооны даргыг дуудъя, яаралтай дууд. Одоо ингэе, одоо хэд болж байна вэ? 12 цагт үргэлжлүүлээд хуралдана. Нийслэлийг бас дуудъя. Монголбанкнаас ч бас хүн дуудах хэрэгтэй болох юм байна. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн өмчийн хороо, тэгээд бүх яамдын Төрийн нарийн бичгийн даргаас дээш албан тушаалтнууд оролцъё. Нийслэлийг дуудъя. Тийм ирцээ хадгалаад.

Ингэе 12 гэхэд саяын юу хэлсэн улсуудыг бүгдийг нь дууд. 12 гэхэд ирсэн бай. Тэр хооронд бас ганц, хоёр гишүүдийн асуултад хариулаад явж байя. Тэгээд дутуу хариулсныг тэр улсуудыг ирэхээр гүйцээж хариулъя, болж байна уу? Ингээд явчихъя. Мөнхсоёл гишүүний асуусан тэр төрийн өмчлөлтэй холбогдолтой эрх зүйн асуудлууд дээр Төрийн өмчийн хороо ирж хариулт өгье. Банктай холбогдолтой тэр Монголбанк ирж хариулт өгье. Мөн Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн удирдлагууд, Төрийн өмчийн хорооны удирдлагууд ирж оролцъё. Батбаяр гишүүн асуултаа асууя.

**Д.Батбаяр:** Би яг энэ аудитын тайлантай холбоотой жижигхэн жижигхэн асуулт асуугаад явчихъя. Тодорхой хариулчхаарай. 1 дүгээр асуулт нь энэ нөгөө ЭТГ ХК-ийн ноогдол ашиг тасарсан байна. Энэ дээр шалтгааныг нь Эрдэнэс Монгол түүний нэгдлийн болон бусад төрийн өмчийн оролцоотой компаниудын хооронд үүссэн авлагаас болоод ноогдол ашгаа төвлөрүүлж чадаагүй байна гэсэн байна. Тэгэхээр хэдэн оноос хойш үүссэн, ямар ямар ТӨК-удын авлагууд байгаа вэ гэдгийг тодорхой хариулж өгнө үү 1 дүгээр асуулт нь.

2 дугаарт нь энэ Нийслэлийн амьдрах орчныг дээшлүүлэх, түгжрэлийг бууруулах, гол дагуу дэд бүтцийг сайжруулах зорилготой холбоос замын

төсөл гээд Нийслэлээс төвлөрүүлэх ёстой байсан 187 тэрбум төгрөгийг нь хасаж тооцсон гэж байна. Энэ холбоос зам төслийн гүйцэтгэл дээр та бүхэн маань аудит хийсэн үү? Энэ энэний гүйцэтгэлийн тайлантай танилцсан уу? Энэ холбоос зам төсөл ямар шатанд явж байна вэ гэсэн 2 дахь асуулт нь байна.

3 дугаарт нь малын гаралтай түүхий эд, эдийг боловсруулах үйлдвэрийн гаалийн татварыг 100 хувь чөлөөлсөн юм байна. Энэ чөлөөлсөн энэ арга хэмжээний хүрээнд хэдэн үйлдвэр орж ирсэн бэ? Одоо үйлдвэрүүд нь баригдсан уу, ямар үр дүнтэй байгаа вэ? Энэ 3 дугаар асуулт байлаа.

4 дүгээр асуулт нь төрийн сангийн мөнгө 2011 оноос 13 он, 16 он хүртэл байршаад одоо хүртэл авч чадахгүй байгаад байгаа юм байна. 16-аас, 2016 оноос хойш өдийг хүртэл төрийн сангийн мөнгө ямар хэмжээтэй мөнгө аль аль банкин дээр байришиж байгаа вэ? Нийгмийн даатгал болон Эрүүл мэндийн даатгалын сан. Энэ дээр чинь нөгөө Төсвийн тогтвортой байдлын зөвлөл байгаа билүү? Байхгүй байгаа юу? Тогтвортой байдлын зөвлөлийг 12 цагаас ирүүлж болох уу? Тэгэхэд нь бас ахиад нэмэлт асуулт асуучихъя.

**Ц.Даваасүрэн:** Тэгвэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхнийг оруулчихъя. Ингээд саяын 4 асуултад хариулъя. Эрдэнэс таван толгойн зээл, холбоос зам, малын гаралтай Хөдөө аж ахуйн яам байна шүү. Малын гаралтай түүхий эд, төрийн сангийнх биш шүү. Энэ нөгөө нэг нийгмийн даатгалын сан, эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг аль банкнуудад байришуулсан бэ, ямар эрсдэл үүссэн бэ гэдэг асуулт. Эрдэнэс тавантолгойн зээл дээр хариулъя. Хэн хариулах вэ? Эрдэнэс тавантолгой. Эрдэнэс тавантолгой чинь тэгээд л нөгөө манай Төрийн өмчийн хороо л ирэх хэрэгтэй болж байна даа. Төрийн өмчийн хороо. Эрдэнэс Монголын ч, яах вэ ер нь болбол энэ Их Хуралд

хариулах чинь бас дэгтэй л дээ. Тэгээд бүүр сүүлдээ бүүр ингээд мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, компаниуд хариулдаг болсон. Уг эрх бүхий албан тушаалтнууд нь хариулах ёстой, хариуцлагаа хүлээх ёстой байдаг байхгүй юу. Холбоос зам төсөв дээр хариулах хүн байна уу? Загджав дарга.

**Д.Загджав:** Батбаяр гишүүний асуултад хариулъя. Холбоос зам төсөл дээр болбол 23 онд гүйцэтгэлийн аудит хийгдээгүй, 24 онд төлөвлөгөөнд туссан байгаа. 24 онд хийнэ.

**Ц.Даваасүрэн:** Хөдөө аж ахуйн яам малын гаралтай түүхий эдийг татвараас, гаалиас чөлөөлсөн. Гаалийн дарга ирсэн биз? Татварын дарга ирсэн үү? Би ирээрэй гэсэн шүү. Энэ чөлөөлсөн дүн ер нь хэд вэ? Хэчнээн хэмжээний үйлдвэр баригдсан бэ? Гааль, Хөдөө аж ахуйн яам хариулъя. Гаалийн дарга. 4 номерын микрофон дээр.

**С.Баярмаа:** Батбаяр гишүүний асуултад хариулж байна. Гаалийн ерөнхий газрын Татвар, орлогын газрын дарга Баярмаа. 2023 онд Хүнс, хөдөө аж ахуйн яамны чиглэлтэй ААН-үүдийн барааны ангиллын тодорхойлолтод заагдсан дагуу 40 орчим ААН-ийн барааг татвараас чөлөөлсөн боловч татварыг ноогдуулж 24 оны 1 дүгээр улиралд багтаан олголтыг олгосон байгаа. 2,4 тэрбум төгрөг.

**Ц.Даваасүрэн:** Танай дарга яагаад ирэхгүй байгаад байгаа юм бэ?

**С.Баярмаа:** Дарга 10 цагаас Гаалийн ерөнхий газар дээр Туркийн элчин сайдтай уулзалт зохион байгуулахаар төлөвлөсөн.

**Ц.Даваасүрэн:** Үгүй ээ одоо тэгээд 12 цаг болж байна шүү дээ. Дууд, дууд. Ингэж хариуцлагагүй хандаад байж болохгүй.

**С.Баярмаа:** Ойлголоо.

**Ц.Даваасүрэн:** Сайд нь ч байхгүй, тэгээд өөрөө агентлагийн дарга нар нь байхгүй. Тэгээд асуултад хариулж чадахгүй. Хамтарсан биш бүүр шал дордов гэдэг нь болж байна шүү дээ. Хөдөө аж ахуйн яам хариулъя, хэчнээн үйлдвэр ашиглалтад орсон юм бэ? Хөдөө аж ахуйн яамнаас адаглаад мэргэжилтэн байна уу, одоо ингэж л гуйхаас даа. Хөдөө аж ахуйн яамны хүн. Тэр хооронд нөгөө нийгмийн даатгалын сан, эрүүл мэндийн даатгалын сангийн юугаар дахиад хариулчихъя Цогбадрах хариулчихъя, 3 номерын микрофон.

**Б.Цогбадрах:** Батбаяр гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Цогбадрах. Нийгмийн даатгалын сангийн хувьд бол яг 2023 оны жилийн эцсийн байдлаар Чингис Хаан банкин дээр 94,9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй, Капитал банкин дээр 68,1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй, нийт энэ 2 банкин дээр 163 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

ЭМД-ын сангийн хувьд бол Чингис Хаан банканд 2023 оны жилийн эцсийн байдлаар Чингис Хаан банкин дээр 30,9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй, Капитал банкин дээр 78,5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй, нийтдээ 109,3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Ц.Даваасүрэн:** Тодруулъя. Батбаяр гишүүний микрофоныг өгье.

**Д.Батбаяр:** Баярлалаа Цогбадрах дарга. Тэгэхээр энэ 2 банкнаас өөр банкин дээр үлдэгдэл байхгүй гэсэн үг үү? Би бол дэлгэрэнгүйгээр хариулахыг хүссэн. Хаана хаана байгаа вэ? Ямар хэмжээтэй байгаа вэ? Ямар эрсдэл учирч байгаа вэ?

**Ц.Даваасүрэн:** Батбаяр гишүүний микрофоныг нэмж өгье.

**Д.Батбаяр:** БЭГ томилогдсон байгаа шүү дээ тийм ээ? Тэгэхээр одоог хүртэл энэ байгаа энэ үлдэгдлийг

барагдуулж байгаа үйл явц ямархуу байна, хэдэн төгрөгийг нь барагдуулаад байна вэ гэдэг дээр нь дэлгэрэнгүй хариулчхаарай. 2 асуулт дахиад нэмж асуулаа шүү дээ.

**Ц.Даваасүрэн:** 1 номер хариулах юм уу, 1 номер. Монголбанкнаас ирсэн үү? Энэ БЭГ томилсон, тэгээд өр барагдуулалт ямар байгаа вэ гэж байна шүү.

**В.Рэнцэнханд:** Батбаяр гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын сангийн харилцах данс арилжааны банкин дээр 2023 оны эцсийн байдлаар 1 их наяд 134,8 тэрбум төгрөг байсан байна. Үүнээс Голомт банкин дээр 87,9, Капитрон дээр 62,3, Солонгос дахь банк буюу нөгөө нэг цэгийн үйлчилгээ тэрэн дээр бол 117 сая төгрөг, Төрийн банкин дээр 373 тэрбум, Хаан банкин дээр 441 тэрбум, Хас банкин дээр 6,3 тэрбум, ХХБ дээр 67,9, Чингис хаан банкин дээр 94,9 гэж байна.

ЭМД-ын сан болбол 94,6 тэрбум төгрөгийн төгрөг болбол арилжааны банкин дээр 23 оны эцсийн байдлаар байршсан байна. Үүнээс бол Голомт банкин дээр 13 тэрбум, Капитрон дээр 3 тэрбум, Төрийн банкин дээр 9, Хаан банкин дээр 25 тэрбум, Хас банкин дээр нэг, Худалдаа хөгжил дээр 11, Чингис Хаан банкин дээр 30 тэрбум төгрөг тус тус байршсан байна. Юуны он оноор эцсийн үлдэгдлийг болбол нэгтгээд Батбаяр гишүүнд хүргүүлье.

**Ц.Даваасүрэн:** Тэг, банк, бүх банкнудаар, тэр нөгөө зөвхөн Чингис биш, Капитал хоёроор биш бусад бүх банкнуудыг нь оруулаад. Тэгээд Монголбанк ирэхээр тэр нөгөө өр барагдуулалтыг нь сонсьё. Хөдөө аж ахуйн яам бас ирэхээр тэр нөгөө хэчнээн үйлдвэр малын гаралтай түүхий эдийн чиглэлээр бий болоод байгаа вэ, татварын хөнгөлөлт авсны үр дүнд. Эрдэнэс тавантолгойн хэчнээн хэмжээний зээл олгогдоод байгаа вэ, ямар

авлага өглөг байна гэдгийг Төрийн өмчийн хороо Цэнгэл дарга. Энхтүвшин гишүүн асууж байя.

**Д.Энхтүвшин:** Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Эхний асуулт нь эдийн засаг өнгөрсөн онд 7 хувиар өссөн гэсэн үзүүлэлт байна. Энэ дотор нь салбараар нь задлаад үзвэл бол уурхай 2,6, тэгээд дараагийн салбар нь 1,8 хувиар тээвэр, агуулахын салбар өссөн ийм үзүүлэлттэй байна. Тэгэхээр төсвийн нөгөө тогтвортой байдлын үзүүлэлт эд нар болохоор уул уурхайн бус өсөлтийг нэрлэсэн үнээр нь 23,3 хувиар өсөж, төсвийн нэгдсэн зардлаа яг энэндээ 23,2-оор барьсан ийм дүр зураг харагдаж байна. Тэгэхээр энэ дээр задаргаа дээр нэг ийм уг нь энэ нөгөө үзүүлэлтийг тооцохдоо уул уурхайн салбарын нөгөө эрдсийн, эрдэс баялгийн бус гэдгийг эрдэс баялгийн гэж тодорхойлохдоо уул уурхайн салбарын энэ балансыг тооцохдоо ихэвчлэн биржээр зарж байгаа нь болбол тээвэр нь орчихсон явж байгаа.

Тэгэхээр энэ дээр бол жишээлбэл тайлбар дээрээ бас бичсэн байна лээ л дээ. Тээвэр энэ агуулахын үйлчилгээ нэмэгдсэн нь болохоор бол уул уурхайтай холбоотой гэсэн ийм үзүүлэлт байна лээ. Тэгэхээр энэ дээр энэ бол уурхайн тээвэр логистиктой холбоотой өсөлт дотор хэд нь бол уурхайтай холбоотой вэ? Энэ үзүүлэлт чинь тэгэхээр бид нар үзүүлэлтээ дутуу тооцоод байгаа байхгүй юу. Тээвэр логистикийн салбар дангаараа өсөөд байгаа биш, уул уурхайгаас хамааралтай өсөлтийг нь дутуу тооцоод, тэгээд энэ хэмжээгээр бас төсвийн зардал нэмэгдүүлсэн юм шиг ийм дүр зураг харагдаж байна. Тэгэхээр энэ дээр тодорхой юу хариулт хүсье. Энэ тээвэр агуулах гэдэг энэ салбарын үзүүлэлт 1,8 хувийн өсөлтийн хэд нь уул уурхайтай холбоотой вэ гэдэг нэг асуулт байна.

Тэгээд дараагийнх нь болохоор орлогын албан татвар 3,8 их наяд, тэгээд



НДШ-ийн орлого 3,9 их наяд байх шиг байна. Тэгээд энэ дотор төрийн болон ТӨК-удын төлсөн татварын болон хувийн хэвшлийн энэ ялгаануудыг нь гаргаж тоог нь хэлж өгөөч.

3 дугаарт нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан гээд энэ задалчихсан аягүй олон дүүргүүдээр нь задалчихсан байна. Тэгээд энэ нийт дүнгээрээ хэд болсон юм бэ? Тэгээд энэ дээр болохоор жишээлбэл залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ, ногоон ажлын байр хөтөлбөр, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ гээд яг үнэндээ жишээлбэл хөдөлмөрийн байр хөдөлмөрийн зах зээл дээр дутагдалтай байгаа энэ үед болохоор яг нөгөө талд нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ гээд ийм богино хугацаатай нэг ийм үр бүтээл багатай, тэгээд энийг нь болохоор санхүүжүүлж байгаа эх үүсвэр нь бол ААН-үүдээс авдаг ийм байдал харагдаад байгаа. Тэгээд энэ хөтөлбөрүүдийн урт хугацааны нөлөө ямар байдаг юм бэ? Энэ талаар бас мэдээлэл авмаар байна.

Тэгээд дээр нь яах вэ зүгээр одоо ерөнхийдөө харахад болбол ийм байр солигдчихсон харагдаад байна л даа. ААН-үүдийн хувьд бол жишээлбэл ТУЗ нь хуралдаж байхад гүйцэтгэх захирал нь ч юм уу, алба, хэлтсийн дарга нь би ийм хуралтай, ажилтай ч юм уу гээд жишээлбэл яваад байж болдоггүй. Тэгэхээр төр засгийн хувьд бол жишээлбэл Улсын Их Хурлын энэ эрэмбэ жишээлбэл ЗГ-ын хуралдаантай гээд жишээлбэл бид нар ингээд жишээлбэл байна гэдэг чинь өөрөө энийг хүлээн зөвшөөрч байна гэдэг чинь бас.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Эхнийх нь Сангийн яам хариулъя. Дараагийнх нь татварыг хариулаад, тэр хөтөлбөртэй холбогдолтой ажлын байрыг нь бас Сангийн яам хариулъя. Хэдэн номерын микрофон уу? Тэр төсвийн тогтвортой байдлын үзүүлэлттэй холбогдуулаад

асуулаа шүү дээ, 6.1.3-тай холбогдуулаад. Төсвийн тогтвортой байдлын үзүүлэлттэй холбогдуулаад аудит ямар дүгнэлт хийсэн юм бэ? Энэ асуугаад байгаа 6.1.3 биелсэн юм уу, биелээгүй юм уу? Аль нь эхэлж хариулах вэ? Нөгөө уул уурхайн эрдэс баялгийн бус бүтээгдэхүүний өсөлттэй холбогдуулж асуугаад байна шүү дээ. Тэгээд тэр тээвэрт тооцогдох уу? Тээврийн асуудал, тээврийн зардлын асуудал. 7 номер.

**Я.Самбууням:** Үндэсний аудитын газар Самбууням байна. Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого тусламжийн орлогын дүнгийн дүнд уул уурхайн салбарын орлого 25,6-аас 29,6 хувийн дүнг эзэлдэг юм байна. Энэ нь болбол 2021-ээс 23 оны үзүүлэлтээр бидний авсан дүнгээр ийм дүнтэй байна.

Уул уурхай, газрын тосны орлого нийт орлогын 2023 оны гүйцэтгэлийг хэлэхэд болбол нийтдээ төлөвлөсөн нь болбол 6 аравны.../үг тасрав/

**Ц.Даваасүрэн:** Биш ээ биш. Тэр 6.1.3-ын нөгөө өсөлт байгаа шүү дээ. Өсөлт нь нөгөө уул уурхайн бус эрдэс баялгийн бүтээгдэхүүний нөгөө ДНБ-ий өсөлтийн хувь нь зардлын өсөлтийн хувиас өндөр байна гээд байгаа шүү дээ. Тэгэхэд тээврийн зардал тооцогдсон уу гээд нэлээн тодорхой асуусан шүү дээ. 6.1-ийн, та нар ер нь энэ төсвийн гүйцэтгэлийг оруулж ирэхдээ Тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагуудыг хангасан юм уу, үгүй юу гэж л дүгнэлт гаргах ёстой шүү дээ. Тийм. Тийм учраас би 6.1.3-ыг яасан юм бэ гээд байна шүү дээ. 6 номерын микрофон.

**Ц.Наранчимэг:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Тайлант онд нэгдсэн төсвийн зарлага нь 4,3 их наяд төгрөгөөр буюу 24 хувиар өссөн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-ын шаардлагыг хангасан байна гэж Монгол Улсын нэгдсэн төсвийн



гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлтэд дүгнэсэн байгаа. Тооцож үзээд, шаардлага хангасан байна гэж, бүх тооцооллыг оруулж тооцоод, шаардлага хангасан байна гэсэн дүгнэлтийг гаргасан.

**Ц.Даваасүрэн:** Сангийн яам, 3 номерын микрофон.

**Б.Цогбадрах:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Цогбадрах. Зарлагын өсөлтийн тусгай шаардлагын хувьд бол тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь 24 хувь, тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь 19,3 хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоод нийт ДНБ-ий өсөлтийн хувь 15,7 гэж тооцон, нэгдсэн төсвийн нийт зарлага 4,3 их наяд төгрөгөөр буюу 24 хувиар өссөн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-д заасан тусгай шаардлагыг хангасан гэж үзсэн.

**Ц.Даваасүрэн:** Татвар 9.

**Р.Мягмаржав:** Татварын ерөнхий газар Мягмаржав. Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Татварын байгууллагад яг төвлөрсөн 2023 онд нийтдээ 13,6 их наяд төгрөгийн татварын орлого төвлөрсөн байгаа. Үүнээс яг уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь нийт орлогын 50 хувь буюу 6,9 их наяд төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. Яг энэ дотроосоо яг ТӨК-удын төлсөн татвар төлөлттэй холбоотой мэдээлэл нь яг болбол эргээд бид нар бас мэдээллээ бэлтгээд эрхэм гишүүн танд хүргүүлье.

**Ц.Даваасүрэн:** Та нар ингээд хүргүүлье гээд байж болохгүй шүү. Тодорхой хариулна шүү. Тэр хөтөлбөрүүд, ажлын байртай холбогдолтой Сангийн яам. Монголбанк ирсэн үү, Төрийн өмчийн хороо ирсэн байна уу? Яасан бэ манай гишүүд хэтэрхий хүнд асуулт асуугаад

байна уу? Та нар их хөнгөн бэлдсэн болж таараад байна уу, хариуцлагагүй хандсан уу? Сангийн яамныхан яах байсан шүү дээ. Энэ нэр өгөхдөө холбогдох яамных нь улсуудын нэрийг өгөх ёстой байсан байхгүй юу та нар. Зөвхөн өөрсдийнхөө нэрийг, аудиттай өгчихсөн байна шүү дээ. Энхтүвшин гишүүн нэмээд тодруулчихъя.

**Д.Энхтүвшин:** Ер нь энэ хуралдааны зүгээр ач холбогдол их бага болчихоод байна. Бид хэд нэг асуусан боллоо. Тэгээд 1 дүгээрт хариулт байхгүй. 2 дугаарт хариултууд бас хангалттай биш байгаа учраас хойшлуулбал яасан юм бэ гэсэн санал байна.

Дээр нь бас энэ бэлдсэн материалууд дээр хангалтгүй байгаа харагдаж байна. Яаруу сандруу хийсэн юм уу? Уг нь цаг хугацаа байсан санагдаж байна. Жишээлбэл энэ дээр нэг хуудсан дээр нь төсвийн зарлага болон цэвэр зээлийн дүн гээд гүйцэтгэл 16 тэрбум гэж байснаа, дараагийн хуудсан дээр нь жишээлбэл өөр байдлаар тэр нь 20 хэдэн тэрбум бол ингээд болчихсон. Тэгэхээр энэ аль тоо нь зөв юм бэ, энэ хооронд нь уялдаанууд буруу, зөрүү эсвэл алдчихсан юмнууд байгаад байна. Ер нь бэлтгэл нэлээн хангалтгүй, хариулж байгаа байдал нэлээн хангалтгүй учраас энэ хойшлуулбал яасан юм бэ гэсэн тийм саналтай байна.

**Ц.Даваасүрэн:** Гишүүд шаардлагатай хариулт авч чадахгүй байгаа учраас 2 цаг хүртэл хойшлууллаа. Тэгэхдээ 2 цагт саяын миний дуудсан Монголбанк, Төрийн өмчийн хороо, Эрүүл мэндийн даатгал хариуцсан улсууд, Нийгмийн даатгал хариуцсан агентлагийн дарга нар, Санхүүгийн зохицуулах хороо, гааль, татвар, Нийслэл энэ улсуудыг оролцуулаад ингээд хуралдаанаа үргэлжлүүлье. Шаардлагатай хариултыг өгөх хэмжээнд Сангийн яам бэлтгэл хангасан байх ёстой шүү. Хөдөө аж ахуйн сангийн, Хөдөө аж ахуйн сан Хөдөө аж ахуйн яамнаас нээрээ

хүмүүс ирэх ёстой шүү. Хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Хөдөө аж ахуйн яамны холбогдох улсууд. Хөдөө аж ахуйн ер нь сангуудтай холбогдолтой асуудлууд нэлээн гарах юм байна гэж ингэж бодоорой.

Ингээд бэлтгэл хангасны дараа хуралдааныг үргэлжлүүлье.

Хуралдаан 12 цаг 05 минутаас 14 цаг 05 минут хүртэл завсарлав.

**Ц.Даваасүрэн:** Батболд гишүүн, Соронзонболд гишүүн, Цогтбаатар ажлын хэсгүүд орж ирье. Ажлын хэсгийн гишүүд орж ирээрэй. Тэгнэ. Аубакир гишүүн шиг л цагтаа ирмээр байх юм. Одоо Мэндсайхан гишүүн асуух юм байна шүү. ХААЯ-наас хүмүүс ирчихсэн байгаа юу? Ингээд Мэндсайхан гишүүн асууна. Ажлын хэсгүүд ороорой, хуралдаанаа эхэлье. Дараа нь П.Ганзориг гишүүн, Б.Түвшин гишүүн, Батлут гишүүн, Батболд гишүүн, Соронзонболд гишүүн, Цогтбаатар гишүүн нар асуух юм байна шүү. Байхгүй байвал тэгээд л алгасаад яваад байна. Мэндсайхан гишүүний микрофоныг өгье. Мэндсайхан гишүүн асуултаа асууя.

**З.Мэндсайхан:** 23 оны төсвийн гүйцэтгэлтэй холбоотой дүгнэлт гарсан байна. Тэгэхээр би 2, 3 асуулт асуучихъя гэж бодож байна. ХАА-н ер нь энэ ЗГ-ын тусгай сангуудын асуудлаар ХАА-н дэмжих санг энэ янзаараа явж болохгүй юм байна гээд өөрчлөх шийдвэрийг тухайн үед нь гаргаад, Сангийн яам, Хөдөө аж ахуйн хамтарсан ажлын хэсэг гаргаж, ХАА-н дэмжих санг шалгаж байсан. Энэний дагуу би тухайн үед хуулийн байгууллагад хандсан.

Одоо энэ гүйцэтгэлтийн дүгнэлтээс харж байхад ТӨК болгоод бие даалгаад гаргаад сангийн асуудлыг хаясан. Гэхдээ энэ дээр тэр яагаад тэр шалгалтаар тогтоогдсон сангийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулсан тэр авлагыг өнөөдрийг хүртэл барагдуулахгүй

ингээд компани руу нь шилжүүлчхэв? Энэ сангийн үйл ажиллагааг чинь яг энэ хэлбэрээр нь үргэлжлүүлж болохгүй гээд ТӨК болгосон шүү дээ. Тэр хувийн хэвшилүүдтэйгээ битгий өрсөлдөөд бай. Нөгөө талдаа тэр сангаар ажиллаж байхад хүлээсэн алдагдлын чинь ихэнх нь ЗГ-ын хөнгөлөлтөөр явчихсан байгаа. Энэ дээр Сангийн яам яагаад буцаагаад ХАА-н дэмжих сандаа ЗГ-ын тогтоолоор 50-аас 80 хувь хүртэлх хөнгөлсөн хөнгөлөлтийнхөө нөхөн дүүргэлтийг хийдэггүй юм бэ? Энэнээс чинь болоод ЗГ-аас авах авлага чинь өсөөд яваад байгаа юм. Ингээд ЗГ өөрөө шийдвэр гаргачхаад, тэр шийдвэрийнхээ иргэдэд юу гэдэг юм ХАА-н салбарт дэмжлэг үзүүлчхээд нөгөө талдаа сангаа ингээд дампууруулах ийм байдалд л хүргэчихсэн байсан. Тэгээд энэ дээр ямар арга хэмжээ авсан бэ? 2 дугаарт тэр өрний араас ер нь яагаад явахгүй байна вэ?

2 дугаарт энэ ХАА-н салбарыг дэмжих хөнгөлөлттэй зээлүүдийг бид нар гаргасан. Одоо шинэ хоршоо, чинээлэг малчны хөтөлбөр маань хэрэгжээд явж байна. Цагаан алт гээд хөтөлбөр хэрэгжих гэж байна. Тэгэхээр арилжааны банктай хамтраад гаргаж байгаа энэ хөтөлбөрийн хүрээнд ХААЯ-ныхаа одоо яг гарсан зээл чинь яг хэчнээн үйлдвэрт очсон бэ? Энэ хүрээнд хэдий хэмжээний татаас өгчхөөд байгаа юм бэ? Энэ банк арилжааны банкнуудтайгаа жил бүр энэ зээлийн үр дүнг 2 талаасаа тэр гэрээнд оролцогч талууд үнэлээд явна гэсэн. Энэ дээр ямар нэгэн дүгнэлт гараагүй байна. Тэгэхээр энэ зээл чинь өөрөө хэр үр дүнгээ өгч байгаа юм бэ гэдэг.

3 дугаарт энэ татаас, ЗГ-ын татаас хэмнэгдсэн байна гээд энэ дүгнэлтэд орчихсон байна ХАА-н салбар дээр. Ноос ноолуурын урамшууллаа ноос, арьс ширний урамшууллаа өнөөдрийг хүртэл малчид авч чадахгүй байна. Тэгээд тэрийгээ бүртгэлийн тогтолцоотой холбоотой гээд энэнээс бид нар 100 орчим тэрбумыг хэмнэчихсэн гээд гаргачихсан

байгаа юм, 10,5-ыг ч билүү. Ингээд хэмнэлт гаргаад яваад байгаа гээд байдаг. Нөгөө талдаа энэ үндэсний үйлдвэрүүдээ дэмжээд арьс, ноос ноолуураа өгчихсөн малчид чинь урамшууллаа авч чадахгүй сар, жилээр хүлээгээд байна. Энэ асуудлыг яагаад.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** ХААЯ-наас хэн байна вэ? ХААЯ-наас хариулъя. Энхбаяр сайд байна уу? ХААЯ Энхбаяр сайд руу хэл дээ, ир гэсэн улсууд ирсэн байна уу? Нөгөө ТӨХ Цэнгэл дарга байна уу, Монголбанк байна уу? Нийгмийн даатгал, боловсрол, эрүүл мэнд. Үгүй ээ нөгөө Сангийн яамнаас гадна нөгөө Монголбанкныхан ЭМД-ын сангийнхан, нийгмийн даатгалын сан байгаа юу? ХАА, Монголбанк, ТӨХ, хаанаас юм бэ? Танай дарга яасан юм бэ? Идэрээ тийшээ суугаад тэр 1, 2, 3, 4 дүгээр микрофоны аль нэг рүү суугаад Идэрцогт дарга хариулъя. 1 дүгээр микрофон, асуултыг сонссон уу? Мэндсайхан гишүүний микрофоныг дахиад өгчихье.

**З.Мэндсайхан:** Тэр ХАА-н дэмжих санг өөрчлөөд ТӨК болгосон. Зорилго нь бол энэ сангийн өр авлага, алдагдал замбараагүй болсон байна гэдгийг Сангийн яамтай тухайн үед хамтраад шалгаад, тогтоогоод, хуулийн байгууллагад хандаж байсан. Энэний араас танай яам юу хийсэн бэ? Энэ 100 тэр үеийн миний санаж байгаагаар бол 100 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө найдваргүй авлага болчихсон явж байсан. Энийг яагаад тэр сангийн өрийг барагдуулахгүйгээр шууд тэр ААН рүү нь шилжүүлчэв. Энэний араас ямар ажил хийв? Нөгөө талдаа ХАА-н дэмжих санг тухайн үеийн ЗГ-ын шийдвэрүүдээр хөнгөлөлт олгоод, ХАА-н салбарыг дэмжих хүрээнд хөнгөлөлтүүдийг олгоод явж байсан. Сангийнхаа дүрмээр бол тэр олгосон хөнгөлөлтийн хэмжээгээр нөхөн дүүргэлтийг нь хийгээд явах ёстой. Энэ ажлыг яаж, юу яагаад өнөөдрийг болтол хэрэгжүүлэхгүй ингээд энэ сангийн

хэлбэрийг өөрчилчхөөд үр дүнгүй болгоод хаячихав?

2 дугаарт энэ ноос, арьс ширний урамшуулал олгогдоогүй байна 23 оны. Малчид чинь энэ асуудлуудыг хөдөө орон нутагт явж байхад үндэсний үйлдвэрүүдээ дэмжээд түүхий эдээ өгчихсөн байдаг, өнөөдрийг хүртэл урамшуулал нь орж ирэхгүй байна гэдэг асуудал ярьж байна. Тэгээд энэ дээрээ яагаад энэ асуудлууд хойш нь тавигдаад яваад байна вэ? ХААЯ-наас асуухаар бүртгэлийн асуудал байна гэж хэлээд яваад байгаа. Тэгэхээр бүртгэлийн асуудал бол танай асуудал шүү дээ. Тэгээд энэ асуудлаа яагаад шийдэхгүй байгаа юм бэ?

3 дугаарт тэр ХАА-н дэмжих зээлүүдийг бид нар гуравласан гэрээ байгуулаад энэ салбараа дэмжээд явж байгаа. Жилийн хугацаанд дүгнээд энэ зээлийг, зээл олгож байгаа арилжааны банк, Монголбанк, ХААЯ 3 дүгнээд явах ёстой. Энэ дээр яг хэчнээн үйлдвэр дээр оччихов энэ зээл, хэдий хэмжээний татаас тийшээ явчлав? Яг бодит үр дүнгүүд газар тариалан, МАА, хүнсний үйлдвэрлэл дээр ямар ямар хэлбэрээр гарч ирэв гэдгийг нэг тодорхой тоо баримттай хэлээд өгөөч.

**Ц.Даваасүрэн:** 1 номерын микрофон нэрээ хэлээд, албан тушаалаа хэлээд, тэгээд хариултаа өгье.

**Л.Идэрцогт:** ХХААХҮЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Идэрцогт. Мэндсайхан гишүүний асуултад хариулъя. Эхний асуулт ХАА дэмжих санг ХАА-н корпорац болгосонтой холбогдуулаад өр зээлийг барагдуулах ажил яагаад эрчимжүүлээгүй вэ гэдэг асуудал яригдаж байна. ХАА-н дэмжих санг өнгөрсөн 23 оны 7 сарын 19-ний өдрөөр тасалбар болгоод, ХАА-н корпорац ААН рүү шилжүүлсэн. Ингэж шилжүүлэхдээ болбол балансаас баланст бүх өр авлагыг тухайн үеийн балансаас шууд

шилжүүлсэн байгаа. Энэнээс хойш 23 онд ХАА-н корпорацын хувьд бол нийт өр төлбөр оны эхнээс 52,7 тэрбумаар буурсан. 270,8 тэрбум байсан. Энэнээс 52,7 тэрбумаар буусан. Богино хугацаатай өр төлбөр нийт өр төлбөрийн 96,3 тэрбум төгрөг байснаас урт хугацаат үүний өр төлбөр нь 174 тэрбум байсан. Эндээс бол ХАА-н корпорац дээр бас хууль хяналтын байгууллагад шилжүүлэх ажлын хэсэг байгуулагдаад, энэ ажлын хэсгийн ажилласан дүнгээр бол үндсэндээ 52,7 тэрбум төгрөгийн өр зээл, өр бол барагдсан ийм дүнтэй байгаа.

Цаашидаа болбол бас энэ чиглэлээр өрийг барагдуулах, ялангуяа ХАА-н дэмжих сан маань урьд нь малчдыг Мал хамгаалах сан, Газар тариалан эрхлэхийг дэмжих сан гэсэн олон сангуудыг 2008 оноос хойших өр төлбөрүүд байсан учраас бас нэлээд тооцоо нийлсэн акт бүрдүүлэх. Ялангуяа 101,7 тэрбум төгрөгийн өр авлага болбол тооцоо нийлээгүй байсан учраас энийг барагдуулж нийлүүлэх энэ бас ажлууд давхар хийгдэж байгаа.

2-т нь 23 онд ноосны урамшуулал, арьс ширний урамшуулал олгогдоогүй байна гэсэн ийм дүн яригдаж байгаа. Тэгэхдээ 23 оны гүйцэтгэлээрээ авч үзвэл ноосны урамшуулал 9,3 тэрбум төлөвлөгдсөнөөс 6,4 тэрбумаар гүйцэтгэл олгогдсон, 20,6 мянган малчин, мал бүхий иргэнд 4,3 мянган тонн ноосны урамшуулал бол олгогдсон. Энэ.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** 1 номерын микрофоныг сунгая. Гүйцээгээд хариулъя. 1 номер.

**Л.Идэрцогт:** Энэ жил олгох мөн 23 оны жилийн эцсээр бол арьс ширний урамшуулал 8 тэрбумаар олгогдохоор тооцсон, гүйцэтгэлээр 1,2 тэрбум олгогдсон. Ингээд 3543 малчин, мал бүхий иргэн хамаарч, 278 мянган ширхэг арьс ширнийг үйлдвэрлэлд нийлүүлэгдсэний урамшуулал олгогдсон байгаа. 24 оны

эхний хагас жилийн хувьд бол ноос, арьс ширний урамшуулал одоохондоо олгогдоогүй байгаа. Ялангуяа арьс шир болбол мал мах бэлтгэлтэй хамаараад энэ мэдээлэл урамшууллын системдээ бүртгэгдэж ирж, хянах энэ ажил процесс юунд явж байгаа. Ноосны урамшууллын хувьд бол 14 тэрбум төгрөгийн ноосны урамшуулал эхний ээлжид системд бүртгэгдээд, энэний дагуу бид тулгалт хийж байгаа. Энэ нь И баримттай тулгалт хийж байгаа. Нөгөө талаар нь болохоор А данстай тулгалт хийгээд, энэ эцэслэхэд бол энэ 9 сардаа багтаагаад олгогдчихоор ингэж тооцоотой явж байгаа.

3 дахь асуулт нь болохоор ХАА-г дэмжиж олгосон зээлийн үр дүн гэсэн. ЗГ-ын, Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолоор хүнсний аюулгүй байдлын чиглэлээр хэрэгжүүлэх зээлийн хүүгийн хөнгөлөлтөд 23 онд 832 тэрбум төгрөгийн зээлийг олгосон. Энэ зээлийн хөнгөлөлтөд 26 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлтийг олгосон байгаа. Энэ зээл хэрэгжсэнээрээ тодорхой үр дүнгүүд гарсан. Тухайлбал энэ салбарт зээл олгогдсон ААН-үүд дээр 1155 ажлын байр шинээр бий болсон. Мөн хүнсний чиглэлийн 7 үйлдвэр шинээр бий болж, мөн энэ чиглэлийн үйлдвэрүүдээс 13 үйлдвэр дээр тоног төхөөрөмжийн шинэчлэлтүүдийг бас хийсэн байгаа. Ноосны, ноолуурын чиглэлийн 4 үйлдвэр.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Нэмж асууя. Мэндсайхан гишүүний микрофоныг өгье, тодруулъя.

**З.Мэндсайхан:** Энэ 2 санг нийлүүлээд дундын 107 орчим тэрбум төгрөгийн ажил одоо болтол тооцоо нийлээгүй явж байгаа гээд. Энэнийг чинь нийлүүл гэдгийг тухайн үед энэ Жавхлан сайд бид хоёрын хамтарсан ажлын хэсэг үүрэг өгч байсан. Тэгээд энэ яагаад энэ ажлыг хийхгүй байна вэ? Сангаас 100 тэрбум төгрөг алга болчихоод байхад та нар тооцоо нийлээгүй гэдгээр 2, 3 жил



болоод явж байдаг чинь ямар учиртай юм бэ?

2 дугаарт 9,3-ыг төлөвлөснөөс ноосонд 6,4-ийг өгчихлөө гэж байна. 23 оны ноосны урамшуулал, арьс ширний урамшууллаа аваагүй байна гэдгийг малчид өөрсдөө ярьж байна. Тэгээд А данстай холбоотойгоор энийг өөрсдөөсөө зайлуулаад байх асуудал байхгүй. И баримтыг үндэслээд данстай тулгана гэж байна, И баримтыг нь үндэслээд л явах ёстой шүү дээ. Энэ асуудлуудыг ямар хугацаанд шийдэж тэр малчдыг хохиролгүй болгох ёстой вэ? Тэр зээл дээр арилжааны банктэй яг та нар жилийн хугацаанд гэрээний дагуу дүгнэлт хийсэн үү тэр тайлан байна уу л гэдгийг би асуугаад байгаа юм.

**Ц.Даваасүрэн:** Идэрцогт дарга нэмж хариулъя. Дээр нь санхүүжилттэй холбоотойгоор Сангийн яам бас тодруулаад хариулчхаарай. Эхлээд 1 номерын микрофон Идэрцогт дарга.

**Л.Идэрцогт:** ХАА-н корпорац дээр шилжсэн өрийн баталгаажуулалт тооцоо нийлэх ажил бол 50 хувьтай хийгдэж байгаа. Энэний дагуу бас баримтжуулах, зарим эздийн хаягийг тодорхой болгох. Ер нь 2008 оноос олгогдсон зарим өр авлагууд бол эзэн нь тодорхойгүй, хаяг нь тодорхойгүй хууль хяналтын байгууллагаар дамжуулж шийдүүлэх ийм шаардлагууд гарсан учраас цаг хугацааны асуудал орсон. Гэхдээ энийг болбол бид 24 ондоо багтаагаад ер нь цаашидаа 50 хувиас дээшээ ер нь болж өгвөл бүүр их бүгд тооцоог нийлүүлэх энэ чиглэлийг ХАА-н корпорацтай хамтарч хийж байгаа.

Ноос, урамшууллын асуудал дээр бол А данстай тулгадгийн учир нь бас нөгөө ченжээр дамжсан ноос арьс ширэн дээр бас энэ олгочих болзошгүй учраас статистик дээр бүртгэгдсэн, статистикийн бүртгэлтэй энэ систем өөрөө нийлж энэ хүн нь малчин буюу мал бүхий иргэн байх ёстой гэдгийг нотолж

байж авах ёстой. 2-т нөгөө бүртгэл дээрээ энэ хүн ямар төрлийн мал эзэмшдэг вэ, ямар төрлийн малтай вэ энэнээс нь хамаарч энэ нөгөө нэг урамшууллаа тулгаж үзэхгүй болбол бас нөгөө талдаа ийм сөрөг асуудлууд бас гарах магадлал ихтэй байгаа юм.

**Ц.Даваасүрэн:** Сангийн яам тэр төлбөр тооцоотой нь холбогдолтой нь ноос, арьс ширний урамшуулал дээр хариулчихъя. 6 номерын микрофоныг өгье.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Мэндсайхан гишүүний асуултад хариулъя. Тэгээд процессын хувьд болбол ХААЯ-наас бол үндсэндээ болбол хариулчихлаа. Гол асуудал нь юу вэ гэхээр тухайн иргэн болбол ченж биш малчин байх ёстой. Нөгөө мөнгө нь болбол илүү малчин руугаа хүрэх ёстой гэдэг ийм шаардлагуудаа тавиад, процессоо болбол зорчхож байгаа. Бидний хувьд болбол Сангийн яамны хувьд болбол ямар байдлаар энд оролцдог вэ гэхээр бид болбол санхүүжилтийг саадгүй олгох, ХААЯ-ны ирүүлсэн материалын дагуу хянаж ирүүлсэн материалын дагуу саадгүй олгох ийм л ажиллагааг болбол хийж байгаа. 2023 оны хувьд болбол бас яг энэ чиглэлийнх нь дагуу ямар нэгэн байдлаар саатал бол байгаагүй, ирүүлсэн бүх материалын дагуу санхүүжилтийг олгоод явсан.

**Ц.Даваасүрэн:** ХААЯ-ны гүйцэтгэл гаргаж ирснээр бүрэн олгосон гэж байна шүү дээ тийм үү Идэрцогт? Та нарын ирүүлснээр бол бүрэн олгосон гэж байна. Тэгэхээр тэр дутуу яагаад байгаа нь танай дээр гэсэн үг шүү дээ. ХААЯ хариулъя.

**Л.Идэрцогт:** Бид яг шаардлага хангасан нөгөө А данс, И баримтаараа л тулгагдаад гарсан жагсаалтынх нь дагуу олгоод байгаа. Тэгэхээр энэ дээрээс буцчихсан шаардлага дутуу байгаа, энэ дээр бас гомдол саналууд нэлээн гарч



олгогдоогүй байна. Тушаасан ноосны гэдэг асуудал яригдаад байгаа үндэслэлд. Түүнээс биш яг манай дээр бол шаардлага хангасан 23 онд бол 1,2 тэрбум төгрөгийн урамшуулалтыг ноосонд олгочихсон байгаа. Цаана нь болбол ноосонд олгоход бол уг нь санхүүжилтийн эх үүсвэр бол байгаа. Гол нь шаардлага хангаагүй байгаа нөхцөлд бид бас шууд олгочих бололцоогүй байгаа юм. Түрүүний хэлдгээр бас энэний дундуур ченжүүд ороод авчих магадлал их байгаад байгаа юм.

**Ц.Даваасүрэн:** Дутуу хариулсан бол дахиж нэг тодруулж болно. Мэндсайхан гишүүн.

**З.Мэндсайхан:** Тэгээд ХАА-н хөнгөлөлттэй зээлийг та нар гэрээ хийгээд дүгнэсэн үү гэдгийг би асуугаад байхад та огт хариулахгүй байна.

2 дугаарт би ченжүүдийн урамшууллыг хөөцөлдөөд асуугаад байгаа юм биш. Тэр малчид та нарын үйл ажиллагааны доголдоос болоод би ноос, арьс ширээ тушаачхаад авч чадахгүй байна. ХААЯ-ныхан И баримт, нэг бол А данс гээд энийгээ тулгаж байна гэдэг байдлаар бид нар урамшууллаа авч чадахгүй байна гэж малчид ярьж байна. Би ченжүүдийн эрх ашгийг яриад байгаа асуудал огт биш. Ченжүүд авах гэж байгаа үгүйг та нар тогтооно биз. Би тэр малчдын олгогдоогүй байгаа татаасыг яагаад та нар өгөхгүй байна гэдгийг л асуугаад байна. Тэгээд бүртгэл гэж ченжүүд гэж өөрсдөөсөө битгий тойруулаад бай.

**Ц.Даваасүрэн:** 1 номерын микрофон өгье Идэрцогт дарга.

**Л.Идэрцогт:** Арилжааны 10 банкаар дамжиж, ХАА-г дэмжих зээл олгогдож байгаа. Энэ арилжааны 10 банктэй болбол бид сар болгон тооцоо нийлж, Монголбанк, Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам хамтарсан зээлийн ерөнхий гэрээ байгуулаад, энэ ерөнхий

гэрээнийхээ дагуу дүгнэж ингээд арилжааны банкнуудаар бас хуваарь гаргаад энэ гэрээг дүгнэж ингэж явж байгаа. Энэ бол жил болгон тогтмол хийгдэж байгаа ажил байгаа юм.

**Ц.Даваасүрэн:** Түрүүн гишүүд асуугаад дутуу хариулагдсан нэг 2, 3 асуудал байгаа. Энийг ТӨХ-ны ирсэн хүн, Цэнгэл дарга ирээгүй юм уу? Энэ уг нь байна шүү дээ Их Хуралд болбол энэ агентлагийн дарга нар, тэгээд ерөнхийдөө бол бараг ТНБД л, тэгээд тэрнээс дээш албан тушаал хариулах дэгтэй юм байна лээ л дээ. Тэгээд та нар, одоо ТӨХ-ноос ямар хүн ирсэн байна бэ? Хариул, тийшээ суу, 2 номерын микрофон руу оччих. Тэгээд ямар албан тушаалтай хүн ирснээ дурдаад, нэрээ хэлээд.

Ийм асуулт байсан байна шүү. Эхлээд байна шүү дээ Идэрцогт дарга хариулна. Тэр ТӨХ-той холбогдолтой нь болохоор ЭТТ компанийн өр авлагын талаар мэдээлэл өгөөч хэлээч. Хэчнээн хэмжээний авлага авахаар байна, хэчнээн хэмжээний өртэй байна гэдэг ийм зүйл асуугаад байгаа юм. Мөн өмчлөлтэй холбогдолтой асуудал. Жишээлбэл Эрдэнэс тавантолгой компанийн өмчлөлийг өмчлөлийн асуудлыг эрх зүйн хувьд яаж зохицуулж байна вэ гээд. Өчигдөр жишээлбэл Их Хурал дээр бид нар танай эзэмшиж байгаа Тавантолгойн нүүрсэнд байгаа 51 хувийг Их Хурлын шийдвэрээр шилжүүлсэн. Энэ ЗГ-ын хүсэлтээр. Гэтэл ингэж болж байна уу гээд гишүүд асуугаад байгаа байхгүй юу. Яагаад гэвэл тэнд иргэд хувьцаа эзэмшиж байгаа. Тэгээд дангаараа төр ийм шийдвэр гаргаад байж болох уу гээд ингээд гишүүд эрх зүйн хувьд энэ боломжтой юу гэдэг асуудал, ийм 2 зүйл байгаа шүү.

Эхлээд Идэрцогт дарга байна шүү дээ тэр малын гаралтай түүхий эдийг гаалийн татвараас чөлөөлөх арга хэмжээнүүд авсан гээд. Энэ ямар үр дүнгээ өгөв, хэчнээн үйлдвэрүүд энэ малын гаралтай түүхий эдийн чиглэлээр

баригдаж байна вэ гэсэн ийм асуулт байна. Идэрцогт дарга хариулаад, дараа нь ТӨХ. 1 номерын микрофон эхэлж өгье.

**Л.Идэрцогт:** ХХААХҮЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Идэрцогт. Асуултад хариулъя. Малын гаралтай бүтээгдэхүүн тэр тусмаа болбол өнгөрсөн жил 23 оны гүйцэтгэлээр бол мал, мах, махан бүтээгдэхүүнийг экспортод гаргасан. Үүгээр 80,4 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн, энийг нойтон мах шилжүүлснээр бол 120 мянган тонн, хонин толгойд шилжүүлснээр бол 6,4 саяд толгой малд ноогдох энэ бүтээгдэхүүнүүдийг бол экспортод гаргасан байгаа. Ингэснээрээ болбол экспортын бүтээгдэхүүний орлого нэмэгдсэн. 380 сая долларын экспортын бүтээгдэхүүний орлого орж ирсэн. Өмнөх жилүүдтэй харьцуулбал энэ дүнгээр бусад орлого бүрдүүлэх дээр бол эерэг үзүүлэлт гарсан. Энэ гаалийн татварын асуудлыг шийдвэрлэснээр болбол бас ийм огцом эерэг үзүүлэлтүүд гарсан байгаа. Мөн дээр нь импортыг орлох бүтээгдэхүүний хувь хэмжээ бол 5,9 хувиар буурч, импортыг орлох бүтээгдэхүүнүүдийн орлогыг нөхөх энэ үр дүн бас харагдсан гарсан байгаа.

**Ц.Даваасүрэн:** Төрийн өмчийн хороо. Үйлдвэрүүдийг нь чадсангүй дээ. ТӨХ, 2 асуудал.

**Д.Нарангэрэл:** ТӨБЗГ-ын дарга Цэнгэл амралтаа авчихсан байгаа. Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Нарангэрэл байна. Асуултад хариулъя. ЭТТ ХК-ийн хувьд хувьцаа эзэмшигч нь Эрдэнэс Монгол компанийн харьяанд байгаа учраас тухайн компанийн санхүү, эдийн засгийн үзүүлэлт болон бизнес төлөвлөгөө, түүний гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг болбол манай дээр тодорхой мэдээлэл одоогоор надад бол байхгүй байна. Өмчлөлийн хэлбэр болон эрх зүйн зохицуулалтын асуудал ч гэсэн компанийн дүрэм болон хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Эрдэнэс Монгол толгой

компани дээр байгаа учраас энэ талаар бас холбогдох хүмүүс бас тайлбар хэлэх байх гэж бодож байна.

**Ц.Даваасүрэн:** Эрдэнэс Монгол нь болохоор Хэрэг эрхлэхийн харьяанд байгаа учраас. Тэгвэл Эрдэс Монголын төлөөллийг Наранхүү даргыг дуудах уу. Наранцогт даргыг дуудъя. Монголбанк. Монголбанкны төлөөлөл байна уу? Монголбанкнаас гишүүд ийм асуулт асуусан байгаа. Капитал банк дампуурлаа зарлаад, бүрэн эрхт төлөөлөгч томилсон. Энэ дээр ямар хэмжээний нийгмийн даатгал, ЭМД-ын авлагууд байна. Мөн өр барагдуулалт нь яаж явж байна вэ? Чингис банк ямар нөхцөл байдалтай байна вэ, яагаад дампуурал зарлахгүй байна гэсэн ийм нэг хэдэн асуулыг гишүүд асуусан байгаа. Энэ асуултаудад хариулъя. 4 номерын микрофон.

**Д.Ган-Очир:** Сайн байцгаана, та бүхэндээ өдрийн мэндийг хүргэе. Капитал банк.../үг тасрав/

**Ц.Даваасүрэн:** Албан тушаалаа хэлээд, нэрээ хэлье.

**Д.Ган-Очир:** Сайн байцгаана уу. Монголбанкнаас Монголбанкны ерөнхий эдийн засагч Ган-Очир байна. Яг Капитал банкнаас.../үг тасрав/

**Ц.Даваасүрэн:** Танайх чинь Дэд ерөнхийлөгч гэж хүн байхгүй болчихсон уу?

**Д.Ган-Очир:** Байгаа манай Дэд ерөнхийлөгч.

**Ц.Даваасүрэн:** Яагаад ирэхгүй ингээд хариуцлагагүй хандаад байгаа юм бэ Их Хуралд? Та нар чинь өөрсдөө бүүр Их Хурлын байгууллага шүү дээ. Тэгээд эдийн засагч явуулчихсан. Энэ Хэрэг эрхлэхэд ер нь нэг жоохон бид нар бичиг, Их Хурал ч энэ Монголбанк ч манай байгууллага юм, нэг жоохон энэ анхааралтай хандахгүй болбол бүүр ерөөсөө мэргэжилтэн, тэгээд зөвлөх энэ

тэр гэсэн улсууд хариулах энэ нөгөө дэгээрээ байхгүй байхгүй юу. Хэтэрхий энэ нэг Их Хурлын үйл ажиллагаа суларч байна шүү. Энэ удаа бол яах вэ тэгээд ингээд явъя. Цаашидаа би мэргэжилтнүүдээр, хэлтсийн дарга нараар ер нь бол хариулт авахгүй. Доод тал нь газрын дарга. Төсвийн байнгын хороон дээр болбол яг энэ хуулийнхаа дагуу дэгээрээ явна шүү.

**Д.Ган-Очир:** Капитал банкин дээр 2019 онд бүрэн эрхт төлөөлөгчийг Монголбанкнаас томилж ажиллуулж байгаа. Тэгээд үүнтэй холбогдуулаад үндсэндээ тэр банкны үйл ажиллагаа, үүний санхүүгийн гүйцэтгэл, өр авлага тэр бүх мэдээллийг болбол Капитал банкны бүрэн эрхт төлөөлөгч түүний баг хариуцдаг. Тэгэхээр болбол Төсвийн байнгын хороонд болбол энэ багаас гаргасан дэлгэрэнгүй тайлан мэдээллийг болбол хүргүүлъя. Яг ерөнхий эдийн засагчийн хувьд болбол энэ төрлийн мэдээлэл нарийн мэдээллүүд болбол хувь хүн дээр ирдэггүй учраас болбол энэ удаа болбол хариулах бололцоо болбол хязгаарлагдмал байна.

Чингис хаан банкны хувьд болбол Банкны хяналт, шалгалтын хорооны гишүүний хувьд болбол өөрт байгаа мэдээллийг болбол танд энэ удаа уламжилъя. Чингис хаан банкны нөхцөл байдал болбол сүүлийн 2, 3 жилийн туршид бол гаруй хугацаанд болбол хүндрэлтэй байгаа. Тэгэхдээ болбол хэд хэдэн үндэслэлээр болбол таны сая асуусан татан буулгах юм уу, Банкны тухай хуульд байгаа дараагийн шатын арга хэмжээ авахгүй бас хойшлуулах ийм арга хэмжээнүүдийг авч явдаг.

Эхний гол үндэслэл болбол шинэ хувьцаа эзэмшигч нар, гаднын хөрөнгө оруулагч нар орж ирэх гэж байгаа, хувьцаагаа авах гэж байгаа, хувь нийлүүлж байгаа тухай мэдээллүүдийг болбол удаа дараа болбол Монголбанк, Монголбанкны хяналт шалгалтын хороонд болбол өгдөг. Энэ дагуу ч гэсэн

тодорхой хэмжээний дүнгүүд болбол орж ирж байгаа, орж ирэх гэж байгаа гэдэг мэдээллээр болбол бас тодорхой мэдээллүүд яваад байгаа. Тэгэхээр энэ асуудлууд нь болбол ямар шатдаа байгаа сүүлийн мэдээллүүдийг болбол шаардлагатай болбол Төсвийн байнгын хороонд болбол ирүүлж болно.

2 дахь гол үндэслэл болбол өмнөх бас Монголбанкны энэ Капитал банк тэрний өмнө бас банкнууд дээр бүрэн эрхт төлөөлөгч ч гэдэг юм уу, дараагийн шатын арга хэмжээ аваад өр, авлагыг хариуцсан үйл ажиллагааг хийх үед болбол бас маш олон шүүмжлэл, үр ашиггүй байдал, дараалалд өөрчлөлт орж байгаа гэдэг ийм асуудлууд болбол гарч ирсэн. Тэгэхээр Монголбанкнаас Чингис хаан банкин дээр тавьж байгаа.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** 4 номерын микрофоныг нэмж нэг минут өгье.

**Д.Ган-Очир:** балансыгаа хумих арга хэмжээ авхуулж байгаа юм. Нэг ёсондоо активуудыгаа зээлийн барьцаанд байгаа активуудыгаа банкаар нь өөрөөр нь борлулуулаад, тэрнээс гарч ирж байгаа мөнгөн хөрөнгүүдийг болбол тэрний өр авлагын дарааллууд гэж байгаа өр төлөх, энэ дарааллынх нь дагуу хуулийн дагуу болбол өгөх үйл ажиллагааг нь болбол банкаар нь өөрөөр нь хийлгэж байгаа. Энэ нь болбол үр ашиг болоод зах зээлийн үнээр барьцаа хөрөнгийг борлуулах, түүн дунд болбол төр болон төртэй холбоотой этгээд орсноос үүсэх эрсдэлүүдийг болбол бууруулах гэдгээр болбол арга хэмжээ авч байгаа. Нэлээд үр дүнтэй байгаа гэдэг мэдээллийг болбол Монголбанкны Хяналт шалгалтын хороонд болбол өгч байгаа. Тэгэхээр энэ үндэслэлүүд бол явж байгаа. Мэдээж яг төртэй холбоотой өр, авлага түүний дараалал болбол яг Банкны тухай хууль болон холбогдох хууль дээр заасан энэ дарааллынхаа дагуу явж байгаа, төлөгдөөд явж байгаа л гэж ойлгож байгаа.

**Ц.Даваасүрэн:** Тийм. 1 дүгээрт би асуугаагүй энэ гишүүд асуугаад хариулт байхгүй байсан учраас өөрийг чинь дуудсан. 2 дугаарт би хувь хүнээс энэ асуултыг тавиад байгаа юм биш Монголбанкийг төлөөлөх хүнээс асуугаад байгаа байхгүй юу. Тийм учраас энэ гишүүний асууж байгаа асуултад бүрэн хариулах хүнээ одоо дуудъя. Тэгээд энэ 2 банктэй холбогдолтой хэчнээн хэмжээний төрийн мөнгө байна, барагдуулалт нь ямар байна энэ асуултад бүрэн хариултыг нь өгье. Тэр төлөөлөх энэ мэдээллийг өгч чадах хүнээ яаралтай дуудъя. Ганзориг гишүүн асууя.

**П.Ганзориг:** 2023 оны улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд Үндэсний Аудитын газраас хийсэн дүгнэлт дээр ерөнхийдөө аудитаар 17 зөвлөмж хүргүүлснээс ерөөсөө бүрэн хэрэгжсэн нь гуравхан зөвлөмж байна гэж байна. Өөрөөр хэлбэл хэрэгжилт нь 20-хон хувьтай гэсэн үг, 20 хүрэхгүй хувьтай. Тэгээд эндээ болохоор төсвийн сахилга бат хангалтгүй муу байгааг харуулж байна гээд дүгнэчихсэн байж байна. Тэгэхээр бид нар улсын төсвийн орлогоо бүрдүүлэхээ болохоор ялангуяа энэ татвар дээр болбол давуулаад 10 орчим хувиар ингээд биелүүлчхээж байгаа юм. Татварын чинь ихэнхийг нь хувийн хэвшил бүрдүүлж байгаа. Хувийн хэвшилээс бид нар татвар төсвөө бүрдүүлэхээрээ дансыг нь хааж байгаад торгож байгаад ингээд төсвөө бүрдүүлчихдэг. Цалингаа тавих гэж байсан, бизнесийнхээ эргэлт үйл ажиллагааг тэлэх гэж байсан мөнгийг нь хааж байгаад торгож байгаад бүрдүүлдэг. Буцаагаад төсөв дээрээ авчраад зарцуулахаараа ингээд хяналт муутай, сахилга бат муутай ингээд замбараагүй зарцуулж байна.

Энэ Үндэсний аудитын газрын дүгнэлт дээр байгаад байна шүү дээ. Маш олон асуудал байна дурдах юм бол. Тэгэхдээ ерөнхийдөө энэ асуудал яагаад ийм сул байгаад байгаа юм бэ? Гол асуудал нь яг юундаа байгаад байгаа юм

бэ? Хэрэгжихгүй байгаад байгаа юм бэ, зөвлөмжүүд өгсөөр байтал, 20 хувьтай, бүрэн хэрэгжсэн нь 20-хон хувь байна гэдэг бол маш хангалтгүйг харуулж байна шүү дээ. Ер нь цаашид энийг яаж сайжруулах юм бэ гэдэг ийм 2 асуулт байна.

Дараагийнх нь болохоор, энэ нийгмийн даатгалын сан, ЭМД-ын сангийн 2023 оны чөлөөт үлдэгдэл бараг 1,3, 4 их наяд төгрөг. Арилжааны цөөхөн хэдэн банканд байршиж байгаа. Тухайлбал Хаан банканд 500 орчим тэрбум төгрөг байршиж байсан гээд сая мэдээлэл өгч байна. Голомт банканд 100 гаруй, 200 орчим тэрбум төгрөг ч гэдэг юм уу. Ингээд байршихдаа ямар хэмжээний хүүтэй байршиж байгаа вэ? Ер нь болбол зөвхөн энэ эрүүл мэнд, нийгмийн даатгалын сан гэлтгүй ТӨК-уд байж байгаа ЭТТ бусад олон ТӨК-уд, сангуудын мөнгө байршиж байгаа юм. Энэ мөнгөнүүд ер нь ямар хүүтэй байршаад байдаг юм бэ? Төсвийн мөнгө чинь эргээд л цаанаа татвар төлөгчдийн мөнгө байж байгаа шүү дээ тодорхой хэсэг нь. Тэгээд буцаагаад арилжааны банкнаас иргэд, ААН зээл авахаараа 20-оос 30 хувьтай зээл авдаг. Арилжааны банкнууд нь хажуудаа баахан банк бусуудтай тэрүүгээрээ 30-аас 40 хувьтай зээлдэж байна лээ. Тэгэхээр ийм асуудал дээр ер нь Монголбанк ямархуу бодлого барьж байгаа юм бэ, Сангийн яам?

Татвар төлөгчдийн мөнгө төсөв рүү ороод, төсвийн орлого болоод буцаад банкин дээр очоод байршихаараа хүүтэй байгаа юм уу, хүүгүй байгаа юм уу, ямар хүүтэй байгаад байгаа юм бэ? Эргээд иргэд нь, ААН нь зээл авахаараа маш өндөр хүүтэй зээл авдаг, маш хүнд нөхцөлтэй, хамаг барьцаа, маш өндөр шалгуур тавьж байж авдаг. Тэгэхээр энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч. Ямар хэмжээний хүү, ямар хэмжээний хүүгийн орлого олсон бэ? 1 минут сунгаад авчих уу?



**Ц.Даваасүрэн:** 1 минут сунгая, Ганзориг гишүүний микрофоныг өгье.

**П.Ганзориг:** 3-д энэ ЗГ-ын газар болон төсвийн байгууллагын данс нийт хаах журам дээр маш тодорхой заачихсан байж байгаа. Энэ санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 2.3-д заасан зөвшөөрлийг олгоходоо Монгол Улсын ЗГ-ын болон төсвийн байгууллагын банкны банкин дахь өглөг харилцах хадгаламжийн дансыг тухайн банкны нийт активын 30 хувиас хэтрүүлэхгүй байна гээд. Энэ шаардлага ер нь ямар байгаа вэ банк болгон дээр?

Тэгээд Аудитын газрын дүгнэлт дээр бас нэг тодруулах зүйл байгаад байгаа юм. Энэ замын түгжрэлийг бууруулах төсөл арга хэмжээнд батлагдсан санхүүжилтээс 260 тэрбум төгрөг зарцуулсан, олгосон. Тэгэхдээ хөрөнгийн зардлын санхүүжилтийг 76,5 тэрбум төгрөгөөр бууруулж тайлагнасан байна гээд тэгж байгаа юм. Энэ зөрчил юм уу юу юм бэ? Энийг нэг жоохон тодорхой тайлбарлаач. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Хариулъя. Эхлээд аудит 8 номерын микрофон өгье.

**Я.Самбууням:** Ерөнхий аудиторын орлогч Самбууням байна. Ганзориг гишүүний асуултад хариулъя. Ганзориг гишүүний хэлж байгаа яг үнэхээр манай энэ төрийн аудитын байгууллагаас өгч байгаа зөвлөмжийн хэрэгжилт болбол хангалтгүй байгаа нь үнэн. 2022 оны ЗГ-ын нэгдсэн тайлангаар бид болбол нийтдээ өгсөн зөвлөмжийн хэрэгжилт болбол 72,2 хувийн биелэлттэй байгаа. Ер нь болбол цаашидаа энэ төсөв захирагч нарт өгч байгаа акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах үүднээс Төрийн аудитын байгууллагын Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлд болбол нэмэлт, өөрчлөлт орсон байгаа. Энэ дээр болбол зөвлөмжийн төлөвлөгөөг төсөв, зөвлөмж авсан аудитад хамрагдагч

байгууллага болбол зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ. Мөн хэрэгжилтийг хангасан тайлангаа ирүүлж байх зохицуулалт орсон.

Энийг хэрвээ хэрэгжүүлээгүй тохиолдолд болбол албан тушаалаас нь чөлөөлөх хүртэл арга хэмжээ авахаар ийм хуулийн зохицуулалт орсон байгаа. Энэ хууль болбол сая 24 оны 1 сараас хэрэгжиж эхэлсэн. Тэгэхээр зэрэг бид энэ хуулийн хэрэгжилтээ болбол хангуулж ажиллана. Зөвлөмжийн мөрөөрх ажлаа болбол хангуулахад анхаарч ажиллаж байна.

Ерөнхийдөө энэ санхүүгийн тайлангийн аудитаар илэрч байгаа алдаа зөрчил байнга ингээд давтагдаад байгаа нь болбол хэд хэдэн үндэслэл байна гэж харж байгаа юм. Эхнийх нь болбол энэ санхүүгийн ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах, эдгээр ажилтнуудын цалин хөлсийг тогтвортой байлгах, тогтвортой ажиллуулахад анхаарах. Эдгээр хүмүүсийг болбол мэргэжлийн хүмүүсийг томилж ажиллуулах. Мөн сургалтын асуудал болбол энд орхигдоод байна. Мөн төсөв захирагчийн дотоод аудитын хяналт болбол хангалтгүй байгаагаас энэ алдаа зөрчил байнга давтагдаж байна гэж үзэж байна. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Сангийн яамнаас бас асуугаад байна. Сангийн яам 6. Тэрний дараа нийгмийн даатгал, ЭМД нөгөө дансны үлдэгдэл, Төрийн сан нь хариулах юм уу юу нь төсвийн дарга нь хариулах юм уу? Тэр үлдэгдэлтэй холбогдолтой юм байгаа шүү дээ. Тэр нь уг нь төрийн сан нь илүү мэдмээр юм. Мөнгөө яаж байршуулж байгаа юм бэ? Хүүтэй юү, үгүй юү? Хэдий хэмжээний хүүтэй байршидаг юм бэ гээд байна шүү дээ. Чи хариулж болохоор байна уу? 6 номер. Тэгээд нийгмийн даатгал, ЭМД-ынхан хариулъя.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Ганзориг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр ЭМД-ын сан болон нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг бол арилжааны банканд хадгалуулах асуудлыг болбол Сангийн яамны зүгээс болбол ерөнхий зарчмын хувьд болбол дэмждэг. Дэмжээд энэ дагуугаа бол ажиллаж байгаа. Нөгөө талдаа болбол энэ 2 ийм эсрэг тэсрэг бас нэг туйлын асуудал болчхоод байгаа. Нэг талдаа болбол арилжааны банканд хадгалуулж нэг хүү олох их чухал байгаад байгаа. Өөрөөр хэлбэл арвижуулах асуудал тийм ээ шимтгэлийн орлогыг.

Нөгөө талдаа болбол энийг бас аюулгүй байдлыг бид нар хангах, эрсдэлгүй байлгах асуудал болчхоод байгаа. Одоогийн байдлаар сая түрүүн нэр дурдагдсан энэ 2 банк Капитал болон Үндэсний хөрөнгө оруулалт эдгээр банкнуудыг Чингис Хаан гээд бас ингээд банкнууд дээр болбол эрсдэл бүхий байршуулчихсан хөрөнгөө одоо хүртэл бас нийгмийн даатгалын сан, ЭМД-ын сангууд бол олж аваагүй тийм зүйлүүд бас байгаад байгаа юм.

Тухайн үедээ болбол эдгээр банкнууд нь бол өөрөө болбол Монголбанкны бүх шалгууруудаа хангачихсан үйл ажиллагаагаа явуулж байсан эрсдэлгүй гэдэг ангилалтай байсан. Сангууд болбол тухайн үед бол олонхын шийдвэрээрээ бас энэ Удирдах зөвлөлөөсөө болбол бас ингээд шийдвэрээ гаргаад мөнгөө хадгалуулчихсан байгаад байдаг ийм зүйл байсан. Энэ асуудал болсны дараа болбол бас Улсын Их Хурал дээр болбол энэ талаар бол нэлээд том асуулга болоод ЭМД-ын сангийн хөрөнгийг болбол одоо бол яаж байна вэ гэхээр бол огт арилжааны банканд хадгалахгүйгээр зөвхөн Монголбанк дахь дансанд буюу Төрийн сангийн Монголбанк дахь дансанд хадгалахаар болбол хуульчилчихсан байгаа. Тэр дагуугаа бол хуульчлаад явж байгаа. Тэгэхээр болбол цаашидаа бид нар болбол Эрүүл мэндийн

даатгалын тухай хуулийг бол шинэчлэх, энэ мөнгийг арвижуулах тал дээр ажиллахдаа энийг эргэж харах боломжтой.

Нийгмийн даатгалын сангийн хувьд болбол одоогоор болбол чөлөөт үлдэгдэл бол 500 орчим тэрбум төгрөг байгаа. Тэгэхдээ энэ дандаа харилцах дээр байдаг. Өөрөөр хэлбэл сарын эхэнд тэтгэврээ өгөөд, сарын дундуур.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Үгүй ээ үгүй гол асуулт нь болохоор байна шүү дээ хэдэн хувийн хүүтэй байршуулж байна вэ? Та нар бонд гаргахдаа өөрийнхөө мөнгийг эргээгээд өндөр хүүтэй болгоод авчхаад байгаа юм биш биз дээ гэж асуугаад байгаа байхгүй юу. 6 номерын микрофон.

**М.Санжаадорж:** Арилжааны банкны хадгаламжийн дансанд байгаа нийгмийн даатгалын сангийн хөрөнгө болбол яг тэрүүгээрээ арилжааны банкттайгаа тохирсон байдлаар л хадгалж байгаа. Тэрнээс биш хугацаатай хадгаламжид бол байршуулах тийм маневрлах боломж бол одоогоор Нийгмийн даатгалын санд бол байхгүй байгаа. ЭМД-ын сангийн хөрөнгө болбол манай дансанд байгаа. Хүү бол бодогдож байгаа зүйл байхгүй. Бонд авах эрх нь бол байгаа. Монгол Улсын 2025 он.../үг тасрав/

**Ц.Даваасүрэн:** Одоо ингээд та нар ЗГ-ын бонд гаргаж байгаа шүү дээ.

**М.Санжаадорж:** Бид бол бонд яагаагүй.../үг тасрав/

**Ц.Даваасүрэн:** Банкнууд жишээлбэл бонд авна тийм үү?

**М.Санжаадорж:** Тийм.

**Ц.Даваасүрэн:** Тэгэхэд тэр одоо та нар ингээд маш бага хүүтэй хадгалуулчхаад, эргээд өндөр үнэтэй төсвийн бонд ашиглаад байгаа юм биш

биз дээ гэж асуугаад байгаа байхгүй юу. Хэдээр байршуулж байна вэ? Бондын чинь хүү хэд байна гээд байгаа юм.

**М.Санжаадорж:** Ойлголоо. Нэг талдаа сул эх үүсвэр байгаад байгаа, нөгөө талдаа арилжааны банкны бондын хямд эх үүсвэр, үнэтэй эх үүсвэр ашиглаад байгаа юм биш биз дээ гэдэг асуулт асууж байна. 23 оны хувьд болбол бид нар бол арилжааны банкны бондын эх үүсвэр болбол ашиглаагүй байгаад байгаа юм. Тийм тэгэхээр дотоод төрийн сангийн үлдэгдлээр явчихсан бонд авах дээр.

**Ц.Даваасүрэн:** Та нар бонд гаргасан байгаа шүү дээ?

**М.Санжаадорж:** Тийм, өмнө нь бол тэгж явж байсан.

**Ц.Даваасүрэн:** Тэр бондын чинь хүү үнэтэй байгаа юм биш биз дээ энэ хадгалуулж байгаагаас чинь.

**М.Санжаадорж:** Цаашидаа цаашидаа энэ талаар анхааръя дарга. Энэ эх үүсвэрийг илүү хүүтэй.../үг тасрав/

**Ц.Даваасүрэн:** Тэгэхээр энэ дээр бол бас асуудал байна гэсэн үг шүү.

**М.Санжаадорж:** Ойлголоо дарга.

**Ц.Даваасүрэн:** ЗГ-ын хадгалж байгаа хүү нь ЗГ-ын төлж байгаа бондын хүүгээсээ бага байна гэж. Нийгмийн даатгалынхан аль микрофон дээр хариулах юм бэ? Нийгмийн даатгалын хүмүүс хаана байна вэ? ЭМД хаана байгаа юм бэ? Тэр 1 номерын микрофон дээр шилжээд хариулчихъя. 1 номер Идэрцогтын тэр микрофон дээр очоод хариулчих. Дараа нь нийгмийн даатгал шүү. Нөгөө банканд алдчихсан байгаа мөнгөнүүд, тэгээд ер нь хэд ямар хувийн хүүтэй байршаад байна энэ тэр гэдгээ тодорхой хариулъя. 3 номер.

**Л.Бямбасүрэн:** ЭМД-ын ерөнхий газрын дарга Бямбасүрэн. Асуултад хариулъя. Манай газар Монгол Улсын ЗГ-ын 2017 оны 344 дүгээр тогтоолын дагуу Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар гэж байгуулагдсан байгаа. Энэ маань НДЕГ-аас салж, биеэ даасан байгууллага болсон.

Ингээд энэ үед арилжааны банканд харилцах хадгаламж хэлбэрээр байршиж байсан 444,4 тэрбум төгрөг, ЗГ-ын бонд 31,2 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийг НДЕГ-аас шилжүүлэн хүлээж авсан байдаг. Энэ мөнгөн хөрөнгийн нэг хэсэг нь Капитал банканд хадгаламж хэлбэрээр 10 тэрбум төгрөг, харилцах хэлбэрээр 122,5 тэрбум төгрөг, нийт 132,5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байсан. Ингээд манай ЭМД-ын сангийн нэхэмжилсэн нийт дүн тухайн үед 136,1 тэрбум төгрөг байсан. ЭМД-ын санд төвлөрсөн мөнгөн дүн 9,9 тэрбум. Мөн эрүүл мэндийн, ингээд манайх бол ЭМД-ын сангийнхаа авлагад тооцоод Капитал банкны эрх хүлээн авагчаас 47,2 тэрбум төгрөгийн 78 объектыг бол хүлээж авсан байгаа. Үүнээс 31,5 тэрбум төгрөгийн 68 объектыг ЭМДЕГ дангаараа, 15,7 тэрбум төгрөгийн 10 объектыг НДЕГ-тай хамтарч ингэж бол хүлээж авсан байгаа.

Ингээд Капитал банкнаас энэ 136,1 тэрбум төгрөгийн авлагаас 2024 оны 8 дугаар сарын 23-ны байдлаар тус банкны эрх хүлээн авагч 11,8 тэрбум төгрөгийг бэлнээр төлсөн байгаа. Би түүрүүн хэлсэн 46,7 тэрбум төгрөгийн үл хөдлөх.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** 3 номерын микрофоныг нэмэлт минут өгье. 1 минут өгчихье.

**Л.Бямбасүрэн:** Ингээд хөрөнгө хүлээж авснаас 10,5 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын орлого ЭМД-ын санд төвлөрсөн байгаа. Одоо

Капитал банкны эрх хүлээн авагчаас авах авлага маань 77,6 тэрбум төгрөгийн авлага байгаа.

Чингис хаан банктай холбоотой мөн бид нар бас энэ бол 16 оны 8 дугаар сарын 8-ны өдрөөс эхэлсэн асуудал юм байна лээ Чингис банктай холбоотой. Одоо бол манай авлага 30,7 тэрбум төгрөгийн авлагатай байгаа. Энэ шүүхэд хандсан. Дээд шүүхийн шийдвэр бол манай талд гарсан, энэ Чингис хаан банкнаас энэ мөнгийг ЭМД-ын санд төвлөрүүл гэсэн. Тэгээд энэ дээр бол бид нар Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газарт бол удаа дараа албан тоот хүргүүлж, энэ хөрөнгийг манай санд төвлөрүүлэх талаар шаардлага бол тавиад ажиллаж байгаа.

**Ц.Даваасүрэн:** Одоо ямар хүүтэй байршиж байгаа юм бэ гээд байсан. 3 номерын микрофоныг дахиад өгчихье.

**Л.Бямбасүрэн:** Арилжааны банканд орж ирсэн шимтгэлийн орлого оны эцсийн үлдэгдлээр гарсан төвлөрүүлэлт маань ЭМД-ын санд энэ хадгаламжид бол ямар нэгэн хүүгүй байршиж байгаа мөнгөн хөрөнгө маань. Бид нар бол 7 хоног тутам арилжааны банканд нийгмийн даатгалын сангаас орж ирсэн манай ЭМД-ын шимтгэлийн орлого арилжааны банканд эд нар шилжүүлдэг. Тэрнээсээ бид нар 7 хоног тутам төрийн сан руу татаад явж байгаа. Арилжааны банканд бол мөнгө 7 хоногоос илүү байршдаггүй гэсэн үг, 7 хоног тутам татаад явчихдаг. Тэгэхээр арилжааны банканд бол хүү тооцохгүй байгаа.

**Ц.Даваасүрэн:** 7 хоног бол сул ашиглагддаг л юм байна. Энийг анхаарах хэрэгтэй л юм байна. Нийгмийн даатгалаас хариулья. Ер нь ЭМД-ынхан байна шүү дээ тэг үлдэгдэлтэй дансны аргаар оройдоо татагддаг хэлбэрээр явж болно. Ер нь тийм чиглэлийг бас өгөх нь зүгээр л юм байна. Сул чөлөөтэй мөнгө 7 хоног гэдэг чинь асар үнэтэй мөнгийг

алдаж байна гэсэн үг шүү дээ. Энэ чинь шөнийн overnight зээл гээд байж байхад чинь 7 хоног зүгээр юм шиг юм яриад байж болохгүй байхгүй юу. Тийм шөнийн зээл гэж байж байхад чинь та нар болбол 7 хоног зүгээрээ гээд ингэж болохгүй.

Тийм учраас ер нь энэ ЭМД-ынхан энэ чөлөөт үлдэгдлийнхээ юуг жоохон тодорхой бас үр ашигтай болгохгүй бол болохгүй. Түрүүн Ганзориг гишүүний хэлээд байгаа үнэн шүү дээ. Наадах чинь тэгээд 7 хоног үнэгүй. Тэгсэн мөртөө бид нар банкнаас бонд босгохоор үнэтэй, өндөр хүүтэй авдаг ийм юм байгаад байгаа юм. Нийгмийн даатгал яах бэ? Нийгмийн даатгал яачихсан юм бэ? Энэ нийгмийн даатгал яагаад байгаа юм бэ? Энэ Гэр бүлийн яам чинь ер нь яачихсан яам юм бэ? Ерөөсөө хүн байна уу тэнд, бүгдийг нь халчихсан юм уу? Өмнөх хуралдаан дээр бас байхгүй, одоо бас байхгүй. ЭМД-ыг ойлголоо. Одоо Нийгмийн даатгалын сангийн үлдэгдлийг гишүүд сонирхоод байна шүү дээ. Энэ мөнгө яасан бэ? Хэд хэдэн удаа, хэний шийдвэрээр байршуулсан бэ гээд байгаа шүү дээ. Тэгээд банкин дээр энийг төлөлт нь ямар байгааг бас танилцъя гээд байгаа учраас энэ нийгмийн даатгалын нөхдүүдийг. Ганзориг гишүүн тодруулах юм уу? Дуудаж байя энэ хооронд. Ганзориг гишүүн тодруулахгүй юу? Тодруулчихъя.

**П.Ганзориг:** Ер нь энэ төсвийн мөнгө, сангуудын мөнгө, ТӨК-удын бас мөнгөнүүд гээд энэ арилжааны банканд бас их хэмжээгээр байршиж байгаа энэ мөнгөнүүдийг ер нь жоохон ил тод ингээд тайландаа тусгаж бас мэдээлэл өгдөг байхгүй бол болохгүй. Төсвийн сахилга бат, үр ашиг гэдэг дотор чинь энэ аягүй чухал үүрэгтэй шүү дээ. Тэгээд сангуудын мөнгө банканд байршихаараа дампуурчхаад байна гээд, эрсдэлтэй тийм болохоор Монголбанканд дээр байршуулах асуудал энэ тэр бас чухал, 2 талаас нь харах хэрэгтэй гээд. Чухлаа чухал.



Тэгэхдээ төлбөрийн чадваргүй болж байгаа эсвэл тэр Чингис хаан банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк 2 дээр хэдэн жилийн өмнө гарч байсан тохиолдол байгаа шүү дээ. Өөрсдийнх нь тэр активын тодорхой хязгаарт хүрэх ёстой юмыг нь эрх мэдэлтэй хүмүүс давуулаад л байршуулчихсан байсан шүү дээ. Тийм жишээгээр муу жишээгээр нь тайлбарлаад ингээд байж болохгүй байх. Тэгээд би тодруулах юм болбол энэ мэдээллүүдийг бас надад ирүүлээч дэлгэрэнгүй. Одоо хариулах боломжгүй байгаад байгаа болбол ямар, ямар хэмжээтэй мөнгөнүүд, тэр журам байгаад байгаа шүү дээ ЗГ болон төсвийн байгууллагуудын дансыг нээх, хаах журамд тавьсан шаардлага байгаа даа 30 хувь гэгчихсэн. Тэрэндээ хэр хангагдаж байгаа юм бэ гэдэг юмыг тодруулмаар байна.

Түрүүн Үндэсний аудитын газраас бас нэг асуултад хариулсангүй. Тэр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар замын түгжрэлийг бууруулах төсөл арга хэмжээнд батлагдсан санхүүжилтээс 260 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Хөрөнгийн зардлын санхүүжилтийг 76 тэрбум төгрөгөөр бууруулан тайлагнасан байна гээд. Энэ зөрчил гээд байгаа юм уу? Зөрчил юм бол ямар зөрчил юм бэ? Яагаад бууруулсан гээд байгаа юм бэ? Ийм тодруулга.

**Ц.Даваасүрэн:** Ганзориг гишүүний асуултад 8 номерын микрофон Үндэсний аудитаас хариульа.

**Я.Самбууням:** Үндэсний аудитын газар Самбууням. Ганзориг гишүүний асуултад хариульа. Манай төсвийн, 2023 оны төсвийн гүйцэтгэлд өгсөн энэ дүгнэлттэй холбогдуулсан асуулт. Энэ дээр болбол юу вэ гэхээр зэрэг Нийслэлийн Засаг даргад нөгөө замын түгжрэлийг бууруулах зорилгоор нийтийн тээврийг сайжруулахад 318 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй автобус худалдан авах эрх шилжсэн байгаа юм. Энэнээс нь бол та бүгдийн мэдэж байгаа нөгөө ногоон

автобусны асуудлаас болоод хууль хяналтын байгууллагаас төсөвт учруулсан хохирлын хэмжээг нь 76,5 тэрбум төгрөг гэж тогтоосон. Энийг болбол хөрөнгө оруулалтаас нь хасаж ингээж олгосныг бид дүгнэлтдээ оруулсан байгаа юм. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** 8 номерын микрофон, ямар зөрчил юм бэ гэж асуугаад байна.

**Я.Самбууням:** Улсын төсөвт хохирол учруулсан байна гэдэг дээр нь ийм дүгнэлт гаргаж байна.

**Ц.Даваасүрэн:** Түвшин гишүүн асуултаа асууя.

**Б.Түвшин:** Та бүхнийхээ энэ өдрийн мэндийг эрье. Тэгээд энэ аудитын тайлан 2 том тайлан ирээд, 2 өдрийн дотор унших гээд. Тэгээд та хэдийн энэ их хийсэн ажлыг бараг уншиж ч амжихгүй, тэгээд л нэг ийм түүвэр байдлаар л асуух л болох гээд байна. Үнэндээ энэ аудитын тайланд бид нарын маргаад мэтгэлцээд байдаг бүх зүйлүүд, бид нарын яриад байгаа бүх зүйлүүд л тусчихсан байна л даа. Тайлангаа ойлгоод, уншаад, нэг бүрчлэн хараад арга хэмжээ авдаг болбол.

Тэгээд хийхэд ч бас хэцүү л юм байна л даа. Энэ чинь ингэсэн байгаад байгаа шүү дээ. Төсвийн хүрээний мэдэгдэл, Төсвийн төсөөллийн тухай хуульд тусгасан эдийн засгийн үзүүлэлтүүдийг нь тухайн жилийн төсвийг батлахдаа өөрчлөлт оруулж байгаад баталчихдаг гээд байгаа юм. Тэгэхээрээ нөгөө харьцуулсан дүгнэлт гаргахгүй, дараа жилийн харьцуулсан төсвийн үзүүлэлтийн дүгнэлт гаргахаар тэрэнд нь тааруулаад хуулиа өөрчилчихдөг учраас томоохон хэмжээний эдийн засгийн дүгнэлт гарах боломжгүй юм гэж ингээж дүгнэж байна. Энэ зөв үү гэдэг дээр хариулаад өгөөч. Өөрөөр хэлбэл та хэдийн хийж байгаа аудитын тайланг яг энэ гүйцэтгэл төлөвлөгөө нь гаргаж ирэхдээ

тааруулаад бэлдчихдэг учраас хуулийн томоохон зөрчил ч юм уу, эдийн засгийн нөлөөллийн асуудал нь том зургаараа гарч ирэх боломжгүй байна гэсэн ийм том зурагтай байна гэж би бол ингээж дүгнэж байна. Энэ бол зөв үү, буруу юу?

2 дугаарт энэ дотоод асуудал руу бас ганц нэгхэн түүвэр болгоод асууя. Маш их зүйлийг бичсэн байгаа учраас. Энэ ганц нэг жишээг хэлье. Энэ авлагыг бүртгэж тайлагнаагүй нийт 9,7 тэрбум төгрөг гэсэн байгаа. Тэгэхээр авлага бүртгэж тайлагнаагүй гэдэг чинь бол үндсэндээ энэ тайлангийн систем огт байхгүй байна гэсэн үг үү?

3 дугаарт энэ бүхэлдээ болбол энэ хязгаарлалттай дүгнэлт өгчихсөн. Тэгээд хязгаарлалттай дүгнэлт дээр ер нь болбол ямар шийдвэр гаргах юм бэ? Одоо миний ажиглаж байгаагаар болбол энэ яаралтай горимоор 2 өдөр хэлэлцээд, та хэдийн бүтэн жилийн хийсэн энэ ажлуудыг ингээд батлаад явуулчихдаг юм уу? Тэгээд энэний чинь араас нь хөөж, хөөцөлдөх, буцаагаад энэ алдааг залруулсан тайланг нь авах процесс нь ямархуу байдаг юм бэ?

3 дугаарт төрийн өмчит болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага өссөн 415 тэрбумаар. Энэ дотроо болбол ялангуяа ЭГТ, Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Хөгжлийн банк мэтээр ингээд маш том хувь эзэлж байна. Энэ авлагуудыг нэг тайлбарлаад өгөөч? Нөгөө талд нь урьдчилгаа 1,5 их наядаар өссөн. Ялангуяа төрийн өмчит үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд. Тэгэхээр том зургаараа нэг талдаа авлага үүсгээд нөгөө талдаа өглөг үүсгээд маш их хэмжээгээр данхайгаад энэ орон нутгийн өмчит үйлдвэрүүд чинь өөрөө мөнгө угаадаг газар болчихсон юм шүү гэж ингээж харагдаад байна л даа. Зээлүүдийг нь харахаар бас дахиад 1,9 их наядаар өсчихсөн. 1,9 их наядынх нь 1,4.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Яах юм бэ, 1 минутаа авах юм уу? Түвшин гишүүний 1 минутыг өгье.

**Б.Түвшин:** 1,9 их наядаар энэ өр зээл өсөж байгаагийн 1,4 их наяд нь төрийн өмчит үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд дээр байгаад байна. Энэ асуудлыг нэг тайлбарлаач. Авлага, өглөг, урьдчилгаа гэснээр нь хослуулаад нэг тайлбарлаад өгөөч.

Дээрээс нь ер нь төсөвт суугаагүй нийгмийн шинж чанартай зардлуудыг төрийн өмчит үйлдвэрийн газруудаар тусгадаг гэж байгаа юм. Энийг болбол ААН болгоноор нь тусгаад, жил жилээр нь гаргаад надад нэг явуулаад өгөөч. Өөрөөр хэлбэл ямар төрийн өмчит үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит газрууд одоо төсөвт тусгаагүй хөрөнгө оруулалтыг хийж байна. Нийгмийн шинж чанартай үйл ажиллагаа хийж үү гэдэг дүнг нь бас гаргаж нэгтгэж харъя.

Дээрээс нь бас нэг том ноцтой асуудал харагдаад байгаа юм. Аудит хийх гэж байгаа хийгдээгүй байхад нь татаж буулгадаг, нэгтгэдэг ийм асуудлууд харагдаад байх шиг байх юм. Жишээлбэл ХАА-г дэмжих сангийн хөрөнгө, өр төлбөр, авлагыг ХАА-н корпорацад.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Хариулж эхэлье. Аудитаас эхэлье. Төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбогдуулаад дүгнэлт хийж чадаж байна уу гэсэн асуулт байна. Аудит, 8 номерын микрофон.

**Я.Самбууням:** Үндэсний аудитын газар Самбууням байна. Түвшин гишүүний асуултад хариулъя. Бид энэ төсөв, төсвийн гүйцэтгэлийг аудит хийж баталгаажуулахдаа болбол энэ төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар дээр нь бас энэ өөрчлөлт оруулаад байгаа асуудлыг Улсын Их Хуралд дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал болон холбогдох

төсвийн төсөв боловсруулж байгаа Сангийн яам зэрэг байгууллагуудад болбол дүгнэлт, зөвлөмж өгч байгаа.

Манай дүгнэлтийн 2 дугаар хэсэг дээр болбол байгаа юм. Төсвийн тухай хуулийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай бүрд Төсвийн хүрээний мэдэгдэл, Төсвийн төсөөллийн тухай хуулийг өөрчилж байгаа нь эдийн засгийн үзүүлэлтүүдийг урьдчилан тооцсон төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж байна гэж. Ингэхээр зэрэг болбол үндсэндээ төсвийн хүрээ, төсвийн хязгаараа болбол гүйцэтгэл болон төлөвлөлтийнхөө үе шатад байнга өөрчилж байгаа нь болбол бас хуультай нийцэхгүй байна гэдэг дээр болбол ийм дүгнэлтийг болбол өгсөн байгаа.

2 дугаар асуулт авлагын хувьд болбол төрийн өмчит ААН-ийн авлага өссөн байна гэж байгаа юм. Энэ дээр болбол төрийн өмчит хуулийн этгээдийн авлагын үлдэгдлийн 24 хувийг ЭТТ ХК-ийнх, 22,1 хувийг Дарханы төмөрлөгийн үйлдвэрийнх, 8,6 хувийг МУХБ-ных, 7,6 хувийг Тавантолгой төмөр зам ХХК нь, 5,4 хувийг МТЗ ТӨХК-ийнх, 2,6 хувийг Диспетчерийн үндэсний төв төрийн өмчит ХХК-ийнх, 2,4 хувийг МИАТ ТӨХК-ийнх, 2,1 хувийг Төрийн орон сууцын корпорац төрийн өмчит ХХК-ийнх, 2,1 хувийг Төрийн төрийн банк ХК-ийнх, 2,1 хувийг ИНЕГ, 2 хувийг Улаанбаатар ЦТС ТӨХК-ийнх, 11,4 хувийг бусад төрийн өмчит хуулийн этгээдийнх эзэлж байна. Ийм авлагын үлдэгдэл байгаа.

Урьдчилж гарсан зардлын хувьд болбол ямар зөрчлүүд илэрсэн бэ гэхээр зэрэг урьдчилж гарсан зардалд болбол төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дансны үлдэгдэлд бол ЭТТ ХК-ийн 2 их наяд 155 аравны, 155 тэрбум төгрөг, Тавантолгой төмөр зам ХК-ийн 1 их наяд 478,4 тэрбум төгрөг, Монгол Росцветмет төрийн өмчит үйлдвэрийн газрын 118,3 тэрбум төгрөг бусад төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 469 тэрбум төгрөгийн

урьдчилж гарсан зардал ТӨК-удынх эзэлж байгаа юм.

**Ц.Даваасүрэн:** Зээл тэгээд нөгөө хязгаарлалттай дүгнэлт дээр ямар шийдвэр гаргах вэ гээд энэ нь гүйцээж хариулъя. 8 номерын микрофоныг.

**Я.Самбууням:** Зээлийн, энэ 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудал байгаа. Энэ дээр болбол 2,8 их наяд төгрөгийн авлагыг ерөөсөө санхүүгийн тайланд тусгаагүй санхүүжилтийг нь олгоод явчихсан ийм асуудал байсан. Энийг болбол бид аудитаар илрүүлээд, энийг болбол авлагадаа бүртгэх, мөн энэ авлагыг тооцоо нийлж баталгаажуулахаар албан шаардлага хүргүүлсэн байгаа.

**Ц.Даваасүрэн:** Хязгаарлалттай дүгнэлт гаргасан байна энэтэй холбогдолтойгоор ямар шийдвэр гаргах вэ гээд, тийм үү? Тийм. 8 номер гүйцэд хариулъя.

**Я.Самбууням:** Түвшин гишүүний асуултад үргэлжлүүлэн хариулъя. ЗГ-ын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар болбол бид хязгаарлалттай дүгнэлт өгсөн байгаа. Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэлийг болбол та бүгдэд болбол хүргүүлсэн тайлан дээр дурдсан байгаа. Үүнд болбол тухайлбал ЗГ-ын гадаад өрийн гадаад зээлийн хөрөнгийн эх үүсвэрээс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр дамжуулан зээлдүүлсэн зээлээс олон жилийн насжилттай, хугацаатай хэтэрсэн, эргэн төлөлт хийгдээгүй 1 их наяд 111,1 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй. Гадаад зээлээр санхүүжүүлсэн 2018-аас 2022 онд хэрэгжиж дууссан Эрдэнэтийн ДЦС-ын өргөтгөлийн төслийн нийт 176,7 тэрбум төгрөгийн дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулаагүй, авлагаар бүртгээгүй. Энэ болбол сая Түвшин гишүүний асуултад бид хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл болгож өгсөн байгаа.

3 дугаарт орон сууцын хороолол, дэд бүтцийн төслийн хүрээнд дамжуулан зээлийн гэрээний дагуу 2012 онд олгосон Бэрэн групп ХХК-д 170.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Болсон уу? Нийт өр төлбөр 2 их наядаар өссөн байгаа. Энийг гүйцээе, 8 номер. ТӨК-удын гэсэн байх чи. 1,4 нь төрийн өмчит болон орон нутгийн өмчит газрууд бусад нь төсвийн байгууллагууд юм уу? Сангийн яам дараа нь нэмээрэй, юу ч гэсэн аудит хариулъя. Аудитын дүгнэлт дээр байгаад байгаа юм байна.

**Я.Самбууням:** Өр төлбөрийн нийт 1 их наяд 465 тэрбум төгрөгийн өсөлтөд богино хугацаат өр төлбөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байгаа. Тухайлбал Төрийн банк ХК-ийн богино хугацаат репо арилжаа хийж Голомт банкнаас богино хугацаат эх үүсвэр татан төвлөрүүлсэн 496,7 тэрбум төгрөг, Г... олон улсын санхүүгийн үйлчилгээнээс 192,1 тэрбум төгрөгийн, бусад 118,5 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн 1 дүгээрт.

2 дугаарт Монголын хөрөнгийн бирж ХК уул уурхайн бүтээгдэхүүний биржээр эрдэс баялгийн бүтээгдэхүүн борлуулж эхэлсэнтэй холбоотой арилжаанд оролцогчийн байршуулсан барьцаа дэнчингийн өглөг 880,9 тэрбум төгрөг, Монгол Улсын хөгжлийн банк ХХК нь үнэт цаасны эргэн төлөлт хийх зорилгоор Сангийн яамнаас авсан 100 тэрбум төгрөгийн хадгаламж. Мөн зээлийн багцын барьцаанд барьцаат гэрээ байгуулж дахин санхүүжилт авсан 429,9 тэрбум төгрөг, арилжааны банкнуудаас авсан санхүүжилт 15 тэрбум төгрөг. Монголын газрын тос боловсруулах үйлдвэр төрийн өмчит ХХК барилгын ажлын үлдэгдэл 45,9 тэрбум төгрөг, барьцааны өглөг 15 тэрбум төгрөг, МТЗ ТӨХК-ийн татварын өглөг 48,3 тэрбум төгрөг, энэ ТӨК-удын өглөг нийт өглөгийн дүнд эзэлж байна. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Түвшин гишүүн 1 минут.

**Б.Түвшин:** Тэр ХАА-г дэмжих сангийн хөрөнгө, өр төлбөр авлага ХАА-н корпорац руу шилжчихсэн гэж байгаа. Энэ аудитлагдсан байдлаар шилжсэн үү, аудитлагдаагүй байдлаар шилжчихэв үү? Энэ дээр аудитын дүгнэлт гарсан уу? Энэ ХАА-г дэмжих сангийн сүүлийн хэдэн жилийн үйл ажиллагаа дээр аудит хийсэн үү?

**Ц.Даваасүрэн:** Хариулъя. Энэ 2 чинь нөгөө нэгдсэн шүү дээ. 8 номер.

**Я.Самбууням:** Хүнс, хөдөө аж ахуйн яамны сайдын багцад хамаардаг ЗГ-ын тусгай сангуудын санхүүгийн тайлангийн аудитыг жил бүр хийж байсан. Энэ хийгдсэн аудитын эцсийн хаалтын балансыг үндэслээд, энэ нэгдэх нийлэх энэ зохицуулалт хийгдсэн байгаа. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Батлут гишүүн алга байна. Батболд гишүүн асуултаа асууя.

**Р.Батболд:** Би ганцхан л асуулт асуучихъя. Сая нөгөө Эдийн засгийн байнгын хороон дээр бас нэг асуултууддаа хариулт авчихлаа. Тэр нөгөө байгалийн Баялгийн сангийн 499,5 тэрбум төгрөгийг санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулна гээд байгаа. Энэ байриччихсан байгаа юм уу, эсхүл байршуулах гээд байгаа юм уу гэдгийг л асуух гээд байгаа юм. Байршуулах гэж байгаа бол хаана байршуулах гэж байгаа юм бэ? Нөгөө эрсдэлтэй банкнууд руугаа аваачаад хийчих юм биш биз дээ л гэж асуух гээд байгаа юм.

**Ц.Даваасүрэн:** Хэн хариулах вэ? 7, Т... үү? 4, 4 хариулъя.

**А.Энхжин:** Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын захирал Энхжин. Батболд гишүүний асуултад



хариулъя. Тэгэхээр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагуу хуримтлалын нэгдсэн сангийн дансны үлдэгдлийг Монголбанкнаа дахь дансанд тусгаарлаад, хуульд заасны дагуу бодлогын хүүгээр өгөөж тооцоод явж байгаа. Сангийн яамтай байгуулсан гэрээний дагуу энэ эх үүсвэрийг энэ оны хувьд бол орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй хөтөлбөрийн санхүүжилтэд бол зарцуулж байгаа.

**Ц.Даваасүрэн:** Тодруулах юм уу? Тодруулъя. Батболд гишүүний микрофоныг өгье.

**Р.Батболд:** Сая төсвийн тодотгол дээр болохоор нөгөө байршуулна гэж орж ирээд байсан юм. Тэгэхээр одоо бол энэ гүйцэтгэл дээрээ орчихсон явж байгаа гэж үзэж болох юм байна шүү дээ тийм үү? Энэ 23 оны төсвийн гүйцэтгэл дээр явж байгаа гэж ойлгож болох нь байна шүү дээ тийм үү?

**Ц.Даваасүрэн:** 4 номер хариулъя.

**А.Энхжин:** Тэгэхээр Үндэсний баялгийн сангийн тухай хууль энэ онд батлагдсан. Тэгэхээр энэ оны хувьд энэ ажил хийгдэж байгаа. Тэгэхээр 5 сард гэрээ байгуулагдаад, он дуустал Монголбанкнаа дээр тусгай дансанд байршаад хүү тооцоод явж байгаа.

**Ц.Даваасүрэн:** Соронзонболд гишүүн алга байна. Цогтбаатар. Да гишүүн алга байна шүү дээ, байгаа юм уу? Байна. Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

**Дав.Цогтбаатар:** Энэ аудит, Монголбанк 2-оос асууя. Тэгээд Монголбанкны хяналт шалгалт хариуцдаг Тэргүүн дэд ерөнхийлөгч эсвэл Дэд ерөнхийлөгчөөс нь асуух гэсэн ирээгүй байх шиг байна. 2022 оны татварын орлого бүрдүүлэлт дээр Төрийн банкнаас 24 тэрбум төгрөгийн өр төлөгдөөгүй гээд биччихсэн байгаа юм. Тэгээд тэрийгээ болохоор ТӨБЗГ-аас санал гаргаад нөгөө

төсвийн ерөнхийлөгч нь, ерөнхийлөн захирагчаас буюу Сангийн сайдаас ноогдол ашиг хуваарилахад төлөвлөсөн гээд байгаа юм. Ингэж болдог юм уу? Болдог бол одоо жишээлэхэд энэ Хадгаламжийн даатгалын корпорацад Төрийн банк миний мэдэж байгаагаар өртэй байх ёстой. Тухайн үеийн авсан ханш нь бол 85 тэрбум төгрөг 2013 онд байна уу, 16 оноос хойш тооцох юм уу байх ёстой. Энийгээ төлдөггүй юм уу? Энэ дээр аудитаас нэг тайлбар аваадахъя.

Тэгээд Монголбанк, Сангийн яам хоёроос бол энэ Төрийн банкныг болбол төр бараг 100 хувь мэдэлдээ байлгаж байгаа, 94,3 хувь нь. Тэгээд 2013 онд байгуулж байхад 3 жилийн хугацаатай Монголбанкнаас Хадгаламжийн даатгалын корпорац 85 тэрбум төгрөг аваад, Төрийн банкныг байгуулчихсан. Хугацаа нь дуусчихсан, зээл нь төлөгддөггүй. Тэгээд тэр зээл нь жишээлэхэд хүүтэй юу, 13 оноос юм уу, 16 оноос юм уу хүү байна уу Монгол банк? Тэгээд энэ Хадгаламжийн даатгалын корпорац чинь өөрөө бусад банкнуудын хадгаламжид нь эрсдэл хүлээх гээд байж байгаа байгууллага. Сангийн яам өөрөө жишээлэхэд Хадгаламжийн даатгалын корпорац эсвэл Сангийн яам хоёр хоёулаа хувьдаа ингээд банктай бусад арилжааныхаа банктай өрсөлдөөд байж болдог юм уу гэдгийг бас нэг тодруулмаар байна.

Тэгээд хувьдаа банктай байж болоод байгаа юм бол хүү бууруулах боломж жишээлэхэд энэ Төрийн банкныг хувьчлаад ч юм уу эсвэл гаднын банкнуудыг энэ Төрийн банкны хувь дээр нь оруулаад хувьцааг нь зараад ч юм уу хүү бууруулах энэ боломжийн талаар ямар төлөвлөгөө, бодлого байсан бэ гэдгийг энэ Монголбанк, Сангийн яамнаас бас асуумаар байна.

Тэгээд 3-д нь болохоор энэ Нийгмийн даатгалын сантай холбоотой Капитал банкны эрх хүлээн авагч 68,2,

Чингис хаан банк 94,9, нийтдээ 163 тэрбум төгрөг. Энэ Монголбанкнаас ямар арга хэмжээ авч байгаа вэ? Эсвэл эрх хүлээн авагч нь house аваад л тансаг амьдраад байна гээд сошиалд гараад байх юм. Эсвэл өндөр цалин аваад яваад байна гээд байх юм. Чингис хаан банкны эзэд нь болохоор гадуур өөр том, том юм хийгээд яваад байж болоод байна гэх юм. Тэгээд энэ төрийнх нь мөнгө ингээд үнэгүйдээд 163 тэрбум төгрөгөөрөө энэ тухайн үеийн мөнгө тэрэн дээр чинь хүү бодогддог юм уу яадаг юм бэ? Энэ дээр Монголбанк эсвэл энэ 2 Монголбанк нь энэ Чингис хаан эсвэл Капитал банкнуудаа толгойг нь илээд нэг ийм БЭТ томилсон байдлаар яваад байж бас болдог юм уу гэдгийг асуух гээд байгаа юм.

Тэгээд энэ 4 дээр болохоор энэ орлого тал дээр гол орлого төвлөрүүлээд байгаа энэ Тавантолгой, Оюутолгой эсвэл Эрдэнэт үйлдвэр ч юм уу эд нарыг байлцуулж байгаад асуух боломжтой юу гэж асуух гээд байгаа юм. Нөгөө Байнгын хороон даргаас. Жишээлэхэд энэ тайлант хугацаанд 8,8 их наяд төгрөгийн.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** 1 минут нэмж өгье. Цогтбаатар гишүүний микрофон 1 минут нэмье.

**Дав.Цогтбаатар:** 5 аравны үгүй ээ 5600 ширхэг тендер зарласан гээд байгаа юм. Тэгээд тодруулах юм бол 2023 онд ЭТТ компани нь энэ 4,1 их наяд төгрөг, Эрдэнэт үйлдвэр 1,6 их наяд төгрөг гээд. Тэгээд энэ тал дээр аудит ямар санал гаргасан юм бэ? Яг ингээд өөрсдөө яваад байх юм уу? Энэ чинь бараг ноцтой зөрчил энэ тэр Таван толгой түлш компаниар харах юм болбол удирдлагууд нь баахан болох болохгүй юм хийчхээд одоо өртэй юутай ийтэй нь өмчлөлийг нь шилжүүлэе гэдэг асуудал яригдаад байгаа юм. Тэгээд Загджав дарга болбол түрүүн асуудлуудыг бараг хуулийн байгууллагад шилжүүлээд байгаа гэж байгаа. Энэ дээр хуулийн байгууллагад шилжүүлсэн ч юм уу, ийм

ноцтой ийм үр дүн гаргаж харсан юм та нарт байна уу гэж байгаа юм.

**Ц.Даваасүрэн:** Хариулъя. Хаанаас эхлэх вэ? 8 номер аудит.

**Я.Самбууням:** Үндэсний аудитын газар Самбууням байна. Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. ТӨБЗГ-ын 2023 оны 341 дүгээр тогтоолоор төрийн өмчид ноогдох хувьцааны ноогдол ашгийн орлогоос 552 арвын тэрбум төгрөгийг бүрдүүлэхээс 416,2 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд, 24,6 тэрбумаар орлого тасалсан байгаа. Мөн төрийн өмчит хамаарах ААН байгууллагууд маань ТӨБЗГ-т төвлөрүүлэх ноогдол ашгаа дутуу төвлөрүүлсэн дээр болбол орлогыг гүйцэд төвлөрүүлэх дээр манайх албан шаардлага өгч ажилласан байгаа. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Сангийн яам орлого дээр нэмэх юм, өөр нэмэх хүн байвал гараа өргө дөө, би микрофоныг нь өгье. 4 Монголбанк, Монголбанк уу? Монгол банк.

**А.Энхжин:** Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын захирал Энхжин. Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Төрийн банк олон нийтэд нээлттэй хувьцаа гаргаснаас хойш ногдол ашиг 20 мянга, 2023 онд хуваарилсан. 2024 онд бас хуваарилах төлөвлөгөөтэй байгаа. Тэгэхээр энэ хуваарилсан дүнгээс Хадгаламжийн даатгалын корпорацад ерөнхийдөө өр төлбөрөө барагдуулаад тодорхой хэмжээнд төлөөд, ноогдол ашиг аваад Хадгаламжийн даатгалын корпорац өр төлбөрөө барагдуулаад явж байгаа.

Төрийн банкттай холбоотой өмнөх тэр Хадгаламж банк бусад банкнуудтай холбоотой Хадгаламжийн даатгалын корпорац 2 зээл Монголбанкнаас авсан байсан. 1 зээлээ бол бүрэн хааж барагдуулсан. Одоо 1 зээлийн үлдэгдэлтэй байгаа. Тэгэхээр Хадгаламжийн даатгалын корпорацаас Монголбанкинд

төлөх ёстой энэ өрийн үлдэгдэл нь бол тухайн үедээ Төрийн банкин дээр нөгөө Хадгаламж банк, Төрийн банк хоёрын тухайн үеийн үйл ажиллагаатай холбоотойгоор ямар нэгэн хүүгүйгээр санхүүгийн дэмжлэг байдлаар олгосон. Тэгэхээр Монголбанкнаас өгсөн энэ үлдэгдэл зээл дээр бол Хадгаламжийн даатгалын корпорац бол хүү тооцдоггүй байгаа. Төлбөрийн хэмжээг бол тодорхой хэмжээнд бууруулаад, ногдол ашгаараа төлөөд явна гэсэн тийм төлөвлөгөөтэй байгаа.

Төрийн банктai холбоотой хувьчлалтай холбоотой асуудлыг бол ЗГ-аас Сангийн яамнаас хариулах нь зүйтэй байх.

Чингис хаан нийгмийн, Чингис хаан, Капитал банкин дээрх нийгмийн даатгал, ЭМД-ын өр төлбөртэй холбоотой асуудалд хариулахад бол Чингис Хаан банкин дээр нийгмийн даатгалын өр төлбөр 96,5 тэрбум, ЭМД-ын 30,9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа. Капитал банкин дээр нийгмийн даатгалын 67,3, ЭМД-ын 77,6 тэрбум төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа. Тэгэхээр энэ 2 банкны хувьд бол Капитал банкин дээр банкны эрх хүлээн авагч томилогдоод ажиллаж байгаа. Тэгэхээр эрх хүлээн авагчийн зүгээс тодорхой хэмжээнд өр төлбөрийг барагдуулах ажлыг яг энэ Банкны тухай хуулийн төлбөрийн дарааллын дагуу хийгээд явж байгаа.

Чингис Хаан банкин дээр бол Монголбанкнаас газар дээрх хянан шалгагч томилоод муу чанаргүй зээлийг төлүүлэх байдлаар энэ өр төлбөрийг нь бууруулах ажлыг бол хийгээд явж байгаа.

**Ц.Даваасүрэн:** Сангийн яам хариулъя. Хэн хариулах юм бэ? Төрийн банк орлоготой холбогдолтой гэж байна. Санхүүгийн зохицуулах газар нь уу? Төсвийн бодлого хариулах юм уу, Санжаадорж хариулах юм уу, хэн хариулах юм бэ?

**Б.Тэлмүүн:** Тэлмүүн хариулъя, тодруулж байя. Цогтбаатар гишүүний микрофон өгье. Энэ сүүлийнх шүү. Та өмнө нь 1-ээ авчихсан, одоо ингээд 2 боломж байдаг, дууссан. Цогтбаатар гишүүний сүүлийн 1 минутыг өгье.

**Дав.Цогтбаатар:** 22 оны тэр татварын орлого бүрдүүлэлт дээр 24 тэрбумыг аудитаас хариулсангүй.

**Ц.Даваасүрэн:** Тэр 24 тэрбумыг хариулна. Тэгээд Тэлмүүн дарга дараа нь хариулна шүү. 8 номерын микрофоныг өгье.

**Я.Самбууням:** Төрийн банк ХК-ийн 2022 оны цэвэр ашигт ноогдуулсан 48,1 тэрбум төгрөгийн ноогдол ашгаас 24,4 тэрбум төгрөгийг дутуу төвлөрүүлж ногдуулалтад үүссэн маргаантай асуудлыг шийдвэрлээгүй байна гэж аудитаар болбол дүгнэсэн байгаа. Ингээд ТӨБЗГ-аас хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчаас нь санал авч, төвлөрүүлэх ноогдол ашгийн хэмжээг тогтоосон. Төрийн банк ХК-аас. Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын хувьцаа эзэмшлийн хувиар ноогдол ашгийг хуваарилж, төвлөрүүлсэн байна гээд ийм хариу тайлбар ирсэн байгаа. Энийг нь болбол бид болбол энэ орлогыг дутуу төвлөрүүлсэн ногдуулалт хийх зарим зохицуулалт тодорхойгүй байна гэж аудитор болбол алдаа зөрчил болгож илрүүлсэн байгаа.

2 дахь нь Цогтбаатар гишүүний бас нэг асуусан асуултад нь энэ Тавантолгой түши хувь ХХК-ийн ЭТТ ХК-тай байгуулсан ийм тоот дугаартай гэрээний дагуу авсан эргэн төлөгдөх, урт хугацаатай хөрөнгийг Барилгын тухай хууль, барилгын норм, дүрэмд заасан шаардлага хангаагүй, төсөл, арга хэмжээнд зарим мөнгөн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж, зарцуулах шийдвэр гарган албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж улсад их

хэмжээний хохирол үүсгэсэн байж болзошгүй байна гэдэг энэ агуулгаар нь болбол бид Улсын ерөнхий прокурорт болбол асуудлыг шийдвэрлэхээр хүргүүлсэн байгаа. Энийг танд залруулж тайлбарлаж байна. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Тэлмүүн даргын 9 номерын микрофоныг өгье.

**Б.Тэлмүүн:** Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн. Төрийн банкны ноогдол ашигтай холбоотой Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Төрийн банк ХК-ийн 49 хувийг бол төр эзэмшдэг ЗГ эзэмшдэг. Төрийн банкны ноогдол ашиг хуваарилах талаар шийдвэр гаргахдаа Монгол Улсын Их Хурал 2022 оны 11 сарын 11-ний өдрийн 72 дугаар тогтоол гээд Монгол Улсын 23 оны Төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоолын 5 дугаар зүйлд заасныг бол удирдлага болгоод, энэ дээр юу гэж заасан гэхээр төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд жилийн эцсийн санхүүгийн тайлангаар гарсан цэвэр ашигийн 50 хувьтай тэнцэх хэмжээний ноогдол ашигийг хуваарилна гэдэг ийм чиглэлийг бол ЗГ-т өгсөн.

Төрийн банк ХК нь бол 23 оны жилийн эцсийн тайлангаар бол 94,7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Үүнээс Их Хурлын тогтоолоор өгөгдсөн үүргийн дагуу бол нийт хувьцаа эзэмшигчдэд 49,9 тэрбум төгрөгийн ноогдол ашигийг бол хуваарилан, хуваарилсан байдаг. Энэ дээр бол нэгж хувьцаанд ноогдох ноогдол ашигийн дүнг 66,2 төгрөг байхаар бол тогтоосон. Энэ нь Улсын Их Хурлаас тогтоосон өгсөн чиглэлийн дагуу цэвэр ашигийн 50 хувийг бол бүрэн хуваарилсан байдаг.

Аудитын тайлантай холбоотой зүгээр яах вэ энэ ТӨБЗГ-тай тодорхой хэмжээний ойлголтын зөрүү гарсан. ТӨБЗГ-аас бол цэвэр ашигийг 100 хувь

бүрэн ноогдол ашигаар хуваарилах ёстой байсан. Үүнийх нь 49 хувь нь төр лүү орох ёстой байсан гэдэг ийм агуулгаар бол асуудал тавьсан. Улсын Их Хурлын тогтоол бол цэвэр ашигийн 50 хувиар ноогдол ашигаа хуваарил гэдэг ийм чиглэл өгсөн. Тэгэхээр бид Улсын Их Хурал талаас Улсын Их Хурал тогтоолоор өгсөн чиглэлийг баримталж Сангийн сайд ЗГ-аас өгсөн удирдамжийн дагуу ноогдол ашиг хуваарилах шийдвэр гаргасан байгаа.

**Ц.Даваасүрэн:** Батлут гишүүн асуулт асууя. Харин байна шүү дээ Цогтбаатар гишүүн өөрөө Зарлагын хяналтын дэд хорооны гишүүн. Тийм учраас би нөгөө 1 минут нэмж өгөх боломжгүй болчихсон учраас та нар Зарлагын хяналтын дэд хороон дээр энэ төрийн өмчийн компаниуд ялангуяа Эрдэс Монгол компанийн төлөөллийг, Эрдэс тавантолгой компанийн удирдлагуудыг оролцуулъя. Тэгээд энэ тодруулах гээд байгаа зүйлүүдийг нь болбол Зарлагын хяналтын дэд хороон дээр тодорхой хариулт өгье. Ийм чиглэл өглөө шүү. Батлут гишүүн асуултаа асууя.

**Д.Батлут:** Би бас урьд нь сонирхож байсан асуудлаа нэлээн лавшруулмаар байгаа юм. Төдий бас бүрэн дүүрэн хариулт аваагүй. Манай төсвийн төслийн ингээд хэрэгжүүлж байгаа үйл явцыг харахаар ингээд нэг юмны араас хөөсөн тийм үйл явц яваад байдаг л даа. Тэгээд яг үнэндээ нэг барилга байгууламж барилаа гэхэд экспертиз хийж байгаа хүмүүс бөгөөд хүмүүс нь бол ямар нэгэн хариуцлага хүлээх хэлбэргүйгээр тэгсэн мөртөө төрийн үйл ажиллагаанд оролцоод, тэд нар асуудлаа гаргаж ирж тавиад, түүнийг нь бид нар авч хүлээж аваад шийдээд яваад байгаа юм.

Тэрний гор нь гэх юм бол 22 оны төсөв дээр 400 орчим төсөл арга хэмжээ хэрэгжүүлсний 200 орчимд нь нийцлийн аудит хийнгүүт 70-аас 80 тэрбум төгрөгийн илүү тооцсон дүн гарсан. Тэгээд бид нар яах вэ аудитын



байгууллагаас асуугаад энэ 23 онд иймэрхүү алдаа дутагдал гарсан уу гэнгүүт гараагүй. Бид засаж чадсан гэж байгаа юм. Тэгвэл тэр эксперт хийгээд зохиомлоор төсөл, арга хэмжээний зардлыг нэмэгдүүлээд байгаа хүмүүст хэрхэн хариуцлага тооцсон юм бэ? Ер нь цаашлаад бид нар яг энэ чиглэл дээр ямар арга ажиллагаагаар ажиллах юм бэ? Тэр нь төрийн бүтэц биш. Нэг хэдэн мэргэшсэн инженерүүд гээд нөхдүүд тэнд нэг асуудлыг хандаад, шийдэл гаргаад, тэрийг нь бид нар алх цохиод шийдээд явчхаж байгаа шүү дээ. Яг энийг бид нар яаж засаж залруулах юм бэ?

Тэгэхгүй бол энэ зүйл хэзээ ч арилахгүй. Жижигхэн зүйл сонсож байж болно. Магадгүй энэ чинь том арга хэмжээ, жилийн, жилийн төсөв дээр ингээд нэмэгдсэн дүнгээр яваад л байх юм бол маш том үр дүн авчрах нөхцөл байдлыг бол сөрөг үр дүнгүүд авчрах нөхцөл байдлыг үүсгээд байгаа шүү. Энэ дээр аудитын байгууллага мэргэжлийн байгууллагууд нь хариулаач. Яг яах юм бэ, энэ эксперт хийж байгаа тэр бүтцийг төр хажуудаа байлгах юм уу эсвэл нэг хэдэн тэр мэргэшсэн инженерүүдийн үгээр амаар бид нар төсвөө зохиодог, төсвөө баталдаг тийм тэр мафийн гар, хөл болчихоод явж байх юм уу? Энийгээ нэг ялгаа заагийг нь олж, эхнээс нь жижгээс нь энэ асуудлуудаа засах хэрэгтэй байна. Энэ дээр нэг хариулт өгөөч.

2 дугаарт нь чуулганы хуралдаан дээр асуусан. ЭМД-ын сан гээд. 58 хувийн хэвшлийн эмнэлэгт зардлыг нь өгөхгүй гэсэн. Яагаад, ямар учраас ингээд зардлыг өгөхгүй болчхов? Эсвэл тэр хувийн хэвшлийн эмнэлгүүд илүү гүйцэтгэлээр санхүүжчихсэн юм уу? Яг хариуцаж байгаа хүн нь ирчихсэн байх шиг байна. Энэ тал дээр надад нэг хариулт өгөөч.

Энэ ЭМД-ын сан маань тэр өр ширээ барагдуулах тал дээр хэрхэн ажиллаж байгаа юм бэ? Яах вэ тодорхой хэмжээний үр дүн гарч байгаа л гэсэн. Тэгээд энэ ЭМД-ын сангаас

санхүүжүүлж байгаа хэдэн чиглэл байгаа. Гүйцэтгэлийн санхүүжилт, сумын анхан шатын, анхан шатын эмнэлгүүдийн санхүүжилт, эмийн сангийн хөнгөлөлттэй эмийн үйлчилгээ гээд.

**Ц.Даваасүрэн:** Хариулъя. Эхний асуудал бол их чухал асуулт байна шүү. Манай аудит хариулъя. Та нарын юугаар нөгөө эксперт хөндлөнгийн аудит хийгдсэн энэ нөгөө үнийн өсөлттэй холбоотой төслүүд дээр болбол илүү мөнгө хийчихсэн юм гарсан юм байна шүү дээ. Тэгээд энэтэй холбогдолтой тэр эксперт хийгээд байгаа нөхдүүдтэй ямар хариуцлага тооцсон бэ гэж байна. Энэ нөхдүүдийн эрхийг цуцалсан уу, ингээд тэд нар зүгээр явж байгаа юу, ямар хариуцлага тооцсон юм бэ? Энэ чухал зүйл шүү.

Яагаад гэвэл энэ үнэхээр ингээд нэг хувийн хэдэн экспертүүдээр л хөндлөнгийн үнэлгээ хийлгээд л, энэ төсөв нь өссөн байна гээд л ороод ирж байгаа шүү дээ. Энэ чинь бол маш том өсөлт. Тэгээд энэ салбарынхан чинь хоорондоо нэг сургууль, нэг анги, найз нөхөд, нэг компанид байсан гээд ийм болчихсон. Яах вэ ер нь энийг бол бид нар Барилгын хуулиар нэлээн зохицуулах шинэ хуулийн төсөл өргөх байх. Та нар ямар арга хэмжээ авсан юм бэ? 8 номерын микрофон.

**Я.Самбууням:** Үндэсний аудитын газар Самбууням байна. Батлут гишүүний асуултад хариулъя. Бид нар 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан дээрээ болбол энэ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй энэ асуудлуудыг болбол нэлээн дүгнэлтдээ оруулж өгсөн байгаа. Үүнтэй холбогдуулаад Монгол Улсын Ерөнхий сайдад болбол Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Шадар сайд, Сангийн сайд гээд ингээд холбогдох эрх бүхий албан тушаалтанд бүгдэд нь зөвлөмж хүргүүлж ажилласан байгаа.

Мөн Барилга, хот байгуулалтын сайдад ч гэсэн энэ барилга байгууламжийн ашиглалтад оруулах дүрмийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн чиглэл арга зүйгээр хангах, барилга байгууламжийн зураг төсөл, ажлын чанар, гүйцэтгэл, илэрч байгаа нийтлэг зөрчил, тулгарч байгаа асуудалд судалгаа шинжилгээ хийж, барилгын норм, дүрэм, стандартыг өөрчлөн шинэчлэх, сайжруулах ажлыг зохион байгуулан норм нормативын сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулахад анхаарч ажиллах гэсэн ийм зөвлөмжүүдийг хүргүүлсэн байгаа.

Мөн 2024 оны төсвийг боловсруулахад болбол бас энэ Сангийн сайдад болбол 2 албан шаардлагыг хүргүүлсэн байгаа. Энд болбол тухайлбал Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр тусгасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан төсөвгүй болон нэг маягийн зураг төсөлтэй төсөл, арга хэмжээг тусгасан байна. Энэ зөрчлийг арилгах гэсэн ийм албан шаардлагыг өгсөн байгаа.

Мөн шинээр хэрэгжүүлэхээр тусгасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол болон үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой зардлын тооцоолол хийгээгүй, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлт гаргаагүй зөрчлийг арилгах гэсэн ийм албан шаардлагуудыг хүргүүлж ажилласан байгаа.

Мөн барилгын, Барилга хөгжлийн төвд болбол энэ экспертүүдтэйгээ хариуцлага тооцох бас албан шаардлагыг хүргүүлж ажилласан байгаа. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Барилгын хөгжлийн төв рүү хүргүүлсэн юм уу? Над руу лав юм ирээгүй шүү. Би тэр үед

Барилгын сайд хийж байсан юм. 8 номерын микрофон өгье.

**Я.Самбууням:** Энэ албан шаардлага өгсөн хэрэгжилтийг ирүүлэх хугацаа хараахан болоогүй байгаа. Тэгэхээр зэрэг энэний хэрэгжилтийг ирэхээр албан ёсоор.../үг тасрав/

**Ц.Даваасүрэн:** Хаашаа өгсөн юм бэ?

**Я.Самбууням:** Би сая дурдлаа. Энэ Барилга, хот байгуулалтын сайд, Барилгын хөгжлийн төв, тэгээд Сангийн сайд гэх мэтчилэнгээр сая эрх бүхий албан тушаалтнуудад өгсөн.

**Ц.Даваасүрэн:** Надад тийм юм ирээгүй. Надад тийм юм ирээгүй. Жишээлбэл ийм эксперт наадах чинь харин миний бүүр шийдэх ёстой гэж бодож явдаг асуудал. Хэрэв та нар яг надад ийм юм ирүүлсэн байсан бол би наадхыг чинь далимдуулаад л арга хэмжээ авах байлаа. Ёстой тийм юм ирээгүй шүү. Надаас хойш, сая ирсэн юм уу? 8 номерын микрофон.

**Я.Самбууням:** Хүргүүлсэн албан шаардлага болон зөвлөмжийнхөө талаар танд юуг нь тайлангуудыг нь хүргүүлье.

**Ц.Даваасүрэн:** Магадгүй надад танилцуулахгүй, доор дарчихсан тийм юм байна уу, үгүй юү би нягталъя. Яагаад гэвэл яг надад энэ төсөвт өртгийг хэтрүүлэн үнэлсэн байна, ийм, ийм улсуудад хариуцлага тооцооч гэж шаардлага болбол Аудитын газраас лав ирсэн юм надад танилцуулагдаагүй шүү. Энэ уг нь тэгэх ёстой. Яагаад гэвэл 70 хэдэн тэрбум гэдэг чинь аймаар их мөнгө шүү дээ. Тэд нар тэгж зүгээр өнгөрч ерөөсөө болохгүй. Тэгэхээр энийг ер нь дахиж нягталъя. Надад тэр юугаа өгчхөөрэй. Хэдийгээр би ажлаа өгсөн ч гэлээ гэсэн хэрвээ тийм хариуцлагагүй юм болсон байгаа болбол тэр улсуудтай эргээд бид нар ярих ёстой. Нууж байж магадгүй. Яагаад гэвэл ах, дүү нар шиг

байгаа учраас тэд нар. 2 дахь асуудалд нь хариулъя. 3 номерын микрофон.

**Л.Бямбасүрэн:** Батлут гишүүний асуултад хариулъя. ЭМД-ын ерөнхий газрын дарга Бямбасүрэн. Энэнээс өмнө би бас нэг хүлцэл өчье. Түүрүүн Даваасүрэн даргаа би буруу ойлгогдохоор хариулт өгчих шиг боллоо. НДЕГ-аас манайд долоо хоног болгоны мягмар гарагт төвлөрүүлдэг нөгөө ЭМД-ын шимтгэлийн орлогыг. Тэгээд бид нар тэрийг нь тэр дор нь төрийн сан руугаа татдаг шүү. Би бас энийг буруу долоо хоног байршуулдаг гээд буруу ойлгуулчих шиг боллоо.

Батлут гишүүний асуулт. 58 хувийн хэвилийн эрүүл мэндийн байгууллагад зардлыг нь өгөхгүй гэсэн гээд тэгж байна. Ер нь бид нар Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан байгаа. Мөн ЭМД-ын үндэсний зөвлөлийн холбогдох тогтоолд ч гэсэн заасан байдаг. Сонгон шалгаруулалтад тэнцсэн, тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагуудтай бид нар барилга байгууламж, хүний нөөцийн чадамж, тоног төхөөрөмжийн хангалтад нь тохирсон оношны хамааралтай бүлгээр гэрээ хийдэг. Энэ 58 хувийн хэвилийн эрүүл мэндийн байгууллагын хувьд энэ хуульд заасан гэрээний тоо хэмжээ хэтэрсэн байгаа. Тэгэхээр бид нар эхлээд бол бид нар мэдээлэл, мэдэгдэл өгсөн байгаа утсаар. Танай тоо хэмжээ ингээд хэтэрчихсэн байна шүү. Тэгээд одоо бид нар нэг бүрчлэн хүлээж авч уулзаад, ер нь уулзаад эхэлчихсэн байгаа л даа. Уулзаад танай тоо хэмжээ ингээд хэтэрсэн байна энэ дээр яах вэ.

Тэгэхээр эд нар бол цаашаа төлбөртэй тусламж, үйлчилгээгээ үзүүлээд явах эрх нь бол нээлттэй байгаа. Бид бол яг хүний нөөц, би түүрүүн хэлсэн барилга байгууламж, тоног төхөөрөмжийнх нь хангалтад тохирсон оношны хамааралтай бүлгээр энэ тоо хэмжээгээ тохирсон. Тэгэхээр өөрийнхөө хүчин чадал, хүний нөөцийн чадамжаас

давсан энэ тусламж, үйлчилгээ бол энийг бол бас чанартай гэж үзэх үү гэдэг бас асуудал гарч ирж байгаа юм. Тэгэхээр бид нар бол энэ дээр ямар ч байсан, гэхдээ өнөөдрийг хүртэл цахим дээр хаалт хийгээгүй, нэхэмжлэлээ илгээсэн хэвээр.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Тодруулъя, Батлут гишүүний микрофоныг өгье.

**Д.Батлут:** Тэгээд энэ Үндэсний аудитын газрынхан, тэгээд холбогдох яамнууд нь яг энийг нэг анхаарахгүй бол ингээд 24 хүн болчихож байгаа байхгүй юу. Тэгээд дотор нь юу ч явж байгаа юм бас мэдэхгүй. Энэ асар их том зөрчил шүү, бүүр нэг тийм мафижсан хэлбэрүүд байгаад байгаа. Энийг би тодорхой бас асуулгаар эргэж тодруулна. Та бүхэн мэдээллүүд гаргаж өгөөрэй.

ЭМД-ын газрын дарга тоо, хэмжээ хэтэрсэн, хүний нөөц, тоног төхөөрөмжийн шаардлага хангахгүй байгаа гээд. Урьд нь шаардлага хангадаг байсан юм уу? Урьд нь шаардлага хангадаг байсан байж байгаад одоо шаардлага хангаа байгаад өгөхөө байчхаж байгаа юм уу, юу гэж ойлгох юм бэ? Наад тайлбараа хүртэл нэг буруу хийх юм та нар. Одоо нийгмээр дүүрэн юу гэж байгаа вэ гэхээр гүйцэтгэлийн санхүүжилт явахаа байчихсан, бүх эмнэлгүүд санхүүжилт авч чадахаа байчихсан, иргэн хүн бүр төлбөр төлж эрүүл мэндийн үйлчилгээ авдаг боллоо гэдэг мессеж л явж байна. Ямар ч мэдрэмж байхгүй. Өөрсдийнхөө хийж байгаа ажлыг нийгэмд мэдээлэл болгож түгээж чадахгүй та хэд. Ийм арчаагүй байдлаар ажиллахгүй. Наана чинь бол нухвал зөндөө юм байгаа шүү. Манай аудитынхан ч анхаарах ёстой. Хүнээс хамаарсан шийдлүүд гарч байгаа энэ ЭМД-ын ерөнхий газар. Тэр дотор янз янзын асуудлууд бий. Магадгүй тэрэн дээр асуудлууд үүссэн байх гэж би зүгээр сэжиглэж байгаа юм. Тодруулга авна энэ талаар би ахиж.

Одоо тэгээд амралтын газрууд гээд хэчнээн сувилал, амралтын газруудад ямар хэмжээний мөнгө өгсөн юм бэ гээд манай гишүүд асуугаад, хариулт авч чадахгүй сууж байна. Хариулаарай. ЭМД-ын сангийн хөрөнгийг юу юунд зарцуулах ёстой юм бэ? Сувилалд юм уу, амралтын газар юм уу? Тэнд хэчнээн хэмжээний мөнгийг ямар, ямар шийдвэрээр гаргачихсан юм бэ? Яг гол тэр гүйцэтгэлийн санхүүжилтэд ямар хэмжээний мөнгө гаргачихсан юм бэ? Одоо бид нар урьд нь ковидын үед гаргасан он дамжуулж шилжүүлсэн өр төлбөрөө яаж барагдуулж байгаа юм бэ? Нөгөө Капитал банк, нөгөө Чингис хаан банкныхаа өр ширийг яаж байгаа юм бэ гээд.

**Ц.Даваасүрэн:** Хариулъя. Чингис хаан, 3 уу? 3. Нийгмийн даатгалыг асуусан уу үгүй юү? Асууж амжаагүй. 3.

**Л.Бямбасүрэн:** Батлут гишүүний асуултад хариулъя. Би хүний нөөц, тоног төхөөрөмж шаардлага хангахгүй гэж хэлээгүй. Хүний, тоног төхөөрөмжийн хангалт, хүний нөөцийн чадамжийн хувьд тэр чинь бас хязгаарлагдмал байгаа шүү дээ. Хэдэн эмчтэй байж байгаа, 5 эмчтэй газар нэг өөр үйл ажиллагаа явуулна, 10 эмчтэй газар нэг өөр үйл ажиллагаа явуулна. Байр байшингийн хувьд бол метр квадратаас шалтгаалаад өөр өөр чадамж, би чадамж гэж хэлсэн. Тэгэхээр энэ чадамжийн хувьд бол яг тэрэнд нь тохирсон гэрээ хэлцлийг бид нар хийж ажилладаг гэдгийг хэлье.

Амралт, сувилалд ЭМД-ын сангийн мөнгийг зарцуулж байна гэж байна. Амралтын газарт бол ЭМД-ын сангаас бол санхүүжилт бол өгдөггүй. Өөрөөр хэлбэл тусламж, үйлчилгээ худалдаж авдаггүй гэсэн үг. Сувиллын хувьд бол Эрүүл мэндийн тухай хуульд сувилал гэдэг маань өөрөө эрүүл мэндийн байгууллага гэж явдаг. Тэгэхээр ЭМД-ын тухай хуульд ЭМД-ын ерөнхий газар нь тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагыг сонгон

шалгаруулалт зарлаад, тэрэнд тэнцсэн эрүүл мэндийн байгууллагатай гэрээ хийнэ. Гэрээ хийхдээ тоо хэмжээг тогтооно гэсэн заалт байдаг учраас энэнийхээ дагуу яг ажиллаж байгаа. Сувилалд чинь хэдийг өглөө, би яг тэрийг бэлдэж ирээгүй байгаа учраас. Сувилалд хэд байна вэ? Би энийг бэлдэж байгаад дараа нь асууя.

Түүрүүн Чингис хаан банк, Капитал банктэй холбоотой барагдуулалтын талаар би танилцуулсан. Дахиад танилцуулах уу дарга, Даваасүрэн дарга?

**Ц.Даваасүрэн:** Хэлчих тэгвэл товчхон.

**Л.Бямбасүрэн:** Капитал банкнаас 136,1 тэрбум төгрөгийн авлагатай байсан. Ингээд 2024 оны 8 дугаар сарын.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** 3 номерын микрофоныг 1 минут сунгая.

**Л.Бямбасүрэн:** 23-ны байдлаар тус банкны эрх хүлээн авагч болох 11,8 тэрбум төгрөгийг бэлэн мөнгөөр төлсөн байгаа. Манайх 46,7 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг хүлээж авсан. Үүнээс 10 аравны тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг борлуулсан. Энэ борлуулалтын орлого нь ЭМД-ын санд төвлөрсөн байгаа. Капитал банкны авлага 77,6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа. Энэ дээр бол бид нар Капитал банкны эрх хүлээн авагчид удаа дараа албан тоот хүргүүлж ажиллаж байна.

Чингис хаанд байршуулсан мөнгөний хувьд бол өнөөдрийн байдлаар 30,7 тэрбум төгрөгийн авлагатай байгаа. Энэ нь бол Монгол Улсын Дээд шүүхийн шийдвэр гарчихсан. Ингээд бид нар Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газарт удаа дараа бас албан тоот хүргүүлээд ажиллаж байгаа.

**Ц.Даваасүрэн:** Тэгээд жич өгчхөөрэй. 8 номер.



**Я.Самбууням:** Батлут гишүүний асуултад хариулъя. ЭМД-ын сангаас 2023 онд 46, 47 сувилалд нийт 39,5 тэрбум төгрөг, эмийн хөнгөлөлтөд 90 тэрбум төгрөгийг олгосон байна. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Аубакир гишүүн асуултаа асууя.

**Т.Аубакир:** Баярлалаа. Хөдөө аж ахуйн яам сая түрүүний хэлсэн мэдээлэлдээ 120 мянган тонн нойтон мах, 6,4 сая бог руу шилжүүлбэл 300 орчим сая долларын мах экспортлосон байна гээд хэлсэн тийм ээ. Тэгээд энэ маш сайн байна. Энэ өнгөрсөн 22 оны 3 сард гарсан Хүнсний аюулгүй байдлын зөвлөлийн өгсөн зөвлөмжийн дагуу хонь, ямаа, үхрийн нойтон махыг ямар нэгэн квот хязгаарлалтгүйгээр экспортлох нээлттэй байгаа. Бас энэ мал, махны экспорт үйл ажиллагаа явуулах сонирхолтой бизнесменүүд энэ тэр байх юм бол Монголын төрөөс шалтгаалж байгаа ямар нэгэн хориг саад бол байхгүй. Энэ бол маш амжилттай явж байгаа.

Дээрээс нь нэг цонхны үйлчилгээ маань яг ажиллаж байгаа юу? Өнгөрсөн Засгийн үед, өнгөрсөн парламентын үед бид нар мал, махны экспортын бүх бичиг баримтыг зөвхөн нэг цонхноос ХААЯ-н дээр авахаар төвлөрүүлсэн. 7 байгууллагаас үндсэндээ мал, махны экспортын бичиг баримт бүрдүүлж авдаг байсан. Гаалийн ерөнхий газар, Мал, эмнэлгийн ерөнхий газар гэж байсан тэр үед, Мэргэжлийн хяналт гэж байх үед жишээлбэл авдаг байлаа. Одоо энэ маань яг зөвхөн ХААЯ-н дээрээс холбогдох бүх бичиг баримтаа очоод тэр чинь 72 цагийн дотор л тэр нэг цонхны үйлчилгээнээс мах экспортлогч маань бүх бичиг баримт document-ээ бүрдүүлээд гарахаар бол зохицуулсан шүү дээ. Энэ нэг цонхны маань үйл ажиллагаа яг явж байгаа юу гэж эхний асуулт ХААЯ-наас.

2 дахь асуулт маань Монголбанкнаас байгаа юу, хүн байгаа юм уу дарга Монголбанкнаас?

**Ц.Даваасүрэн:** Дуудаарай.

**Т.Аубакир:** Байсан уу? Монголбанкнаас энэ өнгөрсөн жилийнхээ энэ арилжааны банкнуудын судалгаа гүйцэтгэлээр гэдэг юм уу, хөрөнгө оруулалтын зээл болоод хэрэглээний зээл хоёрын харьцааг ер нь гаргасан уу? Одоо ажиглаад байхад арилжааны банкнууд маань хэрэглээний зээлийг түлхүү өгөөд ард иргэдээс хүүг нь аваад л үндсэндээ энэ чинь зарим газраа бол бодлогын чанартай том хөрөнгө оруулалт төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлээд явах ёстой. Гэтэл манай арилжааны банкнууд маань хэтэрхий нөгөө хэрэглээний зээл рүүгээ илүүтэй зах зээл рүү нь ажиллаад байгаа юм биш биз дээ? Энэ чинь эргээд нөгөө мөнгөний нийлүүлэлт, тэгээд нөгөө импортыг нэмэгдүүлдэг. Нэг их дотооддоо тийм үр дүнтэй болбол ажил бол биш шүү дээ. Тийм учраас энэ 2 зээлийн харьцааны талаар яг нэг тоо хэлээд хэлээдхээч. Монголбанкнаас.

3 дугаарт энэ нүүрсний экспорт маань өнгөрсөн жилийн хугацаанд гүйцэтгэлээр манай Сангийн яам хариулах уу? Өнгөрсөн онд яг энэ Хөрөнгийн биржийн арилжаагаар уул уурхайн бүтээгдэхүүнийг арилжаалах бид нар маш том ажил хийсэн, маш үр дүнтэй явж байгаа. Энэ өнгөрсөн хугацаанд бусад хөрөнгийн биржээр яваагүй байх үетэй нь харьцуулах юм болбол яг хэдий хэмжээний.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Гишүүний асуултад хариулъя. ХААЯ 1 номерын микрофон.

**Л.Идэрцогт:** ХХААХҮЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Идэрцогт. Аубакир гишүүний асуултад хариулъя. Ер нь болбол бас ГЕГ-т манай яамны талаар ярилцаж хийгээд нэг

цонхны үйлчилгээгээр энэ асуудлыг шийдсэн байгаа. Хамгийн гол нь бас импортлогч тал хорио цээрийн шаардлага тавьдаг. Манай талаас бол хамаарах энэ асуудал болбол шийдэгдсэн байгаа. Тэгэхээр Хүнс, хөдөө аж ахуйн яам дээрээ бол нэг цонхны асуудлаа холбогдох газруудаасаа нэгтгэж аваад, энэ асуудлыг шийдээд явж байгаа.

**Ц.Даваасүрэн:** 2 дахь нь Монголбанк. Төв банкны хүү хэт өндрөөс ингээд нөгөө арилжааны зээлүүд хязгаарлагдмал болж байгаа. 4 номерын микрофон.

**А.Энхжин:** Энэ оны 6 сарын эцсийн байдлаар банкнуудын зээлийн үлдэгдэл 31,2 хувиар өссөн байгаа. Нийт зээлийн үлдэгдлийн хэмжээ 33,3 их наяд төгрөгт хүрсэн. Энэ 31,2 хувийн өсөлтийн 11,1, 11,3 нэгж хувийн өсөлтийг бол хэрэглээний зээл бүрдүүлж байгаа. Үлдсэн хэсгийг нь бол 6,3 нэгж хувь нь ипотекийн зээл, 3,6 нэгж хувийг худалдааны зээл гээд ийм зээлийн өсөлтүүд бол бүрдүүлж байгаа.

Монголбанкны зүгээс хэрэглээний зээлийн өсөлтийг хязгаарлах талаар энэ өр, орлогын харьцаа зэрэг энэ макро зохистой бодлогын арга хэмжээнүүдийг ерөнхийд нь авч байгаа. Хэрэглээний зээлийн өсөлт яг таны хэлдгээр энэ импортыг өдөөх, эргээд энэ өрхийн орлогод дарамт учруулах зэрэг сөрөг нөлөөллүүд их байгаа учраас энийг бууруулах тал дээр бол арга хэмжээ авч байгаа.

Монголбанкнаас авч байгаа арга хэмжээ нь хязгаарлагдмал зүйл байгаа нь энэ нөгөө манай хэрэгжүүлж байгаа арга хэмжээ зөвхөн банкны хувьд үйлчлээд байдаг. Банк бус санхүүгийн байгууллагад бас энэ үйлчлэл нөлөө үзүүлэх юу нь бол хангалтгүй байгаад байгаа. Тэгэхээр энэ дээр Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл дээр энэ асуудлыг яриад ер нь арга

хэмжээ авах нь шаардлагатай гэсэн тийм байр суурьтай байгаа.

Бизнесийн зээлийн хувьд бол ерөнхийдөө сүүлийн саруудад яг энэ ААН-үүдэд олгосон хөрөнгө оруулалтын зээл ер нь харьцангуй өсөлттэй явж байгаа. Тэгэхээр өмнөх юун дээр энэ оны яг 6 сарын байдлаар ААН-үүдэд олгосон зээлийн өсөлт 17,6 хувьтай байгаа. Тэгэхээр өнгөрсөн жилийн хувьд бол жишээ нь энэ өсөлт бүүр 4, 5 хувьтай, зарим тохиолдолд өсөлтгүй байсан бол өнөөдрийн байдлаар бол харьцангуй өндөр өсөлттэй байгаа. Энэ дээр нэг нөлөөлж байгаа зүйл нь энэ ЗГ-аас хэрэгжүүлж байгаа хөдөө аж ахуйг дэмжих зээл энэ бусад татаастай зээлүүд бас нөлөө үзүүлж байгаа. Тэгэхээр энэ нь бас зэрэг чиглэлтэй үйлчилж байна л гэж харж байна.

**Ц.Даваасүрэн:** 3 дахь асуулт болохоор нүүрсийг биржээр явуулсан, энэнээс ер нь ямар зөрөө ашиг гарч байна вэ гэдгийг хэн хариулах юм бэ? 9 үү? 9.

**Б.Тэлмүүн:** Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн.

**Б.Тэлмүүн:** Өчигдрийн байдлаар нүүрсний экспорт бол 53,8 сая тоннд хүрсэн байна. Энэ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 39,6 сая тонн байснаас 36 орчим хувиар бол нэмэгдсэн байгаа. Яг биржийн нүүрсний арилжааг би тоог нь аваад танд жич тоог нь өгье. Яг одоогоор алга байна.

**Ц.Даваасүрэн:** 1 минут нэмж өгье. Аубакир гишүүний микрофоныг өгье, тодруулъя.

**Т.Аубакир:** Яах вэ нүүрсний арилжаа уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжаалахыг бид өнгөрсөн парламентаар болбол дэмжсэн л хүмүүсийн нэг нь л дээ бидний хувьд. Тийм учраас энэ элдэв худлаа статистик тоо өгөөд, нүүрсээ уул уурхайн

бүтээгдэхүүнээр биржээр арилжаалахаас ухарч бол болохгүй шүү дээ. Ухарч бол болохгүй. Тийм учраас бид нар нэг ажил хийчхээд, энэ ерөөсөө болдоггүй юм байна гээд хэрвээ ухрах юм болбол эсвэл ямар нэгэн энэ хөрөнгийн бирж дээр ямар нэгэн будилаан гарах юм болбол бид нар шууд хардана шүү. Энэ дээр яах вэ Сангийн яамныханд хэлчихэд.

Гаалийн ерөнхий газар байж байгаа юм байна. Энэ ер нь бүрдүүлэлт хийж байгаа процесстоо ер нь манай дотоодын хувьд, дэлхийн гаалийн байгууллагаас зөвлөгөө зөвлөмж өгдгийг болбол ойлгож байна. Энэ бүрдүүлэлт хийж байгаа процесстоо манайхан ер нь нэг мониторинг хийх ер нь бололцоо бий юу? Яагаад гэвэл маш олон төрлийн бараа таваар ороод ирдэг, тухай бүр дээр нь БТКУС-ийн кодоор жишээлбэл бүрдүүлэлт хийгээд яваад байгаа юм. Энэ нь өөрөө яг тэр татварыг оновчтой ноогдуулахад ер нь нэмэр болж чадаж байгаа юм болов уу? Тийм учраас энэ зүгээр асуулт бол биш шүү. Санал хэлж байгаа юм. Манай гаалийнхан маань энэ бүрдүүлэлт хийж байгаа процесстоо дахиад нэг мониторинг хийж өгөөд, манай энэ өөрөө импортлогч улсын энэ нэг онцлогт нь тохируулаад, 1 машин дээр 300 төрлийн нэр төрлийн бараа таваар ороод ирлээ гэхэд тухай бүр дээр нь БТКУС-ийн код уншуулж байгаа юм шиг мэт боловч яг яс юман дээр энэ яг тэгж бүрдүүлэлтээ хийж чадаж байна уу, үгүй юү? Энэ дээр бид нар бас нэг анхаарах ёстой нэг ийм зүйлүүд байгаад байгаа юм. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Энэ 1 минут нэмэхийг яагаад 3 минут нэмээд унав манайхан? 3 минут нэмчихсэн, та нэлээн удаан ярьчихсан сая бол. Би төгсгөлийн асуултыг асуугаад асуулт асууж дуусгачихъя. Сая нөгөө гишүүд бас үдээс өмнө хуралдахад асуугаад хариулт гүйцэд аваагүй зарим асуултаудыг нь би асуугаад ингээд та бүхэн тодруулчихъя. Тогтвортой байдлын зөвлөлөөс хүн ирчихсэн байна уу? Үндэсний аудитын

газрын хийсэн аудитын тайлангийн талаар та нар ямар байр суурьтай байна вэ гэдгийг хариулна. Тийшээ очоод суучих 1, 2 дугаар микрофоны тийшээ.

Холбоос, 2 дахь асуудал холбоос замын төслийн гүйцэтгэл гээд байгаа юм. Хотоос асууж байгаа. Хотынхон бас 1, 2, 3 тэр юу руу очоод суугаад байгаарай. Хэн Идэрцогт байж байгаарай. Идэрцогтоос нөгөө энэ дахиад л болчих гээд байна. Нөгөө ХАА-н түүхий эд боловсруулах хэдэн үйлдвэр баригдсан бэ гэж байна. Тэрийг давъя. Тавантолгой ХК-ийн авлага ямар, энэ дээр чинь нэг хариултгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр танай харин Зарлагын хяналтын дэд хороо дээр би эдний компанийг дууд гэсэн байгаа. Тэнд авчихъя тэгэх үү? Энийг бол тэгье. Ингээд саяын 4 асуултад, 3 асуултад хариулаадахъя. Эхлээд 2 номерын микрофон Энхбат, та нар энэнтэй ямар байр суурь, санал нэг байна уу? Ямар байр суурьтай байна вэ аудитын дүгнэлт?

**А.Энхбат:** Эрхэм гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Энхбат. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16<sup>1</sup>.5.3-ын дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бол Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан, улсын төлөвлөгөөний, улсын хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд дүгнэлт гаргах ийм үүрэгтэй. Энэ үүргийнхээ дагуу бид нар энэ ЗГ-ын санхүүгийн нэгдсэн тайлан болон улсын төсвийн 2023 оны гүйцэтгэлд бол дүгнэлтээ гаргаад, Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн байгаа.

Асуулт бол тодорхой байгаа. Үндэсний аудитын газрын аудитын дүгнэлттэй бол хэр санал нийлж байгаа вэ гэдэг асуултад товчхон хариулъя. Тэгэхээр ерөнхийдөө бид нар Үндэсний аудитын газраас ЗГ-ын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланд хийгдсэн аудитын тайланд дурдсанаар 5442 төсөвт байгууллага, төрийн өмчит 116

хуулийн этгээд, 370 төрийн сан, 295 төсөл санд бол аудитын тайланг санхүүгийн тайланг нэгтгэсэн байна лээ. Тэгээд ерөнхийдөө энэ Аудитын газрын Ерөнхий аудиторын орлогч Самбууням тэр үндэслэлээ бас тайлбарласан. Хязгаарлалттай дүгнэлт гэсэн гаргасан үндэслэлд байна лээ. Үндсэндээ өөрөөр хэлбэл Монгол Улсын 2022 оны ЗГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангийн 34 их наяд 674,5 тэрбум төгрөгийн нийт зардлын 1 хувиар нь тооцоод материаллаг байдлын алдааны түвшнийг бол 346,7 тэрбум төгрөгөөр тооцож, тэр үндэслэлээр үндэслэлүүдийг нь тодорхой бас тайлбарлаж байна лээ. Үндсэндээ нийтдээ 62 төсвийн ерөнхийлөн захирагч болон 6711 төсвийн захирагч, 3496 санхүүгийн тайланг бол нэгтгээд 2 их наяд 280,2 тэрбум төгрөгийн зөрчлийг илрүүлсэн юм байна лээ. Эндээс ингээд харахад бол өөрчлөлтгүй буюу.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Тэгвэл энэ Тогтвортой байдлын зөвлөл энэ төсвийн гүйцэтгэлтэй холбогдолтой хийсэн тайланг бас гишүүдэд тараагаарай. Холбоос зам төслийн гүйцэтгэлтэй холбогдолтой хотоос. 6 номерын микрофон өгье. Нэрээ хэлээд, албан тушаалаа хэлээд.

**Н.Мандуул:** НЗД-ын нэгдүгээр орлогч Мандуул байна. Даргын асуултад хариулъя. Энэ өнгөрсөн оны төсөв дээр тодотгол хийгээд, нийслэлийн энэ түгжрэлийг бууруулах чиглэлээр зарим хөрөнгө тавигдсан юм байна лээ. Яг тодруулбал нийслэлийн замын сангийн хөрөнгөөр гол болон туслах гудамж, зам, замын байгууламж шинээр барих болон шинэчлэлийн ажил нийт 168 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 58,5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 24 төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн. Гүйцэтгэл бол 85 орчим хувьтай байсан юм байна.

**Ц.Даваасүрэн:** Идэрцогт дарга ХАА-н түүхий эдийг боловсруулах хэдэн

үйлдвэр баригдсан бэ? Энэ оны хувьд асууж байгаа байх ер нь. 9 жилээ оруулаад ч яах вэ, ярья, номерын микрофон өгье.

**Л.Идэрцогт:** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Идэрцогт. Гишүүний өмнө тавьсан асуултад хариулъя. Шинээр байгуулагдсан үйлдвэр цехийн хэмжээнд 13 үйлдвэр цех байгуулагдсан байгаа. Энэ Сүхбаатар аймаг, Налайх дүүрэг, Сонгинохайрхан дүүрэг гэхээр мал төхөөрөх үйлдвэрлэл, мах боловсруулах үйлдвэр, сүү боловсруулах гэсэн ийм чиглэлийн үйлдвэрлэлүүд байна. Мөн хөнгөн үйлдвэрийн чиглэлээр 4 үйлдвэр, ноолуурын чиглэлийн 4 үйлдвэр байгуулагдсан. Мөн ХАА-н тоног төхөөрөмж нэмэгдэх ийм, үйлдвэрүүдийн тоног төхөөрөмж, хүчин чадлыг нэмэгдүүлэх энэ чиглэлээр бол 35 үйлдвэрийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэн ийм дүнтэй байгаа.

**Ц.Даваасүрэн:** Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, ЗГ-ын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлантай холбогдуулж гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байвал нэрээ өгье. Мөнхсоёл, Түвшин, 3 гишүүнээр тасаллаа. Ганхуяг гишүүн үгээ хэлье.

**Х.Ганхуяг:** Удахгүй сарын дараа 25 оны төсөв хэлэлцэж эхэлнэ. Тэгээд бид нар энэ төсвийн хяналтыг сайжруулах, ТӨК-удын засаглалыг сайжруулах, шилэн болгох мөн Улсын Их Хурлын 16 дугаар тогтоолын биелэлтийг бас ярилцах зайлиггүй шаардлагатай юм байна. ТӨК-удын талаас илүү хувь нь алдагдалтай ажиллаж байна, 500 гаруй тэрбум төгрөгийн алдагдалтай байна. Нийгмийн зорилго бүхий янз янзын ажлуудыг санхүүжүүлсэн байна. Янз янзын хардлага зэрлэг байхаар байна. 500 тэрбум төгрөгийг татвар төлөгчдийн мөнгөөр өнөөдөр бид нар алдагдлыг нь нөхөөд явж байна. Томоохон компаниуд нь бүгдээрээ



ер нь банкны үйл ажиллагаа явуулдаг болсон байна. 2,7 их наяд төгрөгийн зээл өгсөн байна, ТӨК бусад ТӨК-уддаа. ЖДУ сан гээд 58 хувь нь муу зээлийн ангилалд орчихсон байх жишээний. Тэгэхээр энэ 25 онд төсвийг өргөн барихдаа ЗГ-ын тусгай сангуудын хуулийг шинэчлэх, муу, хуулиар журамлаагүй сангуудаа нэг бол татан буулгах, нэг бол хуулийг нь оруулж ирэх зайлиггүй шаардлагатай байна. Байнгын хорооны даргаа та энэ дээр нэг онцгой анхаарал хандуулмаар байна.

Мөн зарим нөхдүүд өнөөдрийн асуулт, хариулт дээр бол илт худлаа ярьж орж ирж байна. Их Хурлыг бол хүндэтгэхгүй байна. Би маш тодорхой асуусан. Чингис хаан банкин дээр хэдэн төгрөг байршуулсан байгаа вэ гэхээр зөвхөн 2 сангийн мөнгийг ярьсан байгаа. Тэгээд энэ чинь бүүр 2011 оноос хойш удаа дараа энэ банкин дээр мөнгө байршсан байна. Одоо гэхэд тэр муу авлагаас гадна дахиад 200 гаруй тэрбум төгрөг байршсан байна гээд энэ аудитын тайлан дээр байна. Би тэрийг нь уншиж арай амжаагүй байсан байна. Нөгөө яаралтай горимоор орж ирсэн болохоор. Тэгээд илт өнөөдөр өглөө энд сууж байгаад худлаа ярьсан. Тэгээд яг ийм хүмүүс дээр ямар хариуцлага тооцох ёстой юм бэ? Хариуцлагыг нь тооцож өгөөч гэж Байнгын хорооны даргаас бас хүсэх гэсэн юм.

Мөн анхан шатын баримтгүй, бүрдэл дутуу гээд 243 тэрбумын асуудал байна. Хөрөнгийн тооллогод хамруулаагүй биетээрээ байхгүй гээд 803 тэрбум төгрөгийн акт гарсан байна. Энийг юу гэж ойлгох вэ? Энэ чинь гараад 1 их наяд төгрөгийн асуудал байна шүү дээ. Өнөөдөр бид нар ЭМД дээр мөнгө байхгүй гээд сууж байна. Нийгмийн даатгал, нийгмийн даатгал төлөгч нартаа өртэй гээд сууж байна. 1 их наяд төгрөгийн хөрөнгө алга болчихсон. Энэ дээр ер нь яг ямар арга хэмжээ авах ёстой юм бэ? Энэ дээр энэ татвар төлөгчдийн мөнгө уйлахгүй гэж ерөөсөө энэ бол арай л дэндэж байна даа ер нь. Тэгээд энэ

Төсвийн зарлагын хяналтын дэд хороог хуралдахдаа энэ асуудлуудыг та тодруулж өгмөөр байна.

Мөн энэ бүх юмны эзэн энэ хууль хэрэгждэггүй энэ банкны эздийг нь тодруулж өгмөөр байна. Тэр татвар төлөгчдийн мөнгийг буцааж авч өгмөөр байна. Мөн худал мэдээлэл өгөөд суугаад байгаа энэ эрх бүхий энэ нөхдүүдийн энэ хариуцлагыг өндөрдүүлэх, хариуцлага тооцох асуудлыг Байнгын хорооны даргаас бас хүсэж байна.

Зөвхөн ЗГ-ын тусгай сангуудтай холбоотой яам болгон дээр олон жилийн насжилттай авлагатай болсон байна. Авлагатай, мөнгөө авч чаддаггүй, муу ангилалд орсон. Жишээлбэл Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам 146 тэрбум, Хүнс, хөдөө аж ахуйн яам би нөгөө Тариалан эрхлэлтийг дэмжих санг оруулахгүйгээр 99 тэрбум, ингээд 25 сан дээр манай яамнууд маань, сайд нар маань сайхан журам гаргаад, мөнгө зээлээд.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Ганхуяг гишүүн нэлээн чухал асуудлууд хөндлөө. Тийм учраас энэ яригдаад байгаа банк, банкин дээр байгаа чөлөөлөлт үлдэгдэл, нэмж байршуулсан асуудал энэ тэр нэлээн Зарлагын хяналтын дэд хороон дээр бас нэлээн дэлгэрэнгүй тодорхой ингэж ярья. Тэгээд холбогдох албан тушаалтнуудыг оролцуулъя. Эрдэс, Эрдэнэс Монгол, Эрдэнэс Тавантолгой компанийн удирдлагуудыг оролцуулъя. Тэгээд энэ нөгөө нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын газрын удирдлагуудыг оролцуулъя. Монголбанк, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хариуцлагатай албан тушаалтнууд оролцъё. Ийм улсууд оролцъё.

Ер нь худал мэдээлэл өгөх юм болбол Дэгийн тухай хуулийн 13.1.12 хуралдааны дэг зөрчсөн энэ хуульд заасан арга хэмжээ авна гэж байгаа юм. Энэ хуульд ямар арга хэмжээ байгаа юм. Улсын Их Хурлын тухай хуулийн 21.25-аар

чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, өнөөдөр хүрэлцэн ирээгүй улсууд бий шүү. Тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн, санаатайгаар худал мэдээлэл өгсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай хууль болон бусад хуульд заасан хариуцлага хүлээнэ гэсэн ийм заалтууд байгаа учраас саяын Ганхуяг гишүүний асуусан асуултад үндэслэлгүйгээр худал мэдээлэл өгсөн ийм юу байх юм бол манай Тамгын газрынхан, хуулийнхан надад гаргаад өгчих. Тэгээд энэ хуулийн дагуу нь холбогдох арга хэмжээг авхуулъя. Мөнхсоёл гишүүн үгээ хэлье.

**Б.Мөнхсоёл:** Гол асуудлыг л хэлье гэж бодож байна. 1 дүгээрт нь болохоор энэ томоохон мега төслүүдийг хэрэгжүүлнэ гэж байгаа. Төсвийн сахилга баттай холбоотой хэд хэдэн асуудлууд бас өдөр дараалан хөндөгдсөн. Тэгэхээр энэ дэд бүтцийн шинжтэй том төслүүдэд ямар ч байсан зардал үр ашгийн тооцооллыг маш сайн хийдэг болмоор байна. Энийг бол санал болгож бас хэлж байна. Энэ биелээгүйгээс бас эдийн засгийн, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яамнаас төсөвт оруулах төслүүдээ эрэмбэ дараатай оруулах энэ ажил бас нэлээн хөшүүн хойрго байгаа нь ажиглагдаад байгаа. Энд нөлөөлөөд байна гэж хэлмээр байна.

2 дугаарт нь бид нар мэдэж байгаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын хувьцаа эзэмшигчдийн эрхийг хангуулах ёстой. 9 субъект байгаа. Тэр нь яамнууд өөрсдөө байгаад байна. Тэгэхээр энэ дээр бас нэг яг бодлогоор зангидах ёстой энэ яамнууд нь өөрөөр хэлэх юм бол төрийн өмчид ч бай, хувийнх ч бай ялгаагүй харьцах ёстой энэ байгууллагууд ийм оролцоотой байхаар яг хяналт хариуцлагын асуудал яг бодит амьдрал дээр хэрхэн оновчтой хэрэгжих вэ гэдэг дээр асуудал хөндөгдөж байна. Тэгээд энэ дээр бас Улсын Их Хурал бас эрх зүйн орчныг

сайтар бүрдүүлэх дээр ажиллах ёстой юм болов уу. Ийм байдлаас шалтгаалаад бас 2023 онд төсөвт жишээлбэл ноогдол ашгийн тал хувийг, Ирээдүйн өв сангийн ¼ хувийг орлого бүрдүүлж чадаагүй. Энэ дээр бас сөрөг нөлөөлсөн ийм асуудлууд байна.

Тэгээд цаашидаа энэ ТӨК-удын засаглалыг сайжруулах, ялангуяа төрийн өмчит зарим компаниудыг хувьцаа гаргах замаар олон нийтийн болгох гээд энэ асуудлууд бас шийдэгдэх хэрэгтэй. 2022-оос 23 онд Төрийн Үндэсний аудитын газраас ийм зөвлөмж өгч байсан, хэрэгжээгүй гэх мэт асуудлууд байна.

Тэгээд өчигдөр бас чуулган дээр хэлсэн. Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 60,9 байна уу, 5-хан хувьтай гэж гарсан байсан шүү дээ тайлан дээр бичигдсэн байна лээ, 8 дугаар бүлэг дээр. Тэгэхээр энэ дээр бас анхаарах ёстой. Уг нь болбол улс орнуудад Үндэсний Аудитын газар чинь маш их нэр хүндтэй, тэгээд эргээд хяналт хариуцлагын checked balance ч гэж ярьдаг энэ асуудал дээр маш их нөлөө бүхий байх ёстой. Энэ нь бодит амьдрал дээр Монгол Улсын хувьд хэрэгжихгүй байна, бие даасан байдал нь хангагдахгүй байна гэж харж байна. Товчхондоо ийм байна. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Түвшин гишүүн үгээ хэлье.

**Б.Түвшин:** Ер нь болбол ойрын үеийн хэлэлцэж байгаа асуудлууд их яаралтай байгаа учраас товчхон, товчхон дүгнэлтүүдээ хэлээд л явчих юм шиг байна. ЗГ-аар ч бай, парламент ч бай мэргэжлийн түвшинд ажиллах, ер нь илүү тийм суурьтай ажиллахгүй болбол энэ аудитын дүгнэлт, тогтвортой байдлын зөвлөл гээд харьцангуй ийм мэргэжлийн байгууллагуудынхаа зөвлөмжийг авахгүй, сэтгэл хөдлөл, эмоци, эсхүл өөрийн хувь хүнийхээ туршилага дээр суурилсан байдлаар бодлогуудыг явуулж байна л даа.

Сүүлдээ энэ аудитын болон Тогтвортой байдлын зөвлөлөөс гаргаж байгаа дүгнэлтүүд нь Их Хурлаас гаргасан тогтоолууд өөрчлөхөд түүнд нийцүүлэн гаргадаг байдлаар хувьсдаг. Монгол Улсын эдийн засаг, төсөв, санхүүгийн байдал 5, 10 жилээр төлөвлөх нь битгий хэл жил жилдээ өөрчлөгдөөд, алдаа, оноо алдагдлаа хүлээн зөвшөөрөөд явчихдаг.

Дээрээс нь хариуцлага тооцдог болохоор энэ тайлангуудыг хэлэлцдэггүй учраас энэ холбогдох дарга нар нь ирдэггүй. Тийм учраас Их Хурал өөрөө хүчирхэг байхын тулд, Их Хурал өөрөө тогтвортой, мэргэжлийн байхын тулд энэ Их Хурлаас байгуулсан байгууллагуудаа илүү чадавхжуулж, илүү мэргэжлийн болгож ажиллах зайлиггүй шаардлагатай байгаа нь эндээс харагдаж байгаа юм.

Тогтвортой байдлын зөвлөлийн гаргасан шийдвэрүүдийг бид нар тогтвортойгоор дагаж мөрддөг. Түүнд мэргэжлийн хэлэлцээ өрнүүлдэг байх шаардлагатай байна. Үндэсний аудитын газраас гаргаж байгаа зөвлөмжүүдийг хэрэгжүүлдэг, гүйцэтгэлийн аудит дээр гаргасан дүгнэлтүүдийг тасралтгүй хэрэгжүүлдэг, хэрэгжүүлэлтийг нь хангадаг тэр эрх мэдэл болон хүчин чадал, боловсон хүчний чадавхыг нь, дээрээс нь тэр төсөв, үйл ажиллагааг нь дэмжиж, хараат бус байдлыг нь хангаж өгөхгүй болбол баахан дүгнэлт хийдэг, баахан ажил гарч ирдэг. Эргээд өнөөдөр бид нар яаралтай ЗГ-ын захиалгаар ч юм уу, яаралтай дүгнэлт өгөөд, ингээд хэлэлцсэн болгоод дуусгадаг.

Тийм учраас Их Хурлыг мэргэжлийн болгох, мэргэшсэн болгох, тууштай тогтвортой явуулах энэ бодлого дээр Их Хурлаас байгуулж байгаа байгууллагуудаа тогтвортой тууштай дэмжиж явуулах хэрэгтэй байгаад байгаа юм. Үнэхээр энэ Үндэсний аудитын гаргаж байгаа дүгнэлт дээр маш тийм

том байдлаар болбол бид нарын явуулж байгаа бодлого нийгэм, эдийн засагт нөлөөлж байгаа нөлөөлөл, энэ татвар цуглуулах байдлыг болбол тодорхой дүгнэснийг бид нар хэрэгжүүлэх асуудал дутаад байна. Энэ дээр хийж байгаа нэг том сүүлийн үеийн асуудал болбол ТӨК, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудаар дамжуулж төсвийн бус баланс гаргадаг. Төр өөрөө өөртөө зах зээлээ үүсгэчихсэн. Өөрөө нийгэм, эдийн засгийн бодлого явуулах биш, төр өөрөө өөртөө бодлого явуулсан хэмжээний ингэж данхайсан байгаа нь харагдаж байна л даа. Өөрийн гэсэн банкттай болж, өөрийн гэсэн ААН-үүдтэй, өөрийн гэсэн хүмүүстээ л эргэдэг. Эргээд энэ төрийн гаргаж байгаа, явуулж байгаа нийгэм, эдийн засгийн бодлого нийгэм рүү, олон түмэн рүү биш төрийн хамаарах байгууллагууд руу л хүрэх хэмжээнд хязгаарлагдах.

Цаашидаа төр гээд нэг ийм нийгмийн томоохон бүлэг секц үүсэх учраас энэ ТӨК-удыг илт багасгах, нэгтгэх, нийлүүлэх, олон нийтийн хяналтад оруулах. Төр бол өөрөө маш цомхон хэлбэрээр татвараа цуглуулаад, нийгэм, эдийн засгийн тогтвортой бодлого явуулах дээрээ чиглэхгүй болбол төрийн үйл ажиллагааны 70, 80 хувь мөнгө угаах эрсдэл нь өөрөө ААН рүүгээ чиглээд, төр өөрөө ААН-ийн үйл ажиллагааг 70 хувьтай эрхэлдэг. Нийгэм, эдийн засаг руу явуулах бодлогын ажил нь өөрөө 10-аас 30 хувийн хэмжээнд хязгаарлагддаг болсон байна. Тийм учраас энэ аж ахуйн үйл ажиллагаануудыг төр бодлогоор удирдах болгож тэрийг тэр хувийн салбарууд руу шилжүүлж, төр өөрөө хүчирхэг, цомхон бодлогын байгууллага болох зайлиггүй шаардлагатай байгааг эндээс харуулж байна. Тийм учраас энэ удаагийн Үндэсний аудитын газрын зөвлөмж болгоныг хэрэгжүүлэх, тасралтгүй байнгын тогтолцоог хэдүүлээ бүрдүүлж ажиллах зайлиггүй шаардлага байна.

**Ц.Даваасүрэн:** Гишүүд үг хэлж дуусаж байна. Тэгэхээр энэ дараагийн хуралдаан үргэлжлээд Зарлагын хяналтын дэд хороо дээр явагдана. Тэгэхэд түрүүний миний хэлсэн нэр бүхий албан тушаалтнууд ирж оролцоно. Би түрүүн Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хуулийг хэллээ. Саяын нэр дурдсан албан тушаалтнууд хүндэтгэх шалтгаангүйгээр ирэхгүй бол Ганхуяг гишүүний хэлсэнчлэн хуулийн дагуу хариуцлага тооцож эхэлнэ гэдгийг албан ёсоор хэлье.

Тэгэхээр энэ төсвийн гүйцэтгэл, энэ төсвийн тодотгол, төсөвтэй холбогдолтой гарч байгаа дүгнэлтүүд аудитынх, тогтвортой байдлынх маш тодорхой, ойлгомжтой байх ёстой. Нэг талыг барьж болохгүй. Яагаад гэвэл нийгэмд янз бүрийн ойлголт төрүүлэх аюултай. Сая жишээлбэл тодотгол дээр явж байгаа Тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг нэг талаас нь тайлбарлаад хаячихлаа шүү дээ нийгэмд. Зардал талдаа өр зээлээ бүртгэхгүй болж байгаа юм байна гээд. Тийм юм байхгүй. Төсвийн тогтвортой байдлын хуулийн 19.9-д төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 25 оноос хойш -2 хувиас хэтрэхгүй гэж байж байгаа юм. Тэнцвэржүүлсэн тэнцэлд эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүнгээрээ зардал талд суудаг хэвээрээ байгаа. Тийм учраас зардал хязгааргүй өсөөд л, өр зээл хязгааргүй ингээд явчих юм огт байхгүй.

Төсвийн тогтвортой байдлын хуулийн 4 тусгай шаардлагын 1 болбол өрний хэмжээ ДНБ 60 хувиас хэтрэхгүй. Энэ тусгай шаардлага байж байгаа. Гэтэл энэ бүгд байхгүй болчихсон юм шиг ийм ойлголт нийгэмд явчхаж байна шүү дээ. Тийм учраас энэ гаргаж байгаа дүгнэлт, зөвлөмжүүд энэ тэр бол бас их тодорхой, нэг талыг барихгүй ингэж явахгүй болбол нийгэмд буруу ойлголт өгөх бас аюултай. Нийгэм ямар зүйлийг их сонирхдог болчихсон байна гэвэл буруу юмыг их хүлээж авдаг болж. Буруу аюултай гэвэл зүгээр уухайн тас тэгээд л

ерөөсөө чих нь дэлдийгээд л сонсдог, зөв гэдэг юм уу аль эсвэл зарчмаараа явж байна гэвэл сонсдоггүй. Тийм учраас энэ гаргаж байгаа зөвлөмж, дүгнэлтүүд дээр нэлээн анхааралтай хандаж байхгүй болбол буруу талаас нь харах хандлага илүү байна гэдгийг бас анхаараарай гэдгийг би хэлье. Тэгээд энэ төсвийн гүйцэтгэлтэй холбогдолтой гарсан зөвлөмжүүдийг бас гишүүдэд хүргүүлнэ.

Ингээд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлантай холбогдуулж гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурал тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Төсвийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурал гишүүн Б.Заяабал Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулна. Заяабал гишүүн Зарлагын хяналтын хорооны гишүүн учраас.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурал тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Баярлалаа гишүүд, ажлын хэсэгт. Заяабал гишүүн уншина шүү.

16.13 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА



